

ЭРХ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ОНОЛ,
АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ

ШИХИХУТУГ

1/2001

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН АСУУДЛУУД

Эрхэм уншигч танаа

Тус сэтгүүлийн түрүүчийн дугааруудаас уншигч аругай та Төр, эрх зүйн онол, түүх, Үндсэн хуулийн эрх зүй, Захиргааны эрх зүй, Иргэний ба Иргэний эрх хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн онол, практикийн нэлээд асуудлыг уншиж танилцсан. Энэ дугаарт Эрүүгийн эрх зүйн асуудал зонхилж байгаа юм. Өдгөө тус улсад эрүүгийн нөхцөл байдал хүндэрч, ард иргэд сэтгэл зовинон, ял шийтгэлийг чангалах, шүүх, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг чанд мөрдөхийг шаардаж байна. Энэ бол зүй ёсны хэрэг гэдэг нь нэгэнт тодорхой.

Гарсан хэрэг бүрийг илрүүлдэг, түүнд нь тохирсон ял зэмлэл, цээрлэл хүлээлгэдэг байх нь хууль ёс, зүй ёс, шударга ёс, хүндэг энэрэнгүй ёсны ялалт байдаг. Энэ нь дараа дараагийн гэмт үйлдлээс урьдчилан сэргийлэх нэг нөхцөл нь болдог.


Ер нь гэмт хэрэгт ял шийтгэл ногдуулах нь нэг хэрэг, хамгийн гол нь гэмт явдал үйлдэгдэн гарч буй шалтгаан нөхцөлийг арилгах л чухал юм. Иймд бид дараагийнхаа дугаарын энэ чиглэлд хандуулах болно гэдгээ хэлэх байна.

УИХ-ын 2001 оны хаврын чуулганаар Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн төсөл хэлэлцэгдэх гэж буй энэ үед судлаачдынхаа энэ чиглэлээр бичсэн өгүүлүүдийг толилуулж байна.

Болгоон соёрхоно уу.

Ерөнхий редактор

Данзангийн ЛҮНДЭЭЖАНЦАН



ТӨРИЙН ЭРХ МЭДЭЛ ХУВААРИЛАХ ҮНДСЭН ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Данзангийн ЛҮНДЭЭЖАНЦАН

Хууль зүйн шинжлэх ухааны доктор

Эрх зүйн сэтгэлгээ, тэр тусмаа Үндсэн хуулийн эрх зүйн онолын нэн чухал ололт, нийтээр хүлээн зөвшөөрсөн үнэт зүйлд төрийн эрх мэдлийг хуваарилах онол зүй ёсоор орно.

Монголчууд бидний хувьд төрийн эрх мэдэл хуваарилах хэмээх ухагдахууныг 1980, 90 оны зааг дээр Монгол улсын шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлал боловсруулсан үеэс хэрэглэх болсон юм.

Гэхдээ төрийн эрх мэдлийг хуваарилах асуудлыг авч үзэхэд "эрх мэдэл хуваарилах" болон "засгийн эрх мэдэл хуваах" гэсэн ойлголт, төрийн эрх мэдэл хуваарилах онол, зарчим гэх мэт утга санааг түүнд шингэсэн өнгө аясыг илэрхийлдэг олон нэр томъёог жигдлэх, нэг мөр ойлгох шаардлага зайлшгүй гарч ирнэ.¹ Монгол Улсын Үндсэн хуулийн "Төрийн байгуулал" гэсэн бүлэгт хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын асуудлуудыг эрх мэдэл хэмээн шууд томъёолоогүй бөгөөд харин шүүхийн байгууллагын тухайд "Шүүх эрх мэдэл" хэмээн тодорхойлжээ. Энэ нь төрийн эрх мэдлийг хуваарилан авч хэрэгжүүлэх хэлбэрүүдийг бие даасан тус тусдаа гурван засаг гэсэн ойлголтод хүрэхээс сэрэмжилж, "Эрх мэдэл" гэсэн нэр томъёон дээр үндсэндээ тогтсоныг харуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн төслийг ард түмнээр хэлэлцүүлэх болон мөн түүнийг байнгын ажиллагаатай хууль тогтоох байгууллага-Улсын бага хурал, төрийн эрх барих төлөөллийн дээд байгууллага-Ардын Их Хурлын хуралдаанаар хэлэлцэх явцад дээрх нэр томъёоны асуудал нэг бус удаа сөхөгдөж байв.

Эдгээрээс үндэслэн төрийн эрх мэдлийн хуваарилалтын асуудлыг авч үзэхдээ энэ талаарх сонгодог онол, сургаал, зарчимд нийцүүлэн, тус улсын хууль тогтоомжид тодорхойлсон "төрийн

¹ Эрх мэдэл хуваарилах гэдгийг оросоор Разделение властей, германар Die Gewaltenteilung ангилар Separation of power хэмээнэ.

эрх мэдэл", "төрийн эрх мэдлийг хуваарилах" гэсэн томъёоллоор авч үзэх нь зүйтэй гэж үзэж байна. Учир нь улсын дотор төр нь нэгдмэл байх ёстой.

Энэ талаар манай эрдэмтдийн туурвисан ном, зохиолд ч "эрх мэдэл хуваарилах" гэсэн ойлголтыг хэрэглэх нь манай Үндсэн хуулийн агуулгад илүү нийцнэ хэмээн тэмдэглэжээ.² Учир нь засгийн эрх мэдэл бол ард түмний мэдэлд байдаг учир нэгдмэл байдлаар нь авч үзэх үндэслэлтэй юм. Харин тодорхой эрх мэдэл эдэлж, энэхүү итгэмжлэлтийг ард түмнээс олсон байгууллагууд өөрт ногдсон эрх мэдлээ хэрэгжүүлж болох юм" гэж үзсэнд ач холбогдол өгч байна.

Үндсэн хуульд "эрх мэдэл хуваарилах" гэдэг нэр томъёогоор орсон эл зарчим нь зарим судлаачдын үздэгээр Монгол орон "гурван засаг" буюу "засаглал"-тай болчихоод байна гэсэн утгатай бус, харин Парламентын Бүгд Найрамдах засагтай нэгдмэл төрийн эрх мэдлийг, өөрөөр хэлбэл төрийн эрхэлж хэрэгжүүлдэг ажил / "чиг үүрэг", "эрх хэмжээ" улмаар түүний гол агуулга болсон бүрэн эрх /-ыг төрийн харьцангуй бие даан салаалсан гурван төрлийн байгууллагад хуваарилан харууцуулж хооронд нь харилцан хамаарал, хяналт, тэнцэлтэй болгох гэсэнд гол зорилго оршино.¹ Төрийн эрх мэдлийг зүгээр л нэг хуваарилхын тулд, эсхүл хэн нэгний ажил үүргийг хөнгөвчлөх үүднээс хуваарилсан хэрэг огт биш. Хамгийн ерөнхий утгаараа бол нэгдмэл төр цаашаа хөгжиж дэвшихийн тулд дотроо ажил үүргийн хувьд зааглал, ялгаралд орох хэрэгтэй байлаа. Нөгөөтэйгүүр төрийн эрх мэдлийг хуваарилах нэг шалтгаан бол түүнийг ухаалгаар ашиглах баталгаа бий болгохтой холбоотой.

Хүн төрөлхтөн төрийн бүх эрх мэдэл удирдлагын нэг субъектын гарт төвлөрөх янз янзын хувилбарыг туулж өнгөрүүлсэн. Түүхийн зарим нэг онцгой агшныг эс тооцвол эрх мэдлийн хэт төвлөрөл / монополчиллол / зохистой болохоо харуулж, өөрийгөө зөвтгөж чадаагүй юм.

Засаглалын илүү оновчтой хэлбэрийг сонгож авах зам мөр

² Энэ тухай Ц.Сарантуяа, Төрийн ерөнхий онол, УБ.1998, 129-135 дөхь тал.

Н.Лундэндорж, Төрийн онол, УБ.1997, 55-66 дөхь талд тус тус үз.

¹ Б.Чинд. "Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн үхэл баримтлал" 15 дөхь тал.

бартаатай байсан ч хүн төрөлхтөн алдаа оноогоо дэнсэлсээр эцсийн эцэст төрийн эрх мэдлийг тодорхой субъектуудын хооронд, нэг нэгнийхээ үйл ажиллагааг харилцан хянаж байхуйцаар тэнцвэр бариулан хуваарилах болсон нь эрх зүй, төрийн онол, сэтгэлгээний нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үнэт зүйл яах аргагүй мөн.

Базаж дүгнэвэл төрийн эрх мэдлийг хуваарилснаар хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөний баталгааг хангах эрх зүйн хийгээд бүтэц, зохион байгуулалтын механизмыг бий болгох бөгөөд хүний эрх, эрх чөлөөг хөндөх эрх бүхий төрийн засаглалын байгууллагыг харилцан тэнцвэртэй орших, бие биеийн хэрэгт үл оролцох, харилцан бие биенээ хянах тогтолцоонд оруулна гэсэн хэрэг мөн.

Энэ тогтолцооны давуу нь төрийн эрх мэдлийг хэн нэгнээс ард олны эсрэг сөргүүлэн тавих явдалд хаалт болохоос гадна, төрийн эрх мэдлүүдийн харьцангуй бие даасан байдлыг хангаж, оногдсон чиг үүргээ мэргэжлийн өндөр түвшинд өгөөжтэй гүйцэтгэх боломж олгодгоор илэрдэг.

Төрийн эрх мэдлийг хуваарилснаар түүнийг хэрэгжүүлж буй аль нэг институтын хүсэл зориг дангаар ноёрхох бололцоог хааж, хуулийг зөвхөн иргэний төлөөллийн байгууллага тогтоож, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага хэрэгжүүлж, хууль зөрчиж гажуудсан эсэхийг зөвхөн шүүх шийдвэрлэж байх бололцоо бүрдэнэ.

Өрнөдийн эрдэмтэд тэдний дотроос Германы болон Оросын Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухаанд төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг гол төлөв эрх зүйт төртэй холбон авч үзсэн байна.² Тэдний үзэж буйгаар *төр хүний эрх, эрх чөлөөг хэр хамгаалж, хангаж байгаагаар төрийн эрх мэдлийг хуваарилах шаардлага* тодорхойлогдоно. Төрийн эрх мэдлийг хуваарилах нь

² Мюнхений их сургуулийн профессор Peter Badura, Staatsrecht, Systematische Erläuterung des Grundgesetzes für die Bundesrepublik Deutschland, 2. Auflage, München, 1996, s. 47-48. Мюнхений их сургуулийн профессор, T. Maunz, Эрланг-Нюрнбергийн их сургуулийн профессор R. Zippelius нарын Deutsches Staatsrecht 29. Auflage, München, 1994, s. 86-87. М.В.Баглай, Конституционное право России, М., 1997, с. 115, Г.Н.Манов, Теория права и государства, М., 1995, с.83-85. Түүнчлэн манай ном зохиолд тухайлбал Н.Лүндэндорж "Төрийн онол" УБ, 1997, 65-66 дахь талд тус тус авч үзжээ.

төрийн хөгжлийн нэлээд боловсронгуй шатны үзэгдэл бөгөөд эрх зүйт төрийн орших бодит нөхцөл нь болж өгнө. Тодруулж хэлбэл, эрх зүйт төрийн бусад үндсэн нөхцөл, зарчмыг хэрэгжүүлэх боломж гэлтэй. Энэ нь төрийн эрх мэдлийг хуваарилах үндсэн шаардлага болон тавигдана. Эл шаардлага нь *нэгдүгээрт*, эрх зүйн хэм хэмжээ ардчилсан аргаар, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн оролцогчоор / субъектээр /, зөвхөн хуулиар тогтоогдох; *хоёрдугаарт*, Засгийн газар эрх зүйн хэм хэмжээ тогтоохгүй, харин хуулийг хэрэгжүүлэн биелүүлэх ажлыг эрхэлдэг байх; *гуравдугаарт*, Шүүх нь хуулийг хэрэглэх ёстой. Тодруулж хэлбэл хууль зөрчсөн тохиолдолд шүүх хариуцлага тооцно. Төрийн эрх мэдлийг хуваарилах эдгээр зарчим нь эрх зүйт, Үндсэн хуульт төрийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны үндэс болдог.¹

Доктор Ж.Амарсанаа: "Төрийн эрх мэдэл хуваарилах сонгодог утга гэж байхгүй болов уу. Энэ талаар дэлхий даяар дагаж мөрдөх нэг стандарт байхгүй. Бид Америкаас нэлээд иш татаж авч байна. Америк бас эрх мэдэл хуваарилах эталон биш. Тэр ч утгаараа Монголын хөгжлийн жишиг биш. Энэ бол хүн өөрийнхөө эрх ашгийн төлөө эдсэн хүний бүтээл. АНУ-д харьцангуй түрүүн бодож олсноороо ялгаатай. Яагаад эрх мэдлийг хуваарилах болов гэдгийг тунгааж үзэх учиртай. Төрийн дарангуйлал, дарамтад олон зуун жил байсан хүн маань байгалиас заяасан, язгуур салшгүй унаган төрөлх эрхээ эдлэхийн тулд өөрийнх нь эрхийг хязгаарлан барьж байдаг бат цул төрийн хар хүчийг хувааж задалснаар тэрхүү эрхээ бүрэн эдлэх боломжтой болж байгаа хэрэг. Ингэснээр хүн, төр хоёр дээрээс доош чиглэсэн харилцаанд байснаа ижил түвшний харилцаанд, нэг үгээр хэлбэл тэгш харилцаанд орж ирж байгаа юм. Ямар ч байсан сүүлийн үед Үндсэн хуулийн эрх мэдлийг хуваарилахтай холбоотой асуудлууд сүрхий хөдөлгөөнд орж байна. Энэ нь Үндсэн хуулийн тодорхой заалтын ололт, ялалтыг олж харах, нэг мөр ойлгох, цаашид төгөлдөржүүлэхэд хэрэгтэй юм."² хэмээн тэмдэглэжээ.

¹ С.Томар, "Эрх зүйт төр: Мөн чанар, чиг үүрэг, механизм" Шинэ толь. 1994. № 3.

² Монгол Улсын Үндсэн хууль төрийн эрх мэдлийг хуваарилах зарчим, Дугуй ширээний арилшлага. Монголын мэдээ. 2000. 1. 13. № 250.

Доктор Т.Сэнгэдорж : "Төр бүх эрх мэдлээ ганцаар төвлөрүүлэх нь төдийлөн зохистой бус. Гэхдээ гол гол эрх мэдлээ өөртөө хадгалаад хөгжлийн тодорхой шатанд зарим нэг чиг үүргээ төрийн бус байгууллагад оновчтойгоор шилжүүлэх асуудлыг цаашид бодож үзэх байх. Гэхдээ үүнийг хэт яарч болохгүй. Төр өөрөө оршин тогтнохын тулд чиг үүргээ сарниулж болохгүй нь мэдээж. Үндсэн хуулийн амин гол сүнс болох төрийн эрх мэдэл хуваарилах асуудал зарчмын хувьд зөв чиглэлтэй тусгалаа олсон боловч бодож боловсруулмаар зүйл байгааг үгүйсгэх аргагүй. Энэ асуудлыг онол, практикийн талаас нь шинжлэх ухааны үүднээс судлан үзэх нь чухал байна."¹ гэснээс үзэхэд Монголын эрдэмтэд эрх мэдэл хуваарилах зарчим, түүнийг илэрхийлсэн нэр томъёон дээр санал нэгдэж байгаа нь илт байна.

Зарим судлаачид төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг төрийн чиг үүргийн талаас нь голлон авч үзсэн байдаг. Өөрөөр хэлбэл, институциональ талаасаа буюу засаглалын эрх мэдэл биежсэн, бодит илрэл төр болох учраас засаглал, засаглалын институт, засаглалын өндөрлөгийн тухай ярихаас гадна төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч институт болох Парламент, Засгийн газар, Шүүх гэсэн төрийн бодит засаглалын байгууллагын бүрэн эрхийн тухай асуудлыг авч үзэх ёстой гэж үзэж байна. Иймд *функциональ* буюу чиг үүргийн талаас асуудлыг хөндөх нь институтын хувьд авч үзэхээс илүү нарийн төвөгтэй бөгөөд эрх мэдлийн онолын хөгжлийн нэгэн чухал чиглэл болж байна.

Эцсийн дүнд төрийн байгууллагын салаа, түүний нэгж хуулиар ногдуулсан "өөрийн" ажлыг хуулиар олгосон эрх хэмжээний дотор, хуульд заасан арга хэрэгслээр бие даан хариуцдаг тогтолцоо бий болгох нь нэн чухал. Ямар ч нөхцөлд эрх мэдлийн салаа мөчир бүрт ногдсон бүрэн эрх, чиг үүргийг догматик хандлага, загварчилсан байдлаар бус харин цаг үедээ нийцэн шинэчлэгдэж өөрчлөгдөх тогтолцоо гэж үзэх ёстой юм. Өөрөөр хэлбэл, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл гэдэг нь "урьдынхаас" ялгаатай. *Аливаа ардчилал хөгжсөн төр улсад хууль тогтоох, түүний гүйцэтгэлийг хангах / гүйцэтгэх /, хамгаалах / шүүх / гурван чиг үүрэг зайлшгүй бөгөөд түүнийг гурван салаа бүхий*

¹ Мөн тэнд.

бүтэц эрхэлдэг байх ёстой гэдгийн цаана эрх мэдэл хуваарилалтын гол агуулга оршино гэдэгтэй бид санаа нийлж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд хууль тогтоох эрх мэдлийг Улсын Их Хурал, гүйцэтгэх эрх мэдлийг Ерөнхийлөгч, Засгийн газар, түүний байгууллагууд, шүүх эрх мэдлийг шүүх, Үндсэн хуулийн цэцийн хүрээнд аль нэг хэлбэрээр "байцаан шийтгэх" ажиллагаа эрхэлдэг байгууллага хэрэгжүүлэхээр тусгасан билээ.¹ Ийнхүү төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл, тэдгээрийг хэрэгжүүлэх арга, хэлбэр, эрх хэмжээний нийтлэг ба онцлог шинж, хоорондынх нь харилцаанд баримтлах зарчим, үндсэн чиглэл зэргийг Монгол Улсын Үндсэн хуулиар хуульчлан тогтоосон. Тэгээд ч Үндсэн хууль нь төрийн хамгийн дээд хууль зүйн хүчин чадалтай, улс төр, эрх зүйн эрхэмлэн дагах учиртай баримт бичиг учир төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн нийлмэл байдлыг ханган, эрх зүйт төрийг төлөвшүүлэн тогтоох үйл явцын эрхэм дээд бодит шаардлага болдог.

Үндсэн хуулийн энэхүү үзэл баримтлал нь төрийн эрх мэдлийг хуваарилах түгээмэл онол, зарчимд суурилан, засгийн эрх мэдэл нэг хүний юм уу тодорхой бүлэг хүмүүсийн гарт төвлөрөх нөхцөл боломжийг хаах эрх зүйн гол баталгаа мөн.

Тус улсад улс төрийн шинэчлэлийн эхийг тавьж, шинэ Үндсэн хууль батлагдах хүртэлх түүхэн зурвас үед / 1990-1992 / үйлчилж байсан Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуульд зааснаар: "Монгол Улсын Ерөнхийлөгчийн албан тушаалд нэг хүнийг нэгээс илүү дахин сонгохгүй байх, Ерөнхийлөгчийн албан тушаалыг Үндсэн хуулиар үүрэгт нь хамаарахгүй цалинтай буюу цалингүй өөр төрлийн ажил, албан тушаал хавсарч болохгүй." гэжээ. Энэ нь нэг хүн төрийн олон алба зэрэг хаших, ингэснээр эрх мэдлийг монополичлох боломжийг хааж, цаашдаа төрийн хэрэгт олон хүнийг оролцуулах нөхцөлийг бүрдүүлснээрээ засгийн эрх мэдлийг хуваах анхны том алхам болсон гэж хэлж болно.

Төрийн эрх мэдэл хуваарилах онол нь засгийн эрх мэдэл, түүнийг хэрэгжүүлдэг байгууллагуудын зохион байгуулалт, үйл ажиллагааг нийтлэг зорилтын хүрээнд шаардлагатай нөхцөлд

¹ Б.Чинцаг Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн үзэл баримтлал. УБ.1996. 16 дахь тал.

хамтран ажиллах, төр ард түмний нэгдэл, язгуур эрх, ашиг сонирхолыг хамгаалах, нийгмийн хөгжлийн баталгаат нөхцөлийг хангах зэрэг үйл хэрэгт нэгдмэл хүчээр ажиллах явдлыг үгүйсгэдэггүй. Түүнчлэн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх явцад түүхэн тодорхой нөхцөлд ард түмний язгуур эрх, ашиг сонирхолын үүднээс аль нэг эрх мэдэл тэргүүлэх, давамгайлах үүрэг хүлээхийг нийгмийн амьдрал заавал шаарддаг. Энэ шаардлагыг соргог мэдэрч хэрэгжүүлэхгүй аваас төрийн эрх мэдлийн тэнцвэрт байдал алдагдаж, илүү эрх мэдлийн төлөө тэмцэл газар авч эцэстээ нийгмийг бүхэлд нь хямруулах аюултай. *Эрх зүйт төрийг төлөвшүүлж буй оноогийн нөхцөлд төрийн эрх мэдлийн тэнцвэрт байдлыг ханган, төрийн ноён нуруу болж байх байгууллага нь Парламент юм.*

Төрийн засгийн эрх мэдэл, түүнийг хэрэгжүүлэх байгууллагууд, тэдгээрийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, хоорондын харилцаанд баримтлах журам, эрх хэмжээ, үйл ажиллагааных нь харилцан шүтэлцээтэй байх шинж, бие биенийгээ тодорхой нөхцөлд нөхөн сэлбэх чадвар, шаардлагатай нөхцөлд харилцан бие биенийхээ үйл ажиллагаанд хуульд заасан ёсоор тодорхой асуудлаар хаалт тээг тавих эрхтэй байхаар төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг хэрэглэдэг.

"Төрийн эрх мэдэл хуваарилах" хатуу ба зөөлөн хувилбар байдаг. "Хатуу" хувилбараар эрх мэдэл хуваарилах үед гүйцэтгэх эрх мэдлийн гол институт болох Засгийн газар нь Парламентаас хамаарал багатай байдаг бөгөөд төрийн тэргүүний институттэй холбогдсон байдаг. "Зөөлөн" хувилбарын нөхцөлд Засгийн газар нь Парламентаас харьцангуй илүү хамаардаг, эсхүл шууд хамаарч байдаг. Эдгээрийг төр, эрх зүйн ерөнхий онолд төрийн удирдлагын хэлбэрээс нь хамааруулан Ерөнхийлөгчийн Бүгд Найрамдах Улс, Парламентын Бүгд Найрамдах Улс хэмээн томъёолдог. Тэгвэл *Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон манай төрийн тогтолцоо "зөөлөн" хувилбарт илүүтэй тохирно гэж үзэх үндэстэй юм.*

1990 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуульд заасны дагуу анхны байнгын ажиллагаатай Парламент байгуулсан нь хууль тогтоох эрх мэдлийг жинхэнэ

утгаар нь хэрэгжүүлэх том шийдэл юм. Эл хуулиар Монгол Улсын Ерөнхийлөгчийн албан тушаал бий болгож, *Засгийн газрын харьцангуй бие даасан байдлыг бэхжүүлж*, Парламентын өмнө хариуцлага хүлээх зарчмыг тусгасан нь энэ хуулийн нэг гол онцлог болно.

Олонхи эрх зүйчид, улс төр судлаачдын үзэж байгаагаар төрийн эрх мэдлийг хуваарилах нь Үндсэн хуульт ёсны гол зарчим юм. Үндсэн хуульт ёс бол хууль, ялангуяа Үндсэн хууль улс орны дээд хүчин чадалтай эрх зүйн гол акт байж, төрийн эрх мэдэл ард түмний мэдэлд байж түүний засаглалын үйл ажиллагаа нь хуулиар хязгаарлагдсан байх явдал ажээ. Үндсэн хуульт ёс хэрэгжиж буй улсад эрх мэдэл хянагддаг учир төрийн институтуудын хооронд эрх мэдэл хуваагдаж, бие биенээ хянах хэмжээгээр хамтран ажилладаг байна. Үүний хамт төрийн эрх мэдэл хэрэгжүүлж буй байгууллага, түүний салаа мөчир бүр Үндсэн хуулиа хамгаалах, түүнийг бүтээлчээр хэрэгжүүлэхийн төлөө хүчин зүтгэх ёстой. Энэ ч учраас Үндсэн хуульт ёсыг амьдралд хэрэгжүүлэх бодит механизм нь төрийн эрх мэдлийн хуваарилалт болно.

Төрийн эрх мэдлийг хуваарилах зарчмыг Үндсэн хуулиндаа тунхаглаж бататган тусгасан л бол аяндаа хэрэгжинэ гэж үзэж болохгүй бөгөөд тэнцвэртэй байх, харилцан хянах, хэн нэгнийхээ ажил хэрэгт үл хутгалдах зэрэг үндсэн зарчмууд нь амьдралын "бичигдээгүй хуулиуд"-аар зөрчигдөх нь цөөнгүй. Иймд түүнийг хэрэгжүүлэх механизмыг зөв зохистой бүрдүүлэх, боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигддаг байна. Үүний сацуугаар эрх мэдэл хуваарилах нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлүүд бие даасан, харьцангуй тусгаар бие биенээсээ хараат бус байж, бие биенээ хязгаарлаж хянаж байх боломжтойн зэрэгцээ нэгдмэл цул төрийн бүрэлдхүүн хэсгүүдийн хувьд нийтлэг зорилтын тулд хамтран ажиллах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, энд төрийн эрх мэдлийн нэгдмэл байдлын тухай асуудал сөхөгдөж байна. Төрийн эрх мэдлийн нэгдмэл байдал нь гурван талтай асуудал юм. **1. Социал нэгдмэл** байдал нь нийгэмд зонхилгогч социал бүлгүүдийн нийтлэг ашиг сонирголоос эх үүсвэртэй байдаг гэж үздэг. **2. Нийгмийг зөвшилцөл, тохиролцоогоор удирдах шаардлагаас үүдэн гардаг төрийн бүх**

байгууллагуудын үндсэн зорилго, зорилтын нэгдмэл байдал 3. Зохион байгуулалт, эрх зүйн нэгдмэл байдал . Гэхдээ нэгдмэл байдлын энэхүү талыг хэт хөөрөгдвөл эрх мэдэл хуваарилалтыг үгүйсгэхэд хүрч мэдэх талтай.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан төрийн эрх мэдэл хоорондын харилцааг авч үзье. Хууль тогтоох ба гүйцэтгэх эрх мэдэл хоорондын харилцаа.

Төрийн эрх мэдэл, түүнийг хэрэгжүүлдэг байгууллагуудын зохион байгуулалт, үйл ажиллагааг нийтлэг зорилтын хүрээнд шаардлагатай нөхцөлд хамтран ажиллах, төр ард түмний нэгдэл, язгуур эрх, ашиг сонирхлыг хамгаалах, нийгмийн хөгжлийн баталгаат нөхцөлийг хангах зэрэг үйл хэрэгт нэгдмэл хүчээр ажиллах явдлыг үгүйсгэдэггүй бөгөөд харин ч энэ нь төрийн эрх мэдлийг хуваарилах зарчмын гол баримтлал нь болдог билээ. Өөрөөр хэлбэл хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлүүд нь харьцангуй бие даасан байхаас гадна төрийн засгийн эрхийг урвуулан хортойгоор ашиглах, дураар авирлахаас сэргийлэх үүднээс бие биеэ тогтоон барих, харилцан хяналт тавих, хамтран ажиллах эрмэлзлэл бүхий байхаар хуваарилдаг байна. Энэ ч шаардлагыг удирдлага болгон манай улсын төрийн эрх барих дээд байгууллага-Улсын Их Хурал, төрийн тэргүүн-Ерөнхийлөгч, төрийн гүйцэтгэх дээд байгууллага Засгийн газрын эрхлэх ажил, чиг үүрэг, бүрэн эрх тогтоогдсон гэж хэлж болно. Үүнтэй холбогдуулан Улсын Их Хурал, Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар зэрэг хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн институтуудын чиг үүрэг, үйл ажиллагааны уялдаа холбоо, харилцан зохицлын зарим асуудлыг онцлон авч үзье.

Улсын Их Хурал ба Засгийн газар. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг тогтоох, өөрчлөх нь Улсын Их Хурлын бүрэн эрх байдаг. Мөн ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг Улсын Их Хурлаас томилно. Улсын Их Хурал нь Засгийн газрыг байгуулж байгаа учир түүнийг парламентын олонхийн зарчмаар, өөрөөр хэлбэл, олонхийн суудал авсан нам Засгийн газраа байгуулах бөгөөд мөнхүү олонхийн саналд нийцсэн бодлогыг Засгийн газраас явуулахыг шаарддаг.

Улсын Их Хурал нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг огцруулах эрхтэй байдаг ба Засгийн газар нь Улсын Их Хурлын

өмнө ажлаа хариуцан тайлагнана. Улсын Их Хурал нь Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг батална. Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг Улсын Их Хурал баталж, өөрчилнө.

Засгийн газар ба Улсын Их Хурал. Засгийн газар Улсын Их Хурлын итгэлийг хүлээсэн байх нь төрийн тогтвортой байдлын чухал нөхцөл болдог. Засгийн газрын үйл ажиллагааны талаархи олон нийтийн санаа бодол, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн байх суурийг харгалзан шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Засгийн газар өөрт нь итгэл хүлээлгэж байгаа эсэхийг илэрхийлж өгөхийг хүсэж, холбогдох тогтоолын төслийг Ерөнхий сайд, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Засгийн газар үйл ажиллагааныхаа хөтөлбөрийн төслийг өөрийн бүрэн эрхийг эхэлснээс хойш 60 хоногийн дотор, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл зэрэг баримт бичгийн төслийг Улсын Их Хурлаас тогтоосон хугацаанд түүнд өргөн мэдүүлдэг байна.

Засгийн газар Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулах үүрэгтэй байдаг. Засгийн газраас Улсын Их Хуралтай өдөр тутам шууд харилцах асуудлыг Ерөнхий сайд, эсвэл ажил үүргийн хуваарь бүхий Засгийн газрын гишүүн эрхэлдэг. Засгийн газар нь Улсын Их Хуралд жил бүр үйл ажиллагааныхаа тайланг тавьж, цаг үеийн асуудлаар тогтмол мэдээлэл хийнэ.

Засгийн газар нь хууль санаачлах эрх бүхий 3 субъектын нэгний хувьд боловсруулсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг Ерөнхий сайд, түүний даалгавраар Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурлын даргад зохих журмын дагуу өргөн мэдүүлнэ.

Засгийн газар нь хуулийн төсөл, төрийн бодлогын зарчмын бусад асуудлаар Улсын Их Хурлынхаас өөр саналтай байгаа бол Ерөнхий сайд уг саналаа дахин хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд дахин тавьж болох бөгөөд түүнийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэн шийдвэрлэж хариу өгнө. Засгийн газар, түүний байгууллага / Сангийн яам г.м / төсвийн зарцуулалтын асуудлаар Улсын Их Хурлыг өөрийг нь оролцуулан нийт улсын хэмжээнд хяналт шалгалт эрхэлнэ. Засгийн газрын гишүүн нь Улсын Их

Хурлын гишүүний асуултын хариуг хууль тогтоомжид заасан журмын дагуу өгөх үүрэг хүлээхээр Үндсэн хуульд заажээ.

Парламент ба Засгийн газрын хоорондын харилцаа нь үндсэндээ иргэдийн нийтлэг ба өвөрмөц эрх ашгийг төрийн бодлогод тусгах хэрэгсэл юм. Гэвч амьдрал дээр төрийн эрх мэдэл хоорондын харилцааны зарим ээдрээт асуудал байгаа нь янз бүрийн байдлаар илэрч байгааг үгүйсгэх аргагүй юм. Энэ тухай Г.Чулуунбаатар, Д.Батмөнх нар "Төрийн байгууллагын тогтолцоо, түүний дээд өндөрлөг дэх ээдрээтэй асуудлууд" өгүүлэлдээ: "...Хууль тогтоох онцгой эрх мэдлийг зөвхөн Улсын Их Хурал өөртөө хадгалж байх ёстойг Үндсэн хуульд тодорхойлсон. Гэтэл энэ онцгой бүрэн Улсын Их Хурал маань хуваан хэрэгжүүлж байна уу даа гэж үзэж болохоор байдал бий болж болзошгүй. Улсын Их Хурал нэг хууль гаргаад нийм асуудлыг Засгийн газар, тийм журмыг тэр яам, өөр нэгийг нь тэр сайд гаргана гэх нь холгүй байна. Энд тодорхой зааг ялгаа гаргаж, эмх цэгц тогтоохгүй бол гүйцэтгэх эрх мэдэлтнүүд хууль тогтоох эрхийг хуваалцан хэрэгжүүлдэг зохисгүй байдал бий болох талтай. Ингэж хууль хэрэгжүүлдэх үйл ажиллагаа өөрөө хууль тогтоох шинжтэй болчихож таарахгүй"¹ хэмээн онож гэмдэглэжээ.

Парламент болон Засгийн газрын харилцааг шуурхай, ажил хэрэгч, цэгцтэй болгох үүднээс парламентат ёс төлөвшсөн орнуудын жишгээр Засгийн газарт парламенттай харилцах асуудал эрхэлсэн гишүүн / сайд, төрийн нарийн бичгийн дарга г.м / байх нь зүйтэй гэж бид үзэж байна.

Улсын Их Хурал ба Ерөнхийлөгч. Улсын Их Хурал нь бүх ард түмнээс сонгогдсон Ерөнхийлөгчийг сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргадаг бөгөөд Ерөнхийлөгчийг огцруулах, чөлөөлөх эрхийг Улсын Их Хурал эдэлнэ. Энэ тухай Үндсэн хуулийн 3⁵ дугаар зүйлийн 2-т, Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж, Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаар хэлэлцэж, нийт гишүүдийн дийлэнх олонхийн саналаар огцруулна гэж заасан билээ.

¹ Г.Чулуунбаатар, Д.Батмөнх. Төрийн байгууллагын тогтолцоо, түүний дээд өндөрлөг дэх ээдрээтэй асуудлууд. өгүүлэл. Засгийн газрын мэдээ. 1997. № 230.

Ерөнхийлөгчид олгосон хамгийн бодитой эрх бол Улсын Их Хурлын баталсан хууль, шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих эрх юм. Ерөнхийлөгчийн хоригийг Улсын Их Хурлын гишүүдийн гуравны хоёрын саналаар хүлээж аваагүй бол уг хууль, шийдвэр хүчин төгөлдөр үлддэг.

Ерөнхийлөгч ба төрийн байгууллагын бусад субъектуудын харилцан хамаарлын асуудалтай холбогдуулж хэлэхэд энэ талаархи Үндсэн хуулийн зарим заалтад зохих тайлбар гаргах нь уг харилцааны төлөвшилд чухал учир холбогдолтой. Тухайлбал, Ерөнхийлөгч нь " Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг Улсын Их Хуралтай зөвшилцөн томилох эрхтэй байна. Гэтэл өнгөрсөн хугацаанд Ерөнхийлөгч зарим элчин сайдыг томилохдоо Улсын Их Хурлын байр суурийг харгалзалгүй томилсон тохиолдол гарч байсан. Энэ нь "зөвшилцөх" гэдэг үгийг нэг хэсэг нь Ерөнхийлөгч Улсын Их Хуралд саналаа "танилцуулах" гэсэн утгаар нөгөө хэсэг нь Улсын Их Хуралтай "тохиролцох, саналыг нь заавал харгалзах" гэсэн утгаар ойлгодог.

Зохиогч Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын тухай хуулиудыг хэлэлцэн батлахад уг асуудлаар өөрийн үзэл бодлыг нэг биш удаа илэрхийлэхдээ "Зөвшилцөх" -ийн утга учрыг аль нэг талыг барьж / туйлширч / шийдвээс Засгийн хямралд хүрч болзошгүй. Иймд уг асуудлыг шийдэхдээ: **нэгд**, манайх парламентын засаглалтай улс; **хоёрт**, төрийн эрх мэдэл хуваарилах үзэл баримтлалд / улс төрийн агуулгаар нь / яв цав нийцүүлэх; **гуравт**, энэ асуудлыг нэлээд олон орны Үндсэн хуулинд Ерөнхийлөгч, Парламентын зөвлөмжөөр буюу зөвшөөрснөөр эсвэл парламент өөрөө шууд томилох эрхийг хоёрдмол утгагүй эдэлдэг практикийг тус тус харгалзах ёстой гэж үзэж байсныг дурдах нь зүйтэй юм.

Тэрчлэн "Ерөнхийлөгч Улсын Их Хуралд ажлаа хариуцана" гэсэн Үндсэн хуулийн заалт нь энэ хоёр субъектын харилцааны нэг гол механизм мөн.

Хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн харилцан хамаарал байдлын асуудалтай холбон хэлэхэд саяхан болтол улс төрчид, эрх зүйчдийн анхаарлыг татсан маргаантай асуудал бол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүнээр хавсран ажиллаж

болох эсэх тухай асуудал юм. 1992- 1996 онд Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний гуравны нэг нь Улсын Их Хурлын гишүүд байсан бөгөөд энэ нь холбогдох хуулийн тухайн үед мөрдөгдөж байсан заалттай нийцэж байсан юм. Гэвч 1996 онд Улсын Их Хурлын сонгуулийн дараа дээрх асуудлаар маргаан үүссэнийг Үндсэн хуулийн Цэц, Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн шийдвэрлэсэн билээ. Энэ нь мөн л төрийн эрх мэдлийн хүрээ буюу төрийн байгууллагын ажил үүргийн хуваарнаас үүдэлтэй юм.

Хууль тогтоох ба шүүх эрх мэдэл хоорондын харилцаа. Хууль тогтоох ба шүүх эрх мэдлийн харилцааны асуудал дотор Улсын Их Хурал, Үндсэн хуулийн цэцийн харилцаа чухал байр эзэлнэ. Монгол Улсын Их Хурал, Үндсэн хуулийн Цэцийн хоорондын харилцаа Үндсэн хуулиа дээдлэх ёсныхоо дагуу хуулийн хүрээнд явж ирсэн гэж үзэж байна. Гэвч өнгөрсөн 7 жилийн хугацаанд Үндсэн хуулийн эл хоёр институтийн хоорондын харилцаанд хууль зүйн зохицуулалтын болон ёс зүйн хувьд анхаарч авч үзэх асуудлууд байсан. Судлаачдын үзэж байгаагаар парламент ба Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааг авч үзэхэд үндсэн хуулийн эдгээр хоёр байгууллагын хоорондын харилцаа нь **мөн чанараараа сөргөлдөөн бүхий харилцаа юм.** Энэхүү харилцааны хүрээнд Үндсэн хуулийн шүүх нь парламентын эрх мэдэлд олон хэлбэрээр нөлөөлөх боломжтой. Түүний хамгийн хүчтэй хэлбэр нь хуулийг хүчингүйд тооцох нөгөө талаар парламент нь Үндсэн хуулийн шүүгчдийг сонгоход оролцдог учир өөрийг нь хянадаг байгууллагын бие бүрэлдэхүүнд нөлөөлөх боломжтой байдаг. / ХБНГУ-ын Холбооны Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн § 5, § 6, Монгол Улсын Үндсэн хуулийн 65-р зүйлийг үз / гэж доктор Г.Лихтенбергер үзэж байна. Тэрээр Парламент ба Үндсэн хуулийн шүүх хоорондын харилцааны эрх зүйн үндсийн тухай ярихдаа 1. "бичмэл эрх зүйн үндэс. Үүнд Үндсэн хууль, Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль, муж улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль гэх мэт хуулиуд орно. 2. Парламент ба Үндсэн хуулийн шүүх хоорондын харилцаанд үйлчлэх бичигдээгүй хууль журам байна.¹ гэжээ. Үндсэн хуулийн шүүх

¹ Үндсэн хуулийн шүүх, парламент хоорондын харилцааны эрх зүйн болон ёс зүйн үндэс, симпозиум. УБ. 1998. 92 дөв тал.

нь өөртөө үл хамаарах асуудалд хутгалдахгүй байх ёстой. Үндсэн хуулийн шүүхийн баримтлах ёстой бас нэг зарчим бол төрийн дээд байгууллагууд бие биенээ харилцан хүндэтгэх ба ялангуяа бусад байгууллагын эрх мэдлийг хөндөхгүй байх явдал юм.

Парламент ба Үндсэн хуулийн шүүхийн харилцааг тодорхойлох үндсэн зарчимд уг шүүхийн шийдвэрийг Үндсэн хуулийн бусад байгууллага, түүний дотор парламент хүлээн зөвшөөрч, хүндэтгэх зарчим орно. Хэдийгээр Үндсэн хуулийн шүүх нь их эрх мэдэлтэй ч өөрийнхөө гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардагдах бодит хэрэгсэл түүнд байхгүй. Тийм учраас Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг нийгмийн бүх хүчин хүлээн зөвшөөрч, дагаж мөрдөх явдлаас Үндсэн хуулийн шүүхийн хувь заяа хамаарна. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх эсэх нь юуны өмнө тухайн шүүхийн чадвар нэр хүндтэй холбоотой.

Парламент Үндсэн хуулийн шүүхийн хоорондын харилцааны бас нэг зарчим нь харилцан итгэлшлийн зарчим юм. Энэ зарчмын гол агуулга нь тухайн хоёр байгууллага бие биенийхээ гүйцэтгэж буй ажил, үүрэг даалгаврын биелэлтэд итгэх ёстой. Монгол Улсын Их Хурал, Үндсэн хуулийн Цэц хоорондын харилцаанд хуулиар тогтоосон онцлог бол Үндсэн хуулийн Цэц Үндсэн хуулийн маргааныг авч шийдвэрлэхдээ эхлээд заавал дүгнэлт гаргаж, Улсын Их Хуралд оруулахаар хуульчилсан явдал юм. Эл зохицуулалтын зэрэг, сөрөг үр дагаварын талаар Үндсэн хуулийн Цэцийн дарга Н.Жанцангийн үндэслэлийг сонирхоё.

1. Үндсэн хуулийн Цэц Улсын Их Хурлын гаргасан хууль, бусад шийдвэрийг Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэлт гаргасан тохиолдолд Улсын Их Хурал өөрийн гаргасан алдааг заавал Цэцийн эцсийн шийдвэр гаргахыг хүлээлгүй засаж залруулах боломжтой.

2. Үндсэн хуулийн Цэц бүх тохиолдолд туйлын үнэн шийдвэр гаргана гэсэн баталгаа байхгүй. Ийм болохоор Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал яагаад хүлээж аваагүй вэ? гэдгийг Цэц эцсийн шийдвэр гаргахдаа харгалзах боломжийг олгож байгаа юм.

Сөрөг үр дагавар нь:

1. Улсын Их Хурал Цэцийн дүгнэлтийг хэлэлцэхгүй хуульд



заасан хугацаа хэтрүүлэн хадгалах явдал нэлээд түгээмэл ажиглагдсаар байна. Хуульд зааснаар бол Улсын Их Хурал Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг хүлээж авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрээ гаргах ёстой. Гэтэл зарим тохиолдолд Улсын Их Хурал, Үндсэн хуулийн Цэцийн зарим дүгнэлтийг хэлэлцэхгүй удаасан тохиолдол ч гарч байв. Ийм тохиолдолд Үндсэн хууль зөрчсөн хууль, зарлиг дээр гарч байгааг бүр ноцтой гэж үзэх ёстой.

Үндсэн хуулийн Цэцэд хууль тогтоох эрх мэдэл байхгүй боловч нэгэнт батлагдсан хууль, шийдвэрийг хүчингүй болгож, эцсийн шийдвэр гаргаж байгаа болохоор Цэцийн шийдвэр нь хууль хэрэглэж байгаа бүх субъектуудад хүрч, хуулийн өөрчлөлтүүдэд тусгагдаж байх систем тогтсон байх ёстой. Гэвч одоогоор энэ асуудлыг тусгайлан зохицуулсан эрх зүйн ямар нэг зохицуулалт байхгүй байна.¹ гэсэн байна. Дээрхи эрдэмтдийн тайлбар, үндэслэлүүдийг авч үзэхэд үнэхээр Улсын Их Хурал, Үндсэн хуулийн цэц хоёрын хоорондын харилцааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох асуудлыг судлах шаардлага зүй ёсоор гарч ирж байгаа юм.

Үндсэн хуулийн Цэц болон Улсын Их Хурлын шийдвэрийн хууль зүйн хүчин чадлын харьцааны асуудлыг авч үзэх нь Үндсэн хуулийн эл хоёр байгууллагын харилцааны онцлог, эл хоёр субьектээс гаргаж буй шийдвэрийн хууль зүйн шинж, онцлогийг тодруулахад арга зүйн ач холбогдолтой юм. Учир нь 1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилснээс хойшхи өнгөрсөн хугацаанд төрийн эрх барих болон хууль тогтоох цорын ганц байгууллага болох Улсын Их Хурлаас батлан гаргаж буй хууль тогтоомж, Үндсэн хуулийн заалтуудыг тодруулж, нийгмийн олон талт харилцааг нарийвчлан зохицуулах үүрэгтэй, Үндсэн хуулийг Улсын Их Хурал тайлбарлах ёстой гэсэн үзэл баримтлал зонхилох хандлагатай байв. Монгол Улсад хуулийн албан ёсны тайлбарыг Улсын Дээд шүүх гаргаж байна. Харин Үндсэн хуулийг Улсын Их Хурал тайлбарласан явдал 1993 онд нэг удаа гарсан бөгөөд 1998 онд Ерөнхийлөгч Ерөнхий сайдад нэр дэвшүүлэхдээ парламентад олонхийн суудал авсан нам /

¹ Н.Жинпан. Дурасан өгүүлэл. 48 дэх тал.

эвсэлтэй / зөвшилцөх гэдэг асуудлаар Үндсэн хуулийн холбогдох заалтыг тайлбарласан боловч түүнд Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг Улсын Их Хурал хүлээн авсан билээ. Үндсэн хуулийг тайлбарлах субъект бий эсэх талаар профессор Г.Совд бичихдээ "Монгол Улсын шинэ Үндсэн хуулиар Улсын Их Хуралд хууль тайлбарлах эрх олгоогүй бөгөөд Монгол Улсын Үндсэн хуульд албан ёсны тайлбар өгөх эрхийг ямар ч байгууллагад олгоогүй тул Үндсэн хуульд зөвхөн эрдэм шинжилгээний тайлбар хийх эрхийг хүний эрхийг хүндэтгэх, эрх зүйн шинжлэх ухааныг үнэлэх, хүмүүжлийн зарчмын үүднээс зөвшөөрөгдсөн байна."¹ гэжээ.Сайх дүгнэлттэй санал нийлж байгаа бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал нь Монгол Улсын Их Хуралд аль нэг хуулийг тайлбарлах эрх олгоогүйн хамт Монгол Улсын Үндсэн хуульд албан ёсны тайлбар хийх эрхийг аль ч байгууллагад олгоогүй гэж үзэж байна.

Гүйцэтгэх эрх мэдэл ба шүүх эрх мэдэл хоорондын харилцаа.
Гүйцэтгэх эрх мэдэл ба шүүх эрх мэдэл нь төрөөс засаглалаа хэрэгжүүлж буй эрх мэдлийн хүрээ болохын хувьд эцсийн зорилгоороо нэгдмэл байх тухай ерөнхий зүй тогтолд захирагдана.Өдгөө гүйцэтгэх эрх мэдлийг шууд толгойлоогүй боловч, энэ хүрээнд бүрэн эрхээ хэрэгжүүлэх статус бүхий төрийн тэргүүн-Ерөнхийлөгчийн шүүх эрх мэдлийн хүрээнд хэрэгжүүлэх бүрэн эрхийг Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид хуульчлан бэхжүүлсэн юм. Тухайлбал Улсын Дээд шүүхийн шүүгчдийг Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс Улсын Их Хуралд танилцуулснаар, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн, дагнасан шүүхийн шүүгчийг Ерөнхий зөвлөлийн санал болгосноор, мөн бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгчдийг хуульд заасны дагуу тус тус Ерөнхийлөгч томилно. Мөн хуульд заасан үндэслэл журмын дагуу шүүгчдийг албан тушаалаас нь чөлөөлөх, огцруулах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.

Шүүх эрх мэдлийн хүрээний асуудлууд болох хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагуудын захиргааны удирдлагыг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд хэрэгжүүлдэг.

¹ Г.Совд. Улсын Их Хурал хууль тайлбарлах уу. Өгүүлэл. Монголын тор. эрх зүй. 1995. №2.

Гүйцэтгэх эрх мэдлийн шүүх эрх мэдэлтэй харьцах гол асуудал бол Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн бүрэлдэхүүний асуудал юм. Үндсэн хууль, Шүүхийн тухай хуульд зааснаар Шүүхийн Ерөнхий Зөвлөл нь шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах үүрэг бүхий хамтын удирдлагын орон тооны бус байгууллага мөн. Ерөнхий Зөвлөлийн бүрэлдэхүүнд Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурор, Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Ерөнхий Зөвлөлийн нарийн бичгийн дарга албан тушаалаараа, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчөөс томилсон тус бүр нэг хүн, зохих журмын дагуу нэр дэвшүүлж, Улсын Дээд Шүүх сонгосон бүх шатны шүүхээс тус бүр 2 шүүгч орно. Ерөнхий Зөвлөлийн дарга нь Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

Шүүх эрх мэдэл түүнийг хэрэгжүүлэгч байгууллагуудын харьцангуй бие даасан байдлыг үгүйсгэж, түүнийг хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд шууд хамааруулан авч үзэх нь зүйд нийцэхгүй юм. Нэг үгээр хэлбэл, шүүх эрх мэдлийн байгууллагуудын бие даасан, тусгаар байдлын улс төр, эрх зүй, нийгэм эдийн засгийн баталгааг бүрдүүлэх нь хууль тогтоох-шүүх эрх мэдэл; гүйцэтгэх эрх мэдэл- шүүх эрх мэдэл гэсэн харилцаанд онцгой чухал ач холбогдолтой юм.

Ийнхүү гүйцэтгэх эрх мэдэл нь хууль тогтоох байгууллагаас гаргасан хуулийн биелэлтийг хангаж зохион байгуулах, шүүх эрх мэдэл нь хуулийг сахиулах чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

ТӨСЛИЙГ УЛАМ ТӨГӨЛДӨР БОЛГОЁ.

Жавхлангийн БЯМБАА
МУИС-ийн профессор

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа маань энгийн, ойлгомжтой, эрх зүйн тогтолцооны аль нэг хэлбэрийг голлон түшихдээ уламжлалаа ухаалгаар хослуулан хууль шударга ёс, ардчиллын үнэт ололтыг эрхэмлэн дээдэлсэн хугацааны хэмнэлтэй, элдэв чирэгдэлгүй, бүтээлч байх учиртай. Чухамдаа хэний ашиг сонирхол, яаж, ямар арга хэлбэрээр хамгаалагдаад байгаа нь төдийлөн тодорхой биш хуулийн заалтуудыг нэгэн мөр болгон журамлахгүй бол өнгөн дээрээ ардчилал, хүний эрхийг дээдэлсэн юм шиг атлаа нөгөө л дураар ашилж болохуйц цоорхойнууд, ерөнхий, тусгай ангийн уялдаа муутайхан зохицуулалтууд, эцэс төгсгөлгүй эргэн хөрвөөсөн янз бүрийн шатны шийдвэрүүд манай байцаан шийтгэх ажиллагааны дүр төрхийг тодорхойлсон хэвээр үлдэх болно.

Юуны урьд шүүн таслах байгууллагаас яллах чиг үүргийг ангигжуулах чиглэлээр зоригтой алхам хийх цаг болсон. Бүр 1963 онд Эрүүгийн байцаан шийтгэх хууль батлан гаргахдаа мэтгэлцэх зарчмыг тусган баталгаажуулсан билээ. Ингэснээр Эрүүгийн процесст яллах, өмгөөлөх, шүүн шийдвэрлэх чиг үүргүүд, түүнийг эрхлэн хэрэгжүүлдэг талууд болон байгууллага тов тодорхой болсон юм. Жишээлбэл, хөндлөнгийн, хараат бус шүүхийн өмнө яллах бүхий л баримтыг гагцхүү прокурор гарган тавьж илчлэн нотлох үүрэг хүлээх ёстой. Гэтэл хуулийн зорилго, заалтаас өөр практик хэвээр үргэлжилсээр . . .

1994 онд Үндсэн хуулийн /шинэ/ үзэл санааны дагуу Эрүүгийн байцаан шийтгэх хуулинд зарим тодруулга хийсэн ч нааштай хандлага гараагүй.

Иймээс өнөөгийн төсөлд мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх зоригтой алхам хийж дээрх зорилтыг хэрэгжүүлэх цаг болсон. Тухайлбал:

- * Хуралдааны үед урьдчилсан мөрдөн байцаалтын дутууг гүйцээж яллах баримтыг тодруулах процесс ажиллагааг шүүх бүрэлдэхүүн биеслэн эрхлэх;

- * Яллах тал эрх үүргээ биелүүлэхээс сайн дураар татгалзах тохиолдолд шүүх өөрөө санаачлан ял зэм оноох;
- * Шүүгдэгчийн гэм бурууг нотлуулахаар шүүх санаачлан нэмэлт мөрдөн байцаалтанд буцаах;
- * Цагааттасан, хэрэгсэхгүй болгосон үндэслэлийг үл зөвшөөрөх болон зүйл анги, ялыг хүндрүүлэн шийдвэрлүүлэхээр /эрх бүхий/ шүүгчид эсэргүүцэл бичих зэрэг шүүхийг яллах байгууллага хэмээн ойлгогдох журмуудыг юуны урьд арилгах цаг болсон.

Мэдээж, ийм өөрчлөлтүүд нь манай өнөөгийн эрх зүйн ухамсар, сэтгэлгээнд тийм ч хялбар хоногшихгүй.

Шүүн таслах чиглэлээр хийгдэх дээр дурьдсан өөрчлөлтүүдтэй уялдуулан прокурорын хяналтыг ихээхэн идэвхжүүлэх шаардлагатай. Юуны урьд прокурорын хяналтыг ихээхэн идэвхжүүлэх шаардлагатай. Юуны урьд прокурорын "хөндлөнгийн" шинж чанартай чиг үүргүүдийг нэлээд багасгах нь зүйтэй. Тухайлбал: Гэм буруутай эсэхийг шийдвэрлэхэд прокурор тун их идэвхи чармайлт гаргана.

Тэр нь Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны үе шат болгонд тов тодорхой байна. Харин шүүхийн үйл ажиллагааг "хянаж" эсэргүүцэл бичдэг ч юм уу аливаа шүүх хуралдааны үед "дүгнэлт" өгөх гуравдагч этгээдийн байр суурьнаас хандах зэрэг хэлбэрүүдийг аль болохоор хязгаарлаж, ерөнхий зарчимд нийцүүлэн авч үзэх шаардлагатай. Улсын яллагчийн үүднээс хохирогчийн ашиг сонирхол нийгэм, төрийн эрх ашгийг хамгаалахдаа шүүгдэгчийг өмгөөлөх, аливаа илрэлээс чөлөөлөгдөх ёстой.

Шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд эргэлзээ төрүүлэхгүй, хэргийг хууль, шударга ёсны үндэслэлгүйгээр хэрэгсэхгүй болгуулахгүйн төлөө прокурорын үйл ажиллагаа чиглэхээр төсөлд хуульчилж өгөх шаардлагатай.

Мөрдөн байцаах, хэрэг бүртгэх албаны дарга нар процесс ажиллагааны хэлбэр талыг голлон хариуцсан зохион байгуулагч, зохицуулагч байдаг бол прокурор дотоод мөн чанарыг мэдэрсэн "процессын удирдагч" мөнгийг төсөлд тодруулж өгөх нь зүйтэй. Дашрамд дурьдахад шүүхийг хянаж шалгах элдэв хэлбэрийг эрх зүйн аль ч тогтолцоонд төдийлөн таашаадаггүй. Тэр ч атугай

гаргасан хуулийн биелэлтээ шүүхийн үйл ажиллагаа, тэр тусмаа шүүгчийн ёс зүйтэй холбон хянах Парламентын оролдлогыг хүртэл Англо-Саксоныхон "доромжлол" гэж үздэг байхад Роман-Германыхан "томоохон хэрүүл маргаан" хэмээн тооцдогийг саяхан төрийн ордонд болж өнгөрсөн "Шүүхийн чадавхийг дээшлүүлэх нь" сэдэвт семинар дээр Германы нэрт эрдэмтэн, Бавари муж улсын Захиргааны шүүхийн Ерөнхийлөгч, профессор Иохани Виттмани гуай шуудхан хэлчихнэ лээ.

Төсөлд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагын тогтолцоо, үйл ажиллагааны хэлбэрийг төгөлдөржүүлэхэд нэлээд зүйл тусгах шаардлагатай байна. Юуны урьд эрүүгийн хэрэг бүртгэлтийг "богино хугацааны" мөрдөн байцаалт болгомоор санагдана. Хэрэг бүртгэлтийн гол зорилго нь гэмт үйл явдал болсоныг тогтоож хэргийн холбогдогчийг илчлэн, нотолгооны ач холбогдол бүхий баримт, сэлт мэдээллийг халуун мөрөөр нь олж бэхжүүлэхэд чиглэгддэг. Манай нэгэн онцлог ажиллагаа бий.

Тэр нь зарим хүндэвтэр, хөнгөн хэргүүдийг мөрдөн байцаалтыг дамжуулахгүйгээр шүүхэд шууд шилжүүлэн шийдвэрлэх журам хуульчлагдан тогтсон.

Ер нь эхэлсэн ажлынхаа үр дүнг үзэх хэрэг бүртгэгчдийн сонирхолыг аль болохоор хөхүүлэн дэмжих нь зүйтэй. Хөнгөн, зарим хүндэвтэр төдийгүй ил тодорхой аль эсхүл шуурхай нотлох шаардлагатай, боломж бүхий хэргүүдийг богино хугацаанд шүүхэд шилжүүлж чадвал элдэв чирэгдэл тун багасна. Жишээлбэл, авто осолын, залилан, дээрмийн, хүний биед гэмтэл учруулсан гэх мэт ил тодорхой ямар ч хэргүүдийг хүнд, хөнгөн гэлгүй түргэн шуурхай бүрдүүлж шүүхээр шийдвэрлүүлбэл ядаж мөр ул нь "халуунаараа" хүргэгдэнэ.

Тийм боломж олгохын тул хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтыг "баг" бүрдүүлэх, нэг хэсэг нь бүртгэж /богино хэлбэрийн мөрдөн байцаалт/, нөгөө хэсэг нь явиг төвөгтэй хэргүүд дээрээ ажиллаж байдаг бүтэн тогтолцоо бий болгох шаардлагатай. "Богино хэлбэр"-ийн мөрдөн байцаалт гэж ахин дахин нэрлээд байдаг учир нь хэрэг бүртгэгчид сэжигтэн, холбогдогчийг ял сонсгож, яллагдагчаар татах эрх байхгүйтэй холбогдоно. Хэрэг бүртгэлтээс шүүхэд шилжүүлэхэд зөвхөн прокурор л яллагдагчаар татдаг журам манайд бий. Хэрэг дээрээ мөрдөн байцаалтын маш чухал

хэлбэр учраас энэ нь Үндсэн хуулийн зөрчилд тооцогдох үндэслэлтэй. Хэрэв прокурорын өнөөгийн чиг үүрэгт зарчмын шинж чанартай өөрчлөлт хийхгүй бол энэ дутагдал давтагдсаар байх болно.

Эрүүгийн байцаан шийдвэрлэх ажиллагааг улам боловсронгуй болгохын тулд яллах, өмгөөлөх чиг үүргүүдийн үйлчлэх хүрээ хязгаарыг адил тэгшээр өргөсгөн тэлэх явдал. Тухайлбал, мэтгэлцэх зарчмыг мөн чанараар нь /урьдчилан/ мөрдөн байцаалтын шатанд үйлчлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх шаардлагатай.

Төсөлд шүүгдэгчид /ялтанд/ оноосон ял зэмийг анхан шатанд дахин буцаахгүйгээр давж заалдах журмаар хүндрүүлж болохоор тусгасан нь нэлээд маргаан дэгдээж болзошгүй байна. Учир нь давж заалдах эрхэнд элдэв "шахалт дарамт" үзүүлэхийг олон улсын гэрээ хэлэлцээрүүдээр хориглосон байдаг. Бүр тодруулбал хүндрүүлэх "эсэргүүцэл" гомдол гарсан ч дээд шатны шүүх түүнийг шууд шийдвэрлэдэггүй, заавал буцааж засуулдаг. Энэ нь хэлбэр талаасаа хүнд суртал, чирэгдлийн хэлбэртэй боловч нотлох баримтуудыг үнэлэх, дүгнэлт өгөх эрх хэмжээний тухай шүүн таслах шатуудын хооронд тогтсон нийтлэг жишиг, ял шийтгүүлсэн этгээдийн давж заалдах эрхийн хамгаалалт, мэтгэлцэх зарчим /мэтгэлцээн биш !!/ үйлчлэх хүрээ хязгаараас шууд хамааралтай. Хэрэг дээрээ давах болон хяналтын шат нь эцэс төгсгөлгүй маргаан өрсөлдөөний талбар биш, шүүн таслах ажиллагааг алдаа мадаггүй байлгах шүүлтүүр болдог. Тиймээс эрх зүйн хоёр янзын тогтолцоонд "оршин тогтнож" ирсэн "апелляция" "кассация" хэмээх уламжлалт хоёр хэлбэрийн ерөнхий зарчимд тулгуурлаж төсөлд байгаа маргаант асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй.

Манай Үндсэн хуулийн 2 дугаар бүлэгт хүний халдашгүй эрх, эрх чөлөө олон улсын жишигт хүрэн баталгаажсаныг дотоод гадаадад хүлээн зөвшөөрдөг. Гагцхүү түүнийг салбар хуулиудад онцлог шинж чанар, утга агуулгыг нь харгалзаж тусгаж өгөх шаардлагатай юм. Тухайлбал, төсөлд "сэжигтэн" гэдэг тодорхойлолтыг өгөхдөө түүнийг албадан саатуулах үндэслэлтэй нь хольж хутгасан байна. Сэжигтэн нь эрүүгийн байцаан шийтгэх ажилгааны түр зуурын оролцогчид тооцогддог. Өөрөөр хэлбэл,

албадан саатуулагдсан буюу таслан сэргийлэх арга хэмжээний аль нэгээр эрхээ хязгаарлуулсан этгээдийг "сэжигтэн" хэмээн нэрлэдэг.

Ийм хязгаарлалт тавиагүй болоод манайд сэжигтнээр тооцох хугацаа тодорхой биш, бараг, хэргийн хөөн хэлэлцэх хугацаанд сэжиглэж болохоор ойлгогдож байна. Харамсалтай нь практик ажилтнууд хэвлэл мэдээллийн хэрэгслээр ийм тайлбар олонтаа хийдэг. Жишээлбэл, Батыг хүн амины хэрэгт сэжиглэж шалгаад дараа нь цагдан хорихоос өөр таслан сэргийлэх арга хэмжээ аван "гадуур гаргасан" үед сэжигтэн байх хугацаа нь тоологддоггүй мэт андуу ойголт сүрхий газар авсан. Ямар хэлбэртэйгээс үл хамаарч, таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан л бол 14 хоногийн дотор багтааж ял сонгож яллагдагчаар татна. Яллагдагчаар татаагүй бол тэр этгээд сэжигтэн байх учиргүй.

Ер нь цаашид хүнийг хэдэн удаа "сэжиглэж" болох нарийн журам тогтоох шаардлагатай. Эс тэгвээс дээр жишээ болгон авсан Батыг "бараг бүх насаар нь" ахин дахин сэжиглэж болох хуулийн үндэслэл уламжлагдан үлдэнэ.

Даширамд дурьдахад олон улсын баримт бичгүүдэд хүнийг аль болохоор богино хугацаанд сэжиглэж, яллагдагчаар татаж шүүхэд шилжүүлэх ёстой гэдгийг тунхаглан зааж өгсөн байдаг. Иймээс ч "шинэ" нөхцөл байдлаар "дахин сэжиглэх нь" хуулийн тун нарийн зохицуулалттай байхаас аргагүй.

Шүүхэд төр төдийлөн яллах чиг үүрэг бүхий прокурорын хяналтын эцсийн зорилго нь мөрдөн байцаалтынхантай давхцаж байдгийг хэн ч үгүйсгэхгүй биз. Иймд мөрдөн байцаалтын шатанд хүний эрх, эрх чөлөө, хувийн болоод захидал харилцаа, орон байрны халдашгүй байдлыг хязгаарлах ажиллагаанд гомдол гарсан үед зөвхөн шүүхээр эцэслэн шийдвэрлэдэг байх нь ардчилсан нийгмийн шаардлагад илүү нийцэх тавилантай.

Цаашидаа мөрдөн байцаагч, эрүүгийн хэрэг бүртгэгч зэрэг хүний эрх, эрх чөлөөнд хязгаарлалт тавих эрх бүхий албан тушаалтны ажиллах боломж, нөхцөл, баталгааг аль болохоор бүрдүүлж тусгай хуулиар энэхүү чухал эрхийг нь олгодог журамтай болох нь зүйтэй. Түүнчлэн мөрдөн байцаах, хэрэг бүртгэх эрхийг аль болохоор салбарын хүрээнээс гаргаж нэгдмэл төвлөрсөн шинж

чанартай болгох нь зүйтэй.

Судалгаанаас үзэхэд гааль, татвар, цэргийн хэрэг бүртгэх албаны үйл ажиллагаанд салбарын удирдах дээд албан тушаалтнаас шахалт үзүүлэх, нөлөөлөхийг оролдох явдал цөөнгүй гарсан тохиолдол бий.

Ер нь эрүүгийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий хүмүүсийг томилох, чөлөөлөхөд Улсын прокурорыг заавал оролцуулдаг, бас хугацааны хувьд ч бодолцох цаг болсон.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн төсөлд шаардлагатай нэр томъёог тов тодорхой тайлбарлах хэрэгтэй байна. Тэгэхдээ процесс ажиллагаатай нь нягт уялдуулж өгөх нь зүйтэй. Зүйрлүүлбэл, анхан болон давж заалдах шатны шүүхийн тухай бус анхан шатны журмаар, давах шатны журмаар гэдгийг л тайлбарт оруулъя.

Дээр дурьдсан ерөнхий цөөн асуудлыг хөндөхдөө төслийг боловсронгуй болгох онол практикийг олон чухал сэдвүүдийг цаашид нэг бүрчлэн авч үзэх шаардлагатай байгааг дурьдах нь зүйтэй биз.

Тухайлбал, нотлох баримтын тухай ойлголт, нотлох баримтын эх сурвалжийг шинээр авч үзэх шаардлага, нотолгооны үе шатуудыг нарийвчлан тодорхойлох асуудал үнэхээр эгзэгтэй, ээдрээтэй хэвээр үлдсэн.

Урьдчилсан байдлаар гэм бурууг тогтоох хэлбэр, түүнийг хэрхэн нотлох тухай баримт сэлт мэдээллийг шүүх хуралдааны үед яаж хянаж, шалгах, харьцуулан дүгнэж, дотоод итгэл дээрээ үнэлэх вэ? гэх зэрэг нэг мөр болгон шийдэх олон зүйл заалт байгааг уг төслийг боловсруулж буй ажилтнууд, эрдэмтэн, судлаачид мэргэн оюундаа тунгаан шийдэх буй за.

ГЭМТ ХЭРЭГТ ХАМТРАН ОРОЛЦОХЫН ОНОЛ, ПРАКТИКИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Суурийн ЖАНЦАН

Хууль зүйн шинжлэх ухааны доктор

Гэмт хэрэгт хамтран оролцохын төрөл, хэлбэр: Эрүүгийн эрх зүйн онол судлагдахуун бол нийгэмд аюултай, хуулиар хориглосон, гэм буруутай тодорхой гэмт хэрэг, түүний нийгмийн хор аюулд тохирсон ял байдаг болохоор эрүүгийн эрх зүйн ангилал нь юуны өмнө гэмт хэрэг, ялын төрөл хэмжээнээс шууд шалтгаална. Энэ шаардлага нь гэмт хэрэгт оролцохыг тодорхой хэлбэрт ангилан үзэхэд нэг адил хамаарна. Гэмт хэрэгт хамтран оролцох үйл ажиллагааг тодорхой хэлбэрт ангилахын тулд хэд хэдэн оролцогчдын хамтын ажиллагааны шинж чанар, оролцож байгаа гэмт хэргийн нийгмийн хор аюул, мөн түүнчлэн хамтран оролцогчдын субъектив /сэтгэл зүйн/ хөлбоо, харилцан тохиролцсон байдлын түвшин, гэмт бүлэглэлийн зохион байгуулалтын шинж байдал, оролцогчдын шинж байдал, оролцогчдын харилцан ажиллагааны арга зэрэг шалгууруудыг бас харгалзах нь зүйтэй юм.

Бүлэг хэднй чинээ бат нэгдэлтэй, оролцогчид нэгдмэл зорилготой байх тусам гэмт санаа зорилгоо хялбар хэрэгжүүлэх үндэс болдог. Нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэл, түүнчлэн гэмт хэрэгт хамтран оролцохын нийгэмд аюултай, тухайн гэмт хэргийн хувьд түгээмэл байгаа хэлбэрийг эрүүгийн хариуцлагын чангаруулах нөхцөл байдал болгон Эрүүгийн хуульд заах /хуульчлах/ үйл явц нь юуны өмнө гэмт хэрэг хамтран үйлдэх ажиллагааны нийгэм, сэтгэл зүй, криминологийн судалгааны үр дүнд тулгуурласан байх ёстой бөгөөд

А/ Тодорхой гэмт үйл ажиллагаа түгээмэл гарч байгаа, нийгмийн аюул ихтэй болох тухай мэдээлэл авч, үнэлэх,

Б/ Ийм үйлдэл гарч байгаагийн шалтгаалан нөхцөл, тарьж буй хор уршгийн шинж байдлыг судлах,

В/ Тэдгээрийн явуулах тэмцлийн ирээдүйн хандлагыг тодорхойлох /прогнозчлох/, эцэст нь

Г/ Эрүүгийн хуульд шинэ хэм хэмжээг боловсруулж тусгах шийдвэр гаргах, хуулийн төсөл боловсруулж батлуулах зэрэг хэд хэдэн үе шатыг дамжих ёстой.

Энэ үе шатыг дамжаагүй Эрүүгийн хуульд оруулсан хэм хэмжээ үйлчилдэггүй болохыг амьдрал харуулсан. Тухайлбал 1986 онд улсын тэмдэгтэй үслэг ангийн үнэт арьсыг улсад тушаах журам зөрчих, нийгмийн тустай хөдөлмөрөөс ноцтой зайлсхийх зэрэг үйлдэл, эс үйлдлийг гэмт хэрэгт тооцож Эрүүгийн хуульд оруулсан боловч манай нөхцөлд тохирохгүй хууль байсаар 1993 онд хасагдсан.

1986, 1993 онд гэмт үйл ажиллагаанд хамтран оролцохын түгээмэл хэлбэр болох гэмт хэргийг урьдчилан тохиролцож хамтран үйлдэх, зохион байгуулалттай бүлэг этгээд үйлдэх хоёр хэлбэрийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн олон зүйл, хэсэгт хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдал болгон хуульчилсан нь бүлэг гэмт явдалтай тэмцэх, хариуцлагыг ялгавартай оногдуулахад чухал ач холбогдолтой болсон юм.

Гэмт хэрэгт хамтран оролцохын дээрх хэлбэрийг объектив талыг нь хамтын хүч чармайлтаар хэрэгжүүлдэг бүх гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл байдал болгон хуульчилж чадсан эсэх нь өөр асуудал юм.

Эрүүгийн эрх зүйн тусгай ангийг судалж үзэхэд урьдчилан тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг гэмт хэрэг үйлдсэнийг өмчийн эсрэг гэмт хэргүүд тухайлбал, хулгайлах, булаах, дээрэмдэх, залилан мэхлэх, түүнчлэн аж ахуйн эсрэг гэмт хэргүүд тухайлбал, хэрэглэгчдийг хуурч мэхлэх, эд зүйлсийг улсын хилээр хууль бусаар нэвтэрүүлэх, хориглосон үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэх, мөнгөн тэмдэгт, үнэт цаасыг хуурамчаар үйлдэх, борлуулах, хээл хахууль авах, өгөх, хорих газраас оргох зэрэг хамтран үйлддэг гэмт хэргүүдийг хүндрүүлэх, онц хүндрүүлэх нөхцөл байдал болгон хуульчилсан явдал амьдралын бодит шаардлагыг харгалзсан оновчтой шийдэл юм.

Гэвч объектив талыг нь бүлэглэн хэрэгжүүлж болох танхайрах, агаарын хөлгийг авч зугтаах зэрэг гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэх тухай Эрүүгийн хуулийн хэм хэмжээнд хэд хэдэн этгээдийн хамтарсан үйл ажиллагаанд хариуцлагыг чангаруулах заалт байхгүй байгаа нь учир дутагдалтай санагдана. Иймд

Эрүүгийн хуулийн тусгай ангийн холбогдох зүйл хэсэгт энэ чиглэлээр өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Хамтран оролцохын тодорхой хэлбэрт ангилах гол үндэслэл бол үйлчилж буй Эрүүгийн хуулийн хэм хэмжээ юм.

Эрүүгийн хуулийн заалтыг үндэслэн хамтран оролцохыг онолын үүднээс 1. Ердийн хамтран оролцох гэмт хэргийн урьдчилан тохиролцож буюу тохиролцохгүйгээр бүлэглэж үйлдэх, 2. Урьдчилан тохиролцож хамтран оролцох,

3. Хамтран оролцох,

4. Зохион байгуулалттай бүлэг,

5. Гэмт байгууллага /мафи/ гэсэн хэд хэдэн бие даасан хэлбэрт авч үзэж болох юм. Эрүүгийн хэрэг бүр дээр хамтран оролцохын хэлбэрийг зөв тодорхойлох нь бүлэг гэмт этгээдүүдийн үйлдлийг үүргээ хуваарилж буюу хуваарилалгүйгээр оролцсоныг харгалзан Эрүүгийн хуулийн 16 дугаар зүйлийг журамлах буюу журамлахгүйгээр тусгай ангийн хэм хэмжээгээр хариуцлагыг ялгавартай хүлээлгэх боломж олгодог.

Ердийн бүлэг: Хамтран оролцохыг тодорхой хэлбэрт ангилах нэг гол шалгуур бол хамтран оролцогчдын хоорондын бодит тохиролцоо юм. Нийгмийн хор аюул багатай хамтран оролцохын хэлбэр бол урьдчилан тохиролцохгүйгээр гэмт хэрэгт хамтран оролцох өөрөөр хэлбэл ердийн бүлэг юм. Урьдчилан тохиролцоогүй гэмт хэрэгт хамтран оролцох гэдэг нь гэмт этгээдүүд гэмт хэрэг үйлдэх тухайгаа хоорондоо тодорхой ярьж тохиролцоогүй, эсвэл ярьж тохиролцсон боловч өнгөц, тодорхойгүй байхыг хэлнэ.

Энэ тохиолдолд тэдний субъектив холбоо нь нэг оролцогч бусад оролцогчтой хамтран үйл ажиллагаа явуулна гэдгийг л өнгөц мэдэж байгаагаар хязгаарлагдана. Өөрөөр хэлбэл хэн ямар үүрэгтэй оролцох нь тодорхой байна. Тэдний хоорондох субъектив /сэтгэл зүйн/ холбоо нь гэмт хэрэг үйлдэж эхлэх үед болон түүний явц дунд бий болно. Ийм өнгөц холбоо харилцаатай байгаа нь бүлгийн гишүүд гэмт хэргийг хэрхэн, ямар арга, хэрэглэхээр хэдийд үйлдэх, хэргийн ул мөрөө хэрхэн нуун далдлах талаар тохиролцох боломж олгодоггүй. Тэдэнд хариуцлага хүлээлгэхэд тухай гэмт хэрэгт хоёр ба түүнээс дээш тооны хүмүүс хамтран оролцож, гэмт хэргийн объектив талыг хамтран

хэрэгжүүлсэн байх явдал хангалттай үндэслэл болно.

Бусдын эрүүл мэнд, эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэргүүдийг гол төлөв бүлэглэн үйлдэх нь түгээмэл байгааг харгалзан хууль тогтоогч бусдын бие махбодид хөнгөн гэмтэл учруулах /Эрүүгийн хуулийн 98 дугаар зүйлийн 2 дахь хэсэг/, зодох /99 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг/, хүчиндэх /112 дугаар зүйлийн 2 дахь хэсэг/, бие биедээ захирагдахгүй цэргийн албан хаагчид харилцахдаа дүрмийн заалт зөрчих /226 дугаар зүйлийн 3 дахь хэсэг/ зэрэг гэмт хэргийг бүлэглэн үйлдвэл хариуцлагыг хүндрүүлэх, онц хүндрүүлэх нөхцөл болгон хуульчилсан байна.

Бүлэглэж үйлдвэл гэж зааснаас үзэхэд дээр дурьдсан гэмт хэргийг үйлдэхдээ субъектүүд урьдчилан тохиролцсон байхыг шаардахгүй байна. Энэ нь нэр дурьдсан хүч хэрэглэсэн гэмт хэргүүд нь ихэнх тохиолдолд гэнэт үүссэн шууд санаагаар, ахуйн сэдэлтээр үйлдэгддэгтэй холбоотой юм. Түүнчлэн засгийн төлөөлөгч, цагдаагийн ажилтнуудын хууль бус үйл ажиллагааг эсэргүүцэж эхэлсэн үйлдэл нь аажмаар олон хүнийг хамарч нийтийн эмх замбараагүй байдал бий болгоход гол төлөв урьдчилан тохиролцоогүй аяндаа нэгдсэн бүлэг оролцдог. Бүлэглэн зодолдох ч мөн ийм урьдчилан тохиролцоогүй байдаг онцлогтой.

Урьдчилан тохиролцсон бүлэг: Гэмт явдалтай тэмцэх практик ажиллагаанд түгээмэл тархсан хэлбэр бол урьдчилан тохиролцож гэмт хэрэгт хамтран оролцох явдал юм. Урьдчилан тохиролцсон бүлэг гэмт хэрэг үйлдэх гэдэг нь хоёр ба түүнээс дээш этгээд тухайн гэмт хэргийн объектив талыг хэрэгжүүлж эхлэхээс өмнө гэмт хэргийг үйлдэхэд хэрхэн хүчээ нэгтгэх талаар тохиролцсон байхыг ойлгоно. Монгол Улсын Дээд Шүүхийн Бүгд Хурлын 1991 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 12 дугаар тогтоолд "Бусдын эд хөрөнгийг урьдчилан тохиролцсон бүлэг этгээд ашиглан шамшигдуулах гэдэг нь хэрэг үйлдэхээр урьдчилан ярилцаж үйл ажиллагаагаа зохицуулсан хоёр буюу түүнээс дээш хүн хэрэг үйлдэхийг ойлгоно"¹ гэж тайлбарлажээ.

Гэмт үйл ажиллагааг зохион байгуулагч, хатгагч, хамжигч, гүйцэтгэгч нь ямагт үүргээ хуваарилах талаар харилцан тохиролцож гэмт хэрэгт хамтран оролцдог. Урьдчилан

¹ БНМАУ-ын Дээд шүүхийн бүгд хурлын тогтоолын эмхтгэл.

тохиролцоо нь шинж чанарын хувьд янз бүрийн агуулга, хэлбэртэй байж болно.

Үйлдэх гэж байгаа гэмт хэрэг нийгмийн хор аюул ихтэй, олон хүний хамтарсан ажиллагаа зайлшгүй шаардлагатай тохиолдолд тохиролцоо нь бүх асуудлаар, тухайлбал хэрхэн, ямар нөхцөлд хэзээ гэмт хэргийг үйлдэх, хэн ямар үүрэгтэй оролцох, тохиолдож болох саад, бэрхшээлийг хэрхэн гэтлэн давах, гэмт хэргийн ул мөрийг хэрхэн нуух, баллах, гэмт хэргийн замаар олох эд хөрөнгийг хэрхэх зэрэг асуудлаар нарийвчлан хэлэлцэж тогтсон байна.

Ингэж ул суурьтай тохиролцохыг нийгмийн эмх замбараагүй байдал бий болгох, бусдын өмчийг хулгайлах, булаах, үрэгдүүлэх, завших, албан тушаалын байдлаа ашиглан бусдын эд хөрөнгийг ашиглан шамшигдуулах зэрэг гэмт хэргүүд шаардана. Тийм учраас Эрүүгийн хуульд хулгайлах, булаах /Эрүүгийн хуулийн 123-124 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг/, Бусдын эд хөрөнгийг завшиж, үрэгдүүлэх, эсвэл албан тушаалын байдлаа урвуулж ашиглан шамшигдуулах /Эрүүгийн хуулийн 126 дугаар зүйлийн 2 дахь хэсэг/, Залилан мэхлэх /127 дугаар зүйлийн 1 дэх хэсэг/, Бусдын эд хөрөнгийг бага хэмжээтэй ашиглан шамшигдуулах /131 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг/, Хэрэглэгчдийг хуурч мэхлэх /170 дугаар зүйлийн 2 дахь хэсэг/, Хорих газраас оргох /211 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг/, Авто тээврийн хэрэгсэлийг авч зугатаах /267 дугаар зүйлийн 2 дахь хэсэг/ зэрэг хэргүүдийг урьдчилан тохиролцсон бүлэг этгээд үйлдвэл хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдал болгон заасан нь ялын зорилгыг хангахад ач холбогдолтой юм.

Гэмт хэргийг хамтран гүйцэтгэх хэлбэр: Зохион байгуулалтын түвшин, шинж чанараараа хамтран оролцох нь гэмт хэргийн объектив талыг хамтран гүйцэтгэх болон үүргээ хуваарилж хамтран үйлдэх хэлбэртэй байж болно.

Нэг дэх тохиолдолд бүлгийн гишүүд тухайн гэмт хэргийн объектив талыг хэрэгжүүлэхэд шууд оролцож өөрийн хувь нэмрээ бодитойгоор оруулна. Хоёр дахь тохиолдол бол нэг гэмт хэргийг үйлдэхэд хэн ямар үүрэг гүйцэтгэхээ урьдчилан хуваарилаж, тэр оногдсон үүргээ биелүүлж оролцоно. Жишээ нь гурван этгээд бусдын эд хөрөнгийг орон сууцнаас хулгайлах гэмт хэргийг

хамтран үйлдлээ гэж бодоход нэг нь орцонд хүн харах, нөгөө этгээд айлд орж, эд зүйлийг авах, гурав дахь этгээд хулгайлсан эд зүйлийг авч яваад боломжтой газар нуух үүрэг биелүүлж оролцож болно. Энэ тохиолдолд гурвуулаа өөр өөр үүрэг гүйцэтгэсэн мэт харагдаж байгаа боловч хамтран гүйцэтгэгчид болж тус тусдаа биеэ даасан гэмт хэргийн субъект болж хариуцлага хүлээнэ. Дээрх тохиолдолд гурван этгээдэд Эрүүгийн хуулийн 123 дугаар зүйлийн 2 дахь хэсгээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх ёстой.

Зохион байгуулалттай бүлэг: Сүүлийн жилүүдэд өмчийн болон аж ахуйн эсрэг зарим гэмт хэргүүдийг өндөр зохион байгуулалттай аргаар үйлдэх болсныг харгалзан 1993 онд эрүүгийн хуульд зохион байгуулалттай бүлгийн хууль цаазны шинжүүдийг анх удаа хуульчлан бататгав. Хууль тогтоогч Эрүүгийн хуулийн 16\1 дүгээр зүйлд гэмт хэрэг үйлдэхийн тулд урьдчилан нэгдэж зохион байгуулагдсан бөгөөд тогтвортой ажилладаг 2 буюу түүнээс дээш этгээдийг зохион байгуулалттай бүлэг гэсэн тодорхойлолт өгөхийн зэрэгцээ Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан бусдыг санаатай алах /Эрүүгийн хуулийн 86 дугаар зүйлийн "к"/, хар тамхи мансууруулах болон хордуулах бодис, буу зэвсэг хууль бусаар хил нэвтрүүлэх /Эрүүгийн хуулийн 74 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг/, дээрэмдэх /Эрүүгийн хуулийн 125 дугаар зүйлийн 2 дахь хэсэг/, бусдын эд хөрөнгийг завшиж үрэгдүүлж, эсвэл албан тушаалынхаа байдлыг урвуулж ашиглан шамшигдуулах /Эрүүгийн хуулийн 126 дугаар зүйлийн 3 дахь хэсэг/, хулгайлах, булаах /Эрүүгийн хуулийн 123-124 дүгээр зүйлийн 4 дэх заалт/, бусдын эд хөрөнгийг авахаар далайлган сүрдүүлэх /Эрүүгийн хуулийн 130 дугаар зүйлийн 2 дахь хэсэг/, эд зүйлийг хууль бусаар нэвтэрүүлэх /Эрүүгийн хуулийн 172¹ дүгээр зүйлийн 2 дахь хэсэг/, хориглосон үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ явуулах /Эрүүгийн хуулийн 175¹ дугаар зүйлийн 2 дахь хэсэг/, мөнгөн тэмдэгт хуурамчаар үйлдэх, борлуулах /Эрүүгийн хуулийн 179¹ дүгээр зүйлийн 2 дахь заалт/, хээл хахууль авах, өгөх /Эрүүгийн хуулийн 195, 196 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг/, хорих байгууллагын захиргааны шаардлагад захирагдахгүй байх /Эрүүгийн хуулийн 213 дугаар зүйлийн 2 дахь хэсэг/, албан татвар төлөхөөс санаатайгаар зайлсхийх /Эрүүгийн хуулийн 227 дугаар

зүйлийн 2 дахь хэсэг/, мансууруулах бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах / Эрүүгийн хуулийн 254 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг/ зэрэг 16 төрлийн хүнд, онц хүнд гэмт хэргийг зохион байгуулалттай бүлэг этгээд үйлдвэл хариуцлагыг онц хүндрүүлэх нөхцөл байдал болгон анх удаа хуульчилсан нь гэмт хэрэгт хамтран оролцохын аюултай хэлбэртэй хийх Эрүүгийн эрх зүйн тэмцлийг хүчтэй болгоход ач холбогдолтой болсон юм. Зохион байгуулалттай бүлэг этгээд гэмт хэрэг үйлдсэн нөхцөлд хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдал болгон заагаагүй бусад гэмт хэргийг зохион байгуулалттай бүлэг үйлдвэл Эрүүгийн хуулийн 36 дугаар зүйлийн "б"-г журамлан хариуцлагыг хүндрүүлж хэрэглэж болно. Гэмт хэргийг зохион байгуулалттай бүлэг этгээд үйлдсэн бол бүлгийн гишүүдийн оруулсан хувь нэмэр, оролцооны шинж чанар агуулгыг үл харгалзан хариуцлагыг бүлгээрээ хүлээлнэ. Харин аль нэг гишүүн бүлгийн тохиролцооны хүрээнд багтахгүй өөр гэмт хэргийг бие даан үйлдсэн бол тэр хэргийнхээ төлөө ганцаараа хариуцлага хүлээнэ.

1994 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн УДШ-ийн Бүгд Хурлын 35 дугаар тогтоолд: "Гэмт хэрэг үйлдэх явдлыг орлогын эх үүсвэр болгон эрхлэх зорилгоор урьдчилан нэгдэн нийлж, удирдагч, гүйцэтгэгчээ томилох, үүрэг ролио хуваарилах зэргээр зохион байгуулалтын бүтэц бий болгосон хоёр буюу түүнээс дээш хүмүүсийн нэгдлийг /хамтлагыг/ зохион байгуулалттай бүлэг гэж үзнэ" гэж заасан.

Профессор С.Нарангэрэл "Зохион байгуулалттай бүлэг нь ямар гэмт хэргийг хэзээ, хаана, хэрхэн үйлдэх, энэхүү гэмт хэргийг үйлдэхэд бүлгийн гишүүд ямар үүрэг гүйцэтгэх, гэмт хэргийн ул мөрийг арилгах, гэмт хэрэг үйлдэх замаар олсон орлогоо хуваарилах зэрэг асуудлыг илүү өндөр түвшинд тохиролцон, төлөвлөсөн шинжтэй байдаг"² гэж үндсэн шинжийг оновчтой тодорхойлжээ. УДШ зохион байгуулалттай бүлгийн шинжид "тогтвортой ажилладаг"-ийг хамруулж, тус бүлэгт нэгдэн орсон этгээдэд тодорхой гэмт хэрэг үйлдэх эсэхээс үл хамааран харилцан

УБ., 1991, No.4,41 дэх тал

² С.Нарангэрэл "Зохион байгуулалттай гэмт хэрэг". УБ., 1992.

холбоо харилцан ажиллагаа нь байнгын шинж чанартай байх явдал"³ Зохион байгуулалттай бүлэг нь урьдчилан тохиролцсон бүлэг этгээдээс ялгагдах гол шинж нь бүлгийн гишүүд гэмт хэрэг үйлдэх явдлыг орлогын эх үүсвэр болгох зорилгоор урьдчилан нэгдэж, зохион байгуулалтад орсон байхаас гадна энэхүү гэмт үйл ажиллагааг тогтвортой эрхлэх хандлагатай байдагт оршино.⁴ Гэмт байгууллага: Гэмт хэрэгт хамтран оролцохын тулд өндөр зохион байгуулалттай, бат бэх нэгдэлтэй, байнгын гэмт үйл ажиллагаа явуулах зорилготой хэлбэр бол гэмт байгууллага / мафи/ юм. Манай Эрүүгийн хуулийн тусгай ангийн хэд хэдэн зүйлд ийм байнгын шинжтэй тодорхой зорилго бүхий гэмт бүлэг зохион байгуулсныг биеэ даасан, төгссөн гэмт хэрэг байхаар хуульчилсан нь ийм бүлэг ямагт нийгэмд аюултай, хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдэх магадлалтай байдагтай холбоотой юм. Тухайлбал "төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, авахаар завдахыг хориглоно гэсэн Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн 60.1 дүгээр зүйлд" төрийн эрх мэдлийн Үндсэн хуулийн бус аргаар авах зорилго бүхий хуйвалдаан зохион байгуулах, түүнчлэн 73 дугаар зүйлд "улс хоршоолол, олон нийтийн болон хувийн үйлдвэр, албан газар, байгууллага болон иргэдэд халдан довтлох зорилгоор зэвсэг бүхий бүлэг зохион байгуулсан . . ." 75 дугаар зүйлд ". . . нийтийн эмх замбараагүй байдлыг зохион байгуулсан . . ." 111 дүгээр зүйлд "бусдад биеэ байнга үнэлж явалдахыг /янхан/ зохион байгуулсан . . ." зэрэг нийгмийн хор аюул ихтэй үйлдлийг гэмт хэрэгт тооцсон байна. Хүнд буюу онц хүнд гэмт хэрэг үйлдэхийн тулд буй болсон, нягтарсан ба зохион байгуулалттай бүлгийг гэмт байгууллага гэж тодорхойлж болох юм. Гэмт байгууллагын гишүүдийн \бат бэх нэгдэлтэй\ байдал нь гэмт хэргийн орлогоос татварын нэгдмэл сан бий болгож, материалын талаар хангагдахаас гадна тагнан турших, лоббидох, хахуульдах, "нууц явууллага хийх", "тусгай зэвсэгтэй" хоорондын харилцааны хатуу дэг жаягт гэмт байгууллагад тогтсон журам, дүрмийг зөрчвөл хүлээлгэх

³ Эрүүгийн хуулийг тайлбарласан УДШ-ийн Бүгд Хурлын тогтоолуудын эмхтгэл. УБ., 1995. 127-128 дэхь тал

⁴ С.Нарангэрэл "Монгол Улсын эрүүгийн эрх зүй" /сөрөнхий анги\ 1997. 242-243 дахь тал

хариуцлагатай /шийтгэл/, нутаг дэвсгэр ба эрх мэдэл эзэмшихийн төлөө чармайсан, босоо, шатлан захирах дэг ёстой, төр засаг, хууль хамгаалах байгууллагын эрх мэдэл бүхий албан тушаалтнуудыг байгууллагадаа багтаан хамтран ажилладаг зэрэг шинжээрээ илэрдэг⁵ гэж профессор Г.Совд, С.Нарангэрэл нар тодорхойлжээ. Гэмт байгууллагын үйл ажиллагаатай хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд эвлэршгүй тэмцэл хийх үүрэгтэй цагдаа, прокурор, шүүх, аюулгүй байдлыг хангах байгууллагын албан тушаалтнууд өөрсдөө тэр байгууллагын ажиллагаанд татагдан ордог нь зохион байгуулалттай гэмт хэргээс ялгагдах онцлог юм.⁶

Өнөөдрийн байдлаар олон улсын хэмжээнд гэмт ажиллагаагаа хэрэгжүүлдэг 700 гаруй толгойлогч, 300 мянга орчим гэмт хэрэгтэн бүхий Оросын мафи, 1000 орчим толгойлогч, 400 мянга орчим гишүүнтэй Колумбын мафи, 40-50 мянган гишүүнтэй гэмт хэргийн 130 бүлэгт багтдаг Италийн Сицилийн /Коза-Ностра/, 6000-аад гишүүн бүхий 100 гаруй бүлэглэлтэй Калабриягийн мафи, түүнчлэн Турк, Мексик, Хятад, Японы мафиуд олон оронд үйл ажиллагаагаа явуулж байгаа нь сэтгэл түгшээж байна.⁷

НҮБ мөнгө луйвардах, үнэт зүйл дээрэмдэх, оюуны болон урлагийн үнэт бүтээл, соёлын дурсгалт зүйлийг хулгайлах, хууль бусаар зэвсэг худалдах, онгоц тээврийн хэрэгсэл дээрэмдэх /авч зугатах/, далайн дээрэм хийх, компьютерийн гэмт хэрэг үйлдэх, хүний эд эрхтэн наймаалах, хүн хулгайлан наймаалах, мансууруулах бодис наймаалах, хуурамч дампуурал зарлах зэрэг мафиин 17 түгээмэл төрлийг нэрлэж эдгээртэй тэмцэхийг дэлхийн олон нийтэд уриалж байна.

Гэмт хэрэгт хамтран оролцохын төрөл: Гэмт хэргийн объектив талыг хэрэгжүүлэхэд гүйцэтгэсэн оролцогч бүрийн үүргийг тогтоох зорилгоор тэднийг тодорхой төрөлд ангилан авч үзэх шаардлага гардаг. Тэгээд ч энэ ангилалыг Эрүүгийн хуулийн 16

⁵ Г.Совд "Монгол Улсын эрүүгийн шалт" (өнөөгийн асар), Монголын төр эрх зүй, 1996 No.1, 32 дахь тал

⁶ С.Нарангэрэл "Монгол Улсын эрүүгийн эрх зүй" УБ., 1997, 243 дахь тал

⁷ "Засгийн газрын мэдээ" сонин, 1997.02.06, No.17

⁸ Д.Алтанбалар "Мафи" (гэмт байгууллага), УБ., 1997, 69-70 дахь тал

дугаар зүйлийн хоёр дахь хэсэгт маш тодорхой заасан байдаг. Гэмт хэрэгт оролцсон оролцогчдын шинж чанар, гүйцэтгэж байгаа үүргийг харгалзан оролцогчдыг зохион байгуулагч, гүйцэтгэгч, хатгагч, хамжигч гэсэн 4 үндсэн төрөлд ангилан судалдаг. Ийм ангилал нь оролцогч бүрийн үйл ажиллагааны хууль цаазны шинж чанарыг тодорхойлох, энэ үндсэн дээр хариуцлагыг ялгавартай хүлээлгэхэд онцгой ач холбогдолтой юм. Хамтран оролцогчид нь гүйцэтгэж байгаа үйл ажиллагааныхаа шинж чанараар хоорондоо ялгагдана.

Тухайлбал хамжигч хичнээн чухал үүрэг гүйцэтгэсэн байлаа ч хэзээ ч хатгагч, зохион байгуулагчийн үүрэг гүйцэтгэхгүй.

Гэмт хэргийн гүйцэтгэгч: Гэмт хэрэгт хамтран оролцож байгаа зохион байгуулагч, хатгагч, хамжигчийн үйл ажиллагаа нь зөвхөн гүйцэтгэгчийн үйлдлээр дамжин хэрэгждэг болохоор гүйцэтгэгч бол хамгийн гол оролцогч юм. Өөр өөр чиг үүрэг гүйцэтгэж байгаа бусад оролцогчид байгаа бол гүйцэтгэгчийн тухай биш зөвхөн гэмт хэргийн субъектын тухай асуудал яригдана. Иймд гэмт хэргийн гүйцэтгэгч, түүнчлэн зохион байгуулагч, хатгагч, хамжигч нар бие биенээсээ шууд хамаарах харцангуй ойлголт юм. Гүйцэтгэгчгүйгээр бусад оролцогчид, бусад оролцогчидгүйгээр гүйцэтгэгч гэсэн ойлголт байх ёстой.

Эрүүгийн хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "а"-д зааснаар гэмт хэргийг шууд гардан үйлдсэн этгээдийг гүйцэтгэгч гэнэ. Гүйцэтгэгч хэрэг хариуцах чадвартай, тодорхой насанд хүрсэн байх зэрэг гэмт хэргийн субъектын нийтлэг шаардлага, мөн түүнчлэн үйлдэж байгаа гэмт хэрэг нь тусгай субьекттэй бол түүнд тавигдах нэмэлт шаардлагыг тус тус хангасан байх ёстой.

Эрүүгийн эрх зүйн насанд хүрээгүй болон сэтгэл мэдрэлийн архаг өвчтэй, сэтгэл мэдрэлийн үйл ажиллагаа нь түр сарнисан, оюун ухааны хомсдол буюу өөр бусад хүнд өвчний улмаас хэрэг хариуцах чадваргүй болсон хүмүүсийг өөрийн гар хөл болгож, улмаар гэмт хэрэг үйлдүүлсэн өөрөө гэмт хэргийн субьект болох чадвартай хүмүүс гүйцэтгэгчид нэг адил тооцогдоно.

Насанд хүрээгүй, хэрэг хариуцах чадваргүйн улмаас бусдын шууд нөлөөгөөр үйлдсэн гэмт хэргийнхээ төлөө хүлээх хариуцлагаас суллагдаж байгаа нь тэднийг гар хөлөө болгосон этгээдүүдийг

хариуцлагаас суллах үндэслэл болохгүй бөгөөд тэд Эрүүгийн хуулийн тусгай ангийн холбогдох зүйл хэсгээр гүйцэтгэгч субъект болж хариуцлага хүлээх ёстой. Тухайн асуудлаар эрүүгийн эрх зүйн онол, шүүхийн практикт ингэж шийдвэрлэж ирсэн боловч өнөөг хүртэл хуульд тусгалаа олоогүй байгаа нь учир дутагдалтай юм.

Хамтран оролцож байгаа гэмт хэргийн объектив талыг бүрэн болон заримыг нь хэрэгжүүлсэн ч гүйцэтгэгч болно. Өөрөөр хэлбэл нэг гэмт хэргийн объектив талыг нэг биш хэд хэдэн гүйцэтгэгч хэрэгжүүлсэн тохиолдолд хамтран гүйцэтгэгчийн тухай асуудал яригдана. Хамтран гүйцэтгэгч бүр гэмт хэргийг төгс үйлдэхэд тус бүрдээ гар бие оролцож зөвхөн объектив талын нэг хэсгийг нь хэрэгжүүлсэн байдаг. Жишээ нь нэг гүйцэтгэгч хохирогчийн толгой уруу ташуураар хоёр удаа, нөгөө гүйцэтгэгч элэг рүү нь гараараа, гурав дахь нь хөлөөрөө ар нуруу уруу нь өшиглөх зэрэг хамтарсан үйлдлээр хүний амь насанд хүрсэн байвал хамтран гүйцэтгэгчид болно. Хохирогчийн алахад хэн ямар үүрэг гүйцэтгэсэнийг шүүх эмнэлэгийн шинжилгээгээр тогтоож, түүнийг ял оногдуулахад харгалзаж үзнэ. Хамтран гүйцэтгэгчдэд хариуцлага хүлээлгэхэд шүүхийн практикт тохиолдож байгаа бодит бэрхшээлийг харгалзан тэдэнд хариуцлага хүлээлгэх нийтлэг хэм хэмжээг Эрүүгийн хуульд нэн даруй оруулах шаардлагатай байна. Гүйцэтгэгчийн үйлдлийн агуулга, үр дүнгээс гэмт хэрэг төгс үйлдэгдсэн эсэх асуудал шууд шалтгаална. Хэрэв гүйцэтгэгч гэмт хэргийг төгсгөлд нь хүргээгүй бол бусад оролцогчид түүний нэгэн адил гэмт хэрэгт хамтран оролцохоор завдаснаар хариуцлага хүлээнэ. Харин гүйцэтгэгч гэмт хэргийн объектив талыг хэрэгжүүлэхээс сайн дураараа татгалзсан нь бусад оролцогчдыг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй. Учир нь тэд гэмт үйл ажиллагаагаа гэмт хэргийн урьдчилсан шатанд нэгэнт хэрэгжүүлсэн байдаг.

Гэмт үйл ажиллагааг зохион байгуулагч: Гэмт хэрэгт хамтран оролцогчоос хамгийн аюултай нь зохион байгуулагч юм. Эрүүгийн хуулийн 16 дугаар зүйлийн "б"-д зохион байгуулагч нь гэмт хэрэг үйлдэхийг зохион байгуулах болон бусад оролцогчдын үйл ажиллагааг удирдах чиг үүрэг гүйцэтгэхийг хоёрдмол утгагүйгээр заасан байна.

Зохион байгуулагч өөрийнхөө болон бусад хамтран оролцогчдын гэмт санаа, зорилгыг хамтарсан гэмт үйлдлээр хэрэгжүүлэхэд бүх үйл ажиллагаагаа чиглүүлнэ. Гэмт хэрэг үйлдэхийг зохион байгуулах гэдэг нь юуны өмнө гэмт үйл ажиллагаанд оролцох хүмүүсээ эрж олох, сонгон авах, тэднийг гэмт үйл ажиллагаанд татан оруулах, бүх талаар бэлтгэх, гүйцэтгэх үүргийг нь хуваарилах гэмт үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дагаж мөрдөх төлөвлөгөө боловсруулах, оролцогчдыг гэмт хэрэг үйлдэхэд шаардагдах багаж хэрэгсэлээр хангах, гэмт халдлагын объектыг сонгон авах зэрэг тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг хэлнэ.

Удирдах гэдэг нь хамтран оролцогч бүрийн үүргийг оноож, оролцогч бүр оногдсон үүргээ хэрхэн хэрэгжүүлэх талаар тус бүрд нь заавар зөвлөгөө өгөх, хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, гэмт хэргийн объектив талыг хэрэгжүүлэх талаар гүйцэтгэгч, бусад оролцогчдын үйл ажиллагааг нэгтгэн чиглүүлж, манлайлахыг хэлнэ. Зохион байгуулагч нь дээр дурьдсан зохион байгуулах, удирдах үйл ажиллагааг бүгдийг нь гүйцэтгэх албагүй бөгөөд гол нь гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэх, завдах болон үйлдэж эхлэх шатанд хамтран оролцогчдын гэмт үйл ажиллагааг нэг зорилгод чиглүүлж удирдсан байх явдал юм. Зарим тохиолдолд зохион байгуулагч нь гэмт хэргийн объектив талыг хэрэгжүүлэхэд хамтран гүйцэтгэгчгүйгээр оролцох тохиолдол байдаг ч энэ нь маш ховор юм. Энэ тохиолдолд хамтран гүйцэтгэгч болж Эрүүгийн хуулийн тусгай ангийн холбогдох зүйл хэсгээр хариуцлага хүлээнэ.

Зохион байгуулагч нь бусад оролцогчдыг тодорхой гэмт хэрэг үйлдэхэд удирдан чиглүүлж байгаагаа үйлдэх гэж буй гэмт хэргийн нийгмийн хор аюул, гэмт бүлгийн зорилго, түүнд хүрэх арга замыг ухамсарлан ойлгож, гэмт үйлдлийн улмаас учирч болох хохирлыг мэдэж, ингэхийг хүсэн ямагт гэмт буруугийн шууд санаатай байдаг.

Гэмт хэрэг үйлдэхэд хатгагч: Эрүүгийн хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "в"-д гэмт хэрэг үйлдэхэд өдөөн түлхсэн этгээдийг хатгагч гэж тодорхойлжээ.

Хатгагч гэдэг нь хэн нэг этгээдийг гэмт хэрэг үйлдэхэд өдөөн түлхсэн өөрөөр хэлбэл түүнд тодорхой гэмт хэрэг үйлдэх шийдмэг бодол санаа төрүүлэхийн тулд идэвхтэй үйл ажиллагаа явуулсан

этгээдийг хэлнэ. Эрүүгийн хуульд хатгагчийн тухай тодорхойлолт өгөхдөө тэр энэ үйл ажиллагаагаа хэрхэн, ямар аргаар хэрэгжүүлэхийг заагаагүй байна. Ер нь хатгагч үйл ажиллагаагаа явуулж, тодорхой нөхцөл байдал, хатгагч нөлөөнд нь татагдан орж байгаа этгээд хоёрын хоорондын харьцаа зэргийг харгалзан үзэхгүйгээр хатгах арга, хэрэгслэлийг тодорхойлох боломжгүй юм. Амьдралын туршлагаас харахад хүний хийхийг хүсээгүй үйлдлийг түүний хүсэл зоригоос гадуур албадан хийлгэхэд ердийн арга үр дүн өгөхгүй нь мэдээж юм. Хатгагч гол төлөв бусдыг гэмт хэрэг үйлдэхэд өдөөхдөө хүсэх, гуйх, ятгах, ямар нэгэн зүйл амлах, хахуульдах, өш хонзон атаа жотөөг нь дэвэргэх, ямар нэгэн хариуцлага хүлээхгүй мултарч болно гэж итгүүлэх, тушаах, үүрэг өгөх, цаашилбал занал хийлгэх, хүч хэрэглэх, хуурч мэхлэх зэрэг боломжийн бүх аргыг хэрэглэнэ.

Гэмт хэрэг үйлдэж байх үедээ хатгагч гараараа дохих зангах, заах, нүдээрээ ирмэх, толгой дохих, шүгэлдэх, бусад байдлаар нууц дохио өгөх зэргээр бусдыг гэмт хэрэг үйлдэхэд өдөөн чиглүүлдэг. Хатгагчийн хэрэглэж болох эдгээр аргууд нь хатгалгад өртөгдөж байгаа этгээдийг төөрөгдүүлэхэд бус гагцхүү гэмт хэрэг үйлдэх шийдвэр гаргуулахад чиглэнэ. Дээр дурьдсан аргуудаас албадлага, заналхийлэл нь аймхай хулчгар хүмүүсийг гэмт үйл ажиллагаанд өдөөн түлхэхэд үр дүнтэй нөлөөлдөг арга юм.

Албадлага нь биесийн хүчний болон сэтгэл зүйн агуулга хэлбэртэй байж болно. Биесийн хүчний албадлага нь хатгалгад өртөгдөж байгаа хүмүүс түүний ойр дотны хүмүүст хүч хэрэглэх, зодох, бие махбодид нь гэмтэл учруулах байдлаар хэрэгждэг бол сэтгэл зүйн албадлага нь бодитой хэрэгжих шинжтэй, элдэв төрлийн заналхийлэл байж болно. Хатгагч өөрийн удирдлагад байдаг хүмүүст тушаал даалгавар өгөх замаар тодорхой гэмт хэрэгт өдөөн түлхэж болно. Захирах даргын тушаал бол цэргийн албан хаагчдын хувьд заавал биелэгдэх учиртай. Тушаал биелүүлсний улмаас цэргийн албан хаагч нь үйлдлээрээ нийгэм, иргэдэд хохирол учруулсан бол тэр эрүүгийн ба бусад төрлийн хууль зүйн хариуцлагаас чөлөөлөгдөх бөгөөд тушаал өгсөн дарга өөрөө хариуцлага хүлээдэг журамтай. Энэ нь зөвхөн цэргийн албан хаагчдад төдийгүй бусад байгууллага аж хуйн нэгжийн удирдагч нарт нэгэн адил хамаарна.

Хатгагч нь зөвлөгөө өгөх, хүсэх, итгүүлэх зэрэг түгээмэл арга хэрэглэж бусдыг гэмт хэрэг өдөөдөг. Итгүүлэх арга хатгалгад өртөгдөж байгаа этгээдэд үйлдэх гэж байгаа гэмт хэргийн улмаас бий болох бодит үр дүн, тэр өөрт нь ямар ашигтай болох зорилгоор ингэх болсоныг ойлгуулахад туслана. Итгүүлэх нь олон дахин давтагдах удаан үргэлжлэх чанараараа бусад аргаас ялгагдана. Итгүүлэх явцдаа гэмт хэргийг хэрхэн үйлдэх, ул мөрөө яаж баллах талаар зөвлөгөө өгч болно. Хүсэлт нь хатгагчийн сонирхол дээр тулгуурлаж байдгаараа итгүүлэх аргаас ялгаатай. Хатгагчийн хүсэлт гэмт хэрэг үйлдэхэд өдөөх арга болж чадах эсэх нь хатгагч, хатгагдаж байгаа этгээд хоёрын хооронд тогтсон харьцаанаас шууд шалтгаална. Ойр дотно харьцаатай байх нь хатгагч хүсэлт гаргаснаар хатгагдаж байгаа этгээд бусдыг алах гэмт хэрэг үйлдэхэд хүргэж болдгийг амьдрал харуулж байна. Тухайлбал: "Д", "Р" нар нууцаар амраглаж, хамтран амьдрахаар шийдсэн боловч "Д"-ийн нөхөр "С" үүнийг мэдэж, тэд нарыг ална гэж заналхийлэх болжээ. Нэгэн өдөр "Д"-г гэртээ ирэхэд нөхөр "С" нь согтуу унтаж байсан байна. Энэ үед "Д" нь "С"-ийг алах хэрэгтэй гэж "Р"-ийг ятгахад "Р" нь "С"-ийг уургын хуйваар боон алжээ. Энэхүү гэмт хэргийн төлөө "Д" бусдыг алах гэмт хэрэгт өдөөн хатгасан гэмт үйлдлийн учир, "Р" нь бусдыг санаатай алсан хууль бус үйлдлийн төлөө ял шийтгэгдсэн. Энэ тохиолдолд гэр бүлээс гадуур тогтоосон харьцаа шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн байна. Хатгагдаж байгаа этгээдийн гаргасан алдаа дутагдал, өмнө үйлдсэн гэмт хэргийг илчилнэ гэж айлган сүрдүүлэх аргаар гэмт хэрэг үйлдэхэд өдөөж хатгагч өөрийн эрхэнд оруулдаг нь маш түгээмэл арга юм.

Хатгагч бусдыг гэмт хэрэг үйлдэхэд өдөөн түлхэхдээ хэрэглэсэн арга хэрэгсэлийг нэг бүрчлэн тогтоох нь гэмт хэргийг үйлдэхдээ удирдлага болгосон сэдэлт, санаа зорилгыг тогтоох, үйлдсэн хэргийг зөв зүйлчлэхэд ач холбогдолтой юм.

Хатгагч нь хатгагдаж байгаа этгээдийг ямар нэгэн гэмт үйл ажиллагаанд бус зөвхөн тодорхой гэмт хэрэг үйлдэхэд өдөөх ёстой. Энэ нь хатгагч бусдыг гэмт хэрэгт өдөөн түлхэхдээ ямагт туйлын тодорхой шууд санааг удирдлага болгох ёстой гэсэн үг биш юм. Тодорхой бус шууд санаатайгаар хатгагч үйл ажиллагаагаа явуулсан байлаа ч хариуцлагыг учирсан бодит хор

уршгийг харгалзан хүлээлгэх ёстой. Жишээ нь хатгагч хэн нэг этгээдийг зодох гэмт хэрэг үйлдэхэд өдөөн түлхсэн гэж бодоход зодсоны улмаас хохирогч хүнд гэмтэл авсан бол хатгагч Эрүүгийн хуулийн 16 дугаар зүйл, 90 дүгээр зүйлд тус тус заасан хариуцлага хүлээнэ гэсэн үг юм. Хатгагч нь ямагт гэм буруугийн санаатай / шууд ба шууд бус/ хэлбэрийг удирдлага болгон үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг. Хатгагчийн чиг үүрэг нь зохион байгуулагч, гүйцэтгэгчийн чиг үүргээс объектив болон субъектив шинжүүдээрээ ялгагдана. Хатгагч нь гэмт хэргийн объектив талыг хэрэгжүүлэх ажиллагаанд хэзээ ч оролцдоггүйгээрээ гүйцэтгэгчээс, бусдыг гэмт хэрэгт өдөөн түлхдэг боловч бусад оролцогчдыг эрх олох, төлөвлөгөө боловсруулах зэрэг зохион байгуулах, удирдах чиг үүргийг хэрэгжүүлдэггүйгээрээ зохион байгуулагчаас тус тус ялгагдана.

Хатгалга нь ямагт халдлагын объект, субъектээрээ тодорхой байх ёстой. Тодорхой чиглэсэн зорилгогүй, уриалгын шинжтэй үйл ажиллагаа нь эрүүгийн эрх зүйн утгаараа хэзээ ч хатгалга болохгүй.

Гэмт үйл ажиллагаанд хамжигч: Хамжигч нь хамтран оролцохын хамгийн түгээмэл төрөл боловч бусад оролцогчидтой харьцуулбал нийгмийн хор аюул багатай. Эрүүгийн хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Г"-д зааж зөвлөх, зэвсэг, хэрэгсэл өгөх, учрах саадыг арилгах замаар гэмт хэрэг үйлдэхэд дэмжлэг үзүүлсэн, түүнчлэн гэмт хэрэгтэн болон гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, хэрэгсэл, гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлийг нуун далдлах, гэмт хэргийн ул мөрийг баллахаар урьдчилан амласан этгээдийг хамжигч гэнэ хэмээн тодорхой заасан байна.

Хамжигчийн зүгээс дэмжлэг /хамжлаг/ үзүүлж байгаа үйл ажиллагааны шинж, аргуудыг харгалзан биений хүчний болон сэтгэл санааны дэмжлэг гэж 2 ангилна.

Биений хүчний дэмжлэг үзүүлэх нь гүйцэтгэгчээс тодорхой гэмт хэргийн объектив талыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн

- а/ шаардагдах зэвсэг, хэрэгсэл олж өгөх,
- б/ гэмт хэрэг үйлдэхэд тохиолдож байгаа саад бэрхшээлийг идэвхитэйгээр арилгах,
- в/ гэмт хэрэг үйлдэх явдлыг хөнгөвчлөхөд чиглэгдсэн бусад дэмжлэг үзүүлэх зэрэг идэвхитэй үйл ажиллагаа явуулах байдлаар

илэрнэ.

Зарим тохиолдолд тухайлбал саад хийх, гаргуулахгүй байх албан үүрэг хүлээсэн хамжигч энэ үүргээ биелүүлээгүй байгаагаараа гүйцэтгэгчид дэмжлэг үзүүлсэн бол эс үйлдлээр хамжсан гэж үзнэ.

Хамжигчаас гүйцэтгэгчид олж өгч байгаа зэвсэг хэрэгсэл гэдэгт түлхүүр, халуун хүйтэн зэвсэг, тээврийн хэрэгсэл, бензин зэрэг материаллаг зүйл байж болно. Хамжигчийн олж өгч байгаа зэвсэг хэрэгсэлийг тоочих боломжгүйн адил тэдгээрийг гүйцэтгэгч тухайн гэмт хэргийг үйлдэхэд зайлшгүй хэрэглэнэ гэж шууд нотлох боломжгүй юм. Жишээ нь түлхүүрийг орон байр, байгууллагад нэвтрэн орж бусдын эд зүйлийг хулгайлах, тагнуул хийхэд, буу зэвсгийг бусдыг алах, дээрэмдэх, зандалчлах, хүчирхийлэх шинжтэй гэмт хэрэг үйлдэхдээ тус тус ашиглаж болно.

Гүйцэтгэгч хамжигчийн өгсөн зэвсэг хэрэгсэлийг зөвхөн тохиролцсон гэмт хэргийг үйлдэхдээ ашигласан бол үүрэг гүйцэтгэсэн хамжигч гэж үзнэ. Хамгийн гол нь эдгээр зэвсэг хэрэгсэл нь зориулалтын хувьд гэмт хэрэг үйлдэхэд ашиглах бүрэн боломжтой байх ёстой.

Хамжигч гэмт хэрэг үйлдэхэд тохиолдож болох саад бэрхшээлийг арилгах хөнгөвчлөхөд чиглэгдсэн тухайлбал, эд хөрөнгийг хадгалж хамгаалах үүрэг бүхий манаачийн анхаарлыг сарниулах, объектоо орхиж явах нөхцөл бүрдүүлэх, архи өгч согтоох, гэрэл цахилгаан, утсан холбоог таслах, хоточ нохойд хор өгөх гэх мэт үйл ажиллагаа байж болно. Жишээ нь "А" гүйцэтгэгч "Н", "Ө" нартай ярьж тохирсоны дагуу байгууллагын харуул өөрийн танил "М" рүү эхнэр чинь авто осолд орлоо гэж утсаар ярьсны дараа "М" хаалгаа түгжээд нэг цагийн хугацаанд гэртээ хариад ирэх хооронд гүйцэтгэгч нар байгууллагын сейфэд байсан мөнгийг хулгайлж амжсан байв. "А" энэ хэрэгт тохиолдох байсан саад бэрхшээлийг арилгах замаар хамжигчаар оролцсон гэж хариуцлага хүлээсэн байна. Хамжигч нь гүйцэтгэгч этгээдэд гэмт хэрэг үйлдэх, шийдмэг санаа бодлыг бэхжүүлэх, тодорхой болгох зорилгоор түүнд заавар, зөвлөгөө өгөх замаар сэтгэл санааны дэмжлэг үзүүлнэ.

Гүйцэтгэгчид хамжигч заавар, зөвлөгөө өгөх замаар дэмжлэг

үзүүлэх нь ховор тохиолдол бөгөөд ийм дэмжлэг үзүүлсэн этгээдийн гэмт хэргийг санаачлагч, зохион байгуулагч, хатгагчийн үүрэг гүйцэтгэсэн гэж үзэх нь зүйд нийшнэ. Иймд эрүүгийн хуульд хамжигч заавар, зөвлөгөө өгөхийг сэтгэл санааны дэмжлэгт тооцсон нь төдийлөн оновчтой биш юм. Харин нэгэнт тодорхой гэмт хэрэг үйлдэхээр шийдсэн гүйцэтгэгчийн энэ итгэл, найдварыг бэхжүүлэх, бататгахад чиглэсэн зөвлөгөө өгсөн бол хамжигчийн үүрэг гүйцэтгэсэн гэж үзэж болох юм.

Сэтгэл санааны дэмжлэг үзүүлэхийн нөгөө хэлбэр бол гэмт хэрэгтэн болон гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг хэрэгсэл, гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлийг далдлах, гэмт хэргийг ул мөрийг баллахаар урьдчилан амлах явдал юм.

Хамжигч нь гүйцэтгэгчийн үйлдэх гэж байгаа гэмт хэргийг холбогдох байгууллагад мэдэгдэхгүй гэж амласан байдаг нь түүнийг гэмт хэргээ төгс үйлдэх шийдвэр төгс болгодог. Ингэснээр гүйцэтгэгч гэмт хэргийн объектив талыг хэрэгжүүлэхдээ түүнийг хамжигч этгээд хаацайлж байгаа, саадгүй байх болно гэсэн бат итгэлтэйгээр үйл ажиллагаагаа чөлөөтэй явуулдаг. Хамжигч гүйцэтгэгчид өгсөн амлалтаа бүгдийг биелүүлсэн байхыг шаардахгүй бөгөөд тэрээр гэмт хэрэг үйлдэх шийдмэг байдлыг бэхжүүлж чадсан нь сая хамжигчийн үүргээ төгс гүйцэтгэдэг. Хамжигч гүйцэтгэгчийн үйлдсэн гэмт хэрэг, хэрэглэсэн багаж зэвсэгийг нуун далдлах, ул мөрийг баллахад чиглэсэн үйлдлээ урьдчилан амлалгүй хийсэн бол хамтран оролцогч биш гэмт хэргийн хамаарагч болно. Хамжигч болон бусад оролцогчдын үйл ажиллагаа нь гүйцэтгэгчийн хэрэгжүүлсэн үйлдэл, түүний хор уршигтай шалтгаант холбоонд байх ёстой. Иймд хамжигч өөрийн чиг үүргээ гүйцэтгэгч гэмт хэрэг үйлдэж эхлэхээс өмнө эсвэл үйлдэж байх тэр үед биелүүлэх ёстой бөгөөд ямар ч тохиолдолд цаг хугацааны хувьд халдлага төгсөхөөс өмнө дэмжлэг үзүүлэхээр амласан байхыг шаардана.

Гэмт хэрэг үйлдэгдэж дууссаны дараа урьдчилан амлалгүйгээр гэмт хэрэгтэнг гэртээ орогнуулсан, хулгайлагдсан эд зүйлийг нуусан бол гэмт хэрэгт хамжигчийн үүрэг гүйцэтгэж оролцсон болохгүй бөгөөд үүнийг гэмт хэрэгт хамаарсан гэж үзэж хариуцлага хүлээлгэнэ.

Хамжигч гэмт хэрэг үйлдэгдэж дуусахаас өмнө дэмжлэг үзүүлсэн

байх ёстой гэсэн үндэслэлтэй холбогдуулан зарим төрлийн гэмт хэргийн төгсгөлийг хууль тогтоогч гэмт үйл ажиллагааны урьдчилсан шатанд байхаар тогтоосныг тусгайлан авч үзэх шаардлагатай юм. Ихэнх тохиолдолд гэмт хэргийн төгсгөл нь гүйцэтгэгч объектив талыг гардан хэрэгжүүлсэнтэй цаг хугацааны хувьд давхцаж байхад заримдаа зөрж байна. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 125 дугаар зүйлд заасан дээрэмдэх гэмт хэрэг нь гүйцэтгэгч бусдын эд хөрөнгийг авах зорилгоор иргэдийн амь бие эрүүл мэндэд аюултайгаар хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж довтолсон үйлдлээр төгсөж байхаар заажээ. Энэ тохиолдолд довтолох үйлдэл нь зөвхөн бусдын эд хөрөнгийг хууль бусаар эзэмших арга болохоос гэмт хэрэгтний хүрэх гэсэн эцсийн зорилго биш юм. Иймд дээрмийн довтолгоон эхлээд хараахан дуусаагүй байхад өдөөн түлхсэн бол хамжигч болно. Мөн түүнчлэн иймэрхүү төстэй байдал удааширсан буюу үргэлжилсэн гэмт хэргүүд үйлдэгдэх явцад ажиглагддаг. Хугацаат албаны цэргийн албан хаагч албанаас зайлсхийх зорилгоор анги, байрлалаа орхиж явсан үеэс гэмт хэрэг төгсдөг бөгөөд баригдах, эргэж ирэх хүртэл үргэлжилдэг учир энэ хугацаанд үзүүлсэн тусламж, дэмжлэгийг хамжигчаар хамтран оролцсон гэж үзэх үндэстэй. Энэ тохиолдолд хамжигч гэмт хэрэгтэнд гэмт үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломж олгож байна. Харин иргэнийг хууль бусаар хорих /Эрүүгийн хуулийн 145¹ дүгээр зүйл/ гэмт хэрэг нь түүнийг хууль бусаар хорьсон, чөлөөтэй зорчих эрхийг хууль бусаар ноцтой хязгаарласан үеэс төгсдөг болохоор гүйцэтгэгчид уг үйл ажиллагаагаа цаашид үргэлжлүүлэх боломж олгосон этгээд хамжигч болохгүй гэдгийг харгалзах ёстой. Хамжигчийн галт зэвсэг хууль бусаар олж гүйцэтгэгчид өгсөн үйлдэл нь Эрүүгийн хуулиар хориглосон гэмт хэрэг болж байвал тэр хамтран оролцсон болон биеэ даасан гэмт хэрэг үйлдсэнээр нэг зэрэг хариуцлага хүлээнэ. Хамжигч нь үйл ажиллагаагаа гэмт буруугийн санаатай хэлбэрээр явуулна. Хамжигч нь өөрөө хамжигчаар оролцож байгаа гэмт хэргийн нийгмийн хор аюул тухайн гэмт хэргийн улмаас бий болох хор уршигийг ухамсарлан ойлгож, улмаар нийм хор уршиг бий болгохыг хүсдэг ба хүсдэггүй боловч үйл ажиллагаагаараа тийм хор уршигт хүргэдэг. Болгоомжгүйгээр гүйцэтгэгчид

дэмжлэг үзүүлсэн бол хамжигч болохгүй бөгөөд үндэслэл байвал биеэ даасан болгоомжгүй гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэж болох юм.

Гэмт хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн болон урьд шийтгүүлсэн этгээд үйлдсэн гэдэг үндэслэлээр хариуцлагыг хүндрүүлэхийг ийм шаардлага хангаагүй оролцогчид тэр тусмаа хамжигчид хамааруулан хэрэглэж болохгүй юм.

Хамжигч нь гэмт хэргийн объектив талыг хэрэгжүүлэхэд оролцдоггүйгээрээ гүйцэтгэгч, хамтран гүйцэтгэгчээс ялгагдана. Зарим хамтран гүйцэтгэгч нь туслах чанарын үүргийг гүйцэтгэдэг боловч гүйцэтгэгчтэй хамтран гэмт хэргийн объектив талыг хэрэгжүүлдэг ба хэргийн газар байлцаж, хэрэгжүүлэхэд оролцож байдгаараа хамжигчаас ялгаатай байдаг.

ХОРИХ ЯЛ

Чимэд-Очирын БАЯРТУУЛ

Хууль зүйн магистр

I. Хорих ялын агуулгыг тодорхойлох нь

Хүний нийгмийн түүхийн бүхий л эринд гэмт явдал хор уршиг тарьж, хүмүүсийг өөрийн эргүүлэгт татан зүй бус хэлмэгдэлд автуулж байлаа.

"Гэмт явдал"-ыг нийгмийн үзэгдэл болохын нь хувьд хүн төрөлхтөн судалж, түүнтэй хийх тэмцлийн арга замыг эрэлхийлсээр өнөөдрийг хүржээ.

Ер нь хүмүүс гэмт хэргийг хэзээнээс үйлдэж эхэлсэн бэ?

Анхны гэмт хэрэг хэзээ гарсан бэ?

Түүнд хариулахад мэдээж хэцүү. Гэсэн хэдий ч хүмүүсийн хооронд эсрэг тэсрэг хүсэл, сонирхол бий болсон тэр цагт тэмт хэрэг гарч эхэлсэн биз ээ. Тийнхүү бие биенийхээ эрх, эрх чөлөөнд харшилж эхэлмэгц төрөөс энэ асуудлыг зохицуулах нь зайлшгүй болов. Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, түүний гаралтыг бууруулах нь төрийн бодлогод тусгалаа олж эхлэхэд цөөнгүй аргыг сонгосны нэг нь хатуу чанга ял шийтгэл байлаа. Өөрөөр хэлбэл гэмт хэрэгтэнг гэсгээн цээрлүүлж, түүнийг болон бусдыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх оновчтой аргын нэгд ял шийтгэл оржээ.

МЭЭ 106-43 оны үед амьдарч байсан "логикийн эцэг" Цицерон *эрх чөлөөтэй байхыг эрхэм та хүсвээс хуульдаа захирагд хэмээсэн нь дээрхийг гэрчилнэ*⁸.

Гэмт хэрэгтэн, зөрчил гаргагчийг янз бүрээр цээрлүүлж байсны дотор "хорих" хэмээх ялын төрөл нилээд түгээмэл байсныг түүх тэрчилнэ.

Хорих ял нь нэг биш зуунд хэрэглэж ирсэн ялын нилээд түгээмэл хэлбэр юм.

М.Ф.Владимирский-Будановын судалгаанаас үзэхэд хорих ял нь ялын эртний хэлбэрийн нэг бөгөөд 2 хэлбэртэй

⁸В.С.Нерсисянц "Философия права" Мос., 1997г. С.329

байжээ. Үүнд:

1. Гавлаж, дөнгөлөх (гинж) нь нилээд хөнгөн хэлбэр

2. Мөглөнд хийх (авадар мэт зүйлд) нь хүнд хэлбэр

бөгөөд XI зууны эхний хагаст хэрэглэж байсан нь нотлогдсон байна. Тухайлбал: Киевт Всеслав ноён мөглөнд хийснийг ард түмэн суллаж байсан тухай тэмдэглэгдэн үлдсэн байдаг. Харин газар доорх шоронг цайзны фундамент, хонгицыг ашиглан хийж байв. Энэ эрдэмтний саналаар бол эртний үед хорих ял нь бусад ялын төрлийг бодвол зөвхөн цээрлүүлээд зогсохгүй урьдчилан сэргийлэх ач холбогдолтой байсан ба таслан сэргийлэх арга хэмжээ болгон хэрэглэхийн зэрэгцээ олзлогдогсодыг ч хорьж байсан байна.⁹

Хорих ял бол Монгол Улсын Эрүүгийн Хуульд заасан ялын үндсэн төрөл бөгөөд ялтны эрх, эрх чөлөөнд шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор хязгаарлагдт тогтоосон төрийн албадагын хамгийн хатуу цээрлэл бүхий арга хэмжээ болно.¹⁰

Хууль зүйн ухааны доктор, профессор Г.Совд *хорих ял бол гэмт хэрэг үлдсэн этгээдийг шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор хуулиар тогтоосон тодорхой хугацаагаар нийгмээс тусгаарлан тусгай дэглэмтэй байлгаж хүмүүжүүлж байгаа төрийн албадлага юм.*¹¹ хэмээн тодорхойлсон байхад эрдэмтэн Б.Содовсүрэн 1969 онд хэвлүүлсэн "БНМАУ-ын эрүүгийн эрх" (ерөнхий анги) сурах бичигтээ *шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолд заасан хугацааны дотор ял шийтгэгдэгчийг тус улсын хуулиар зохицуулсан тусгай дэглэм бүхий журмын дагуу олон нийтээс тусгаарлан хүмүүжүүлэхийг хорих ял*¹² гэж үзсэн. Хууль зүйн ухааны дэд доктор С.Нарангэрэл "Монгол Улсын эрүүгийн эрх зүй"-н ерөнхий ангийн сурах бичигтээ *хорих ялын үндсэн агуулга нь ялтныг олон нийтээс тусгаарлаж харуул хамгаалалт, хяналт бүхий хорих тусгай байгууллагад байлгахад оршино*¹³ гэжээ.

Хорих ялын үндсэн шинж: I. Хорих ял нь ял шийтгэлийн нэг

⁹Владимирский-Буданов М.ф. Обзор истории русского права. СПб., 1905 С.329

¹⁰С.Нарангэрэл Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. УБ., 1996. С.301

¹¹Г.Совд БНМАУ-ын Эрүүгийн эрхийн курс. УБ., 1973. С. 353

¹²Б.Содовсүрэн БНМАУ-ын Эрүүгийн эрх (ерөнхий анги) УБ., 1969. С.113

¹³С.Нарангэрэл Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. УБ., 1996. С. 301

төрөл бөгөөд ялын үндсэн шинжийг агуулна.

2. Хорих ял нь хамгийн хүнд ялын төрөл мөн.

3. Хорих ялыг гэм буруутай нь нотлогдсон этгээдийг шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор олон нийтээс тусгаарлах, харуул хамгаалалт, хяналт бүхий хорих тусгай байгууллагад гүйцэтгэнэ.

4. Хорих ялын хугацааг хуульчилан тогтооно.

Хорих ял нь ял шийтгэлийн нэг төрөл бөгөөд ялын үндсэн шинжийг агуулна: Хорих ял нь гэмт хэрэг үйлдэх, гэм буруутайд тооцогдсон этгээдийн эрх, эрх чөлөөнд эрүүгийн хуульд заасны дагуу шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор хязгаарлалт тогтоосон төрийн албадлагын арга хэмжээ мөн. Хорих ялыг ялын нэг төрөл хэмээн Монгол Улсын Эрүүгийн Хуульд заасан.

Гэм буруутай этгээдийг нийтээс тусгаарлаж буй хорих ял нь хуульд заасан ялын зорилгыг бүрнээ агуулдаг болно. Эрүүгийн хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар ялын зорилго нь гэмт халдлагаас иргэн, нийгмийг хамгаалах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, засан хүмүүжүүлэх, түүнчлэн ялтныг болон бусад хүнийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино.

Ялын зорилго нь ялыг оногдуулсны болон гүйцэтгэсний үр дүн байх ёстой. Өөрөөр хэлбэл ялын зорилгыг хангахын тулд гэм буруутай этгээдэд илүү ял оноож, төрийн эрх бүхий байгууллага гүйцэтгэдэг.

Хорих ялын биелэлт нь зөвхөн хүний эрх, эрх чөлөөг хасан, хорих байгууллагад хорьсноор хязгаарлагдахгүй. Харин ялтан д тавих хяналт, ялтны засрал, нийгмийн ял шийтгүүдсэн бие хүнд хандах хандлага болон хэвийн гишүүдийн тусламжтайгаар ял эдлэсэн хүнд тавих хяналтаар илэрч болно.

Эрүүгийн эрх зүйн сонгодог урсгалын үүднээс ялын утга учир нь гэм буруугийнхаа нүглийг арилгахад оршино.¹⁴ Ялын биелэлтийн үүднээс дээрх онол нь практикт ялтныг хорих байдлаар биелэгдэж байлаа.

Хорих ялын үндэс бол гэмт этгээдийн эрх, эрх чөлөөг хасах бөгөөд энэ нь гэм буруутай этгээдийн үйл ажиллагаа хууль бус болохыг илэрхийлэхийн зэрэгцээ хийсэн хэрэгтээ гэмших,

¹⁴И.В.Шварев Уголовно-исполнительное право Мос., 1996. С.16

ухамсарлахад нөлөөлөх тухай асуудал юм. Хатуу хорих загварыг өнөөдөр ч гэсэн криминологчдын ихэнх нь сайшааж байна. Энэ нь хүн амын дунд хүлээн зөвшөөрөгдсөөр байгааг тэмдэглэх хэрэгтэй.¹⁵

Хорих ял онц аюултай гэмт хэрэгтнүүдээс нийгмийг хамгаалах, тэднийг нийгэмшүүлэх, хүнд, онц хүнд гэмт хэргийн гаралтыг багасгах зорилготой бөгөөд гэмт этгээдийн эрхийг хуульд заасан үндэслэлээр хязгаарладаг.

Энэхүү ялын биелэлтийн практик онол нь тусгай мэргэжлийн хандлагад өөрийн илэрлээ олсоор байна. Тодруулбал гэмт хэрэгтний эмнэлэг-психолог шинж. Түүний үндэс нь XIX-XX зууны хүмүүнлэгийн болон нийгмийн шинжлэх ухааны томоохон ололтууд (психолог, социолог, сурган хүмүүжүүлэх) ялын биелэлтэд нөлөөлсөн явдал болно.

Эмнэлгийн загвар нь гэмт хэрэгтэнтэй тусгай мэргэжлийн талаас хандах өвөрмөц хэлбэртэй загвар юм.

Криминологийн орчин үеийн сургаалууд ял нь гэмт болон гэмт бус зан үйлүүдийн хооронд хязгаар тогтоох замаар гэмт хэрэгт эсэргүүцэл үзүүлэхэд чиглэгддэг гэж үздэг.*

Орчин үед ялыг гүйцэтгэх мэргэжлийн олон аргууд байдгийн дотроос нийгэмшүүлэх, тэр дундаа олон улсын түвшинд нэлээд өргөн хэрэглэгдэж байгаа нь *нийгэм-психолог, эмнэлэг зүйн аргууд* юм.

Хорих ялыг хэрэглэх гол зорилт нь *гэмт этгээдийг нийгэмшүүлэх болно*.¹⁶ Ялтаны хувьд ажиллах чадвар, бусдын адил амьдрах хүсэлтэй байх нь ялын зорилтыг биелэхэд чухал байр суурьтай. Хоригдлын эрхийг хязгаарлах илүү дутуу, хэрэггүй рискүүд орох шаардлагагүй, эрх чөлөөтэй, бусдын адил амьдрах боломжуудыг хуулийн дагуу ашиглан нийгэмд хөл нийлэн алхах хүсэл төрүүлэх нь хангалттай.

"Нийгэмшүүлэх" гэдэг нь ялыг гүйцэтгэх хамгийн гол түлхүүр ойлголт. Гэмт хэрэг бол хүний дутуу нийгэмшилт, нийгэмд дутуу боловсрогдсон зан үйлийн хэлбэр гэж зарим эрдэмтэд тодорхойлжээ.

*С.М.Иношков Зарубежная криминология Мос., 1997. С.314

**Г.А.Шнайдер криминология мос., 1994. С.400

Хорих анги дахь хүний "эвдрэл" нь эвдэрсэн хүмүүсийн гэмт мэдрэмжийг эсэргүүцэх орчингүйддэгтэй холбоотой. Энэ нөхцөлд хүн эвдрэхгүй байхын тулд өөрт буй сайн чанарыг хадгалахыг хичээх хэрэгтэй ажээ. Нийгэмшүүлэх гэсэн ойлголт нь хууль зөрчигчийг хууль сахин биелүүлэх үүргээ ухамсарлах түвшинд хүргэх тухай ойлголтыг агуулдаг.

Орчин үеийн нийгэм хурдацтай хөгжиж буй тул эрчимтэй нийгэмшүүдэлт шаардлагатай байна. Ялтанг ийм хурдацтай нийгэмшүүлэх явцад түүний ертөнцийг үзэх үзлийг өөрчлөх, өөртөө эрчимтэй, шүүмжлэлтэй хандах боломжийг олгож, соёлжуулахад чиглэгдэх ёстой. Хорих ялыг гүйцэтгэхэд "клиник" чиглэл ч анхаарах болжээ.

Түүхийн эртний болоод дундад зууны, түүний дараах үед гэмт хэрэгтэнд ямар нэгэн албадлагыг хэрэглэхдээ эрүүгийн ялын тусламжтайгаар бие хүний эрүүд мэнд, нийгмийн байдалд хохирол учруулж байлаа. Харин гэмт хэргийн хохирогчид хохирлыг нөхөн төлүүлэх тухай сэтгэлгээ нь түүхэн хөгжлийн шинэ акцент болон гарч ирсэн. Нийгэм гэмт хэргийн учир үүссэн хохирол дээр ямар нэг шинэ зүйл нэмэхийг эрмэлздэггүй.

Ялыг биелүүлэхийн зорилго нь хорихоос илүүтэй гэмт хэрэгтэн ба хохирогч хоёрыг эвлэрүүлэх явдалд оршино.

Шинэ үеийн эхээр харгис хэрцгий ял шийтгэлээс зайлсхийх хүмүүнлэг-эрүүгийн ялын тухай үзэл санааг Ч.Беккарна, Х.Говард нар нэвтрүүлсэн.

Ялыг биелүүлэх практик, онолын хөгжлийн чиг хандлага энэ зууны эхэнд тодорхойлсноор, ХХ зууны чиг үүрэг болсон ялтны эрүүгийн болон эрх зүйн статусын харилцаа дараахь 3 асуудлыг хамаарна. Үүнд:

1. Ял шийтгэл нь эрх чөлөөг хязгаарлахад л бий болдог. Ялтанд гагцхүү үйлдсэн бөгөөд нотлогдсон гэмт хэргийнх нь төлөө л ял онооно.

2. Хоригдолд эдлэх эрх байх ёстой. Эдгээр эрх нь хуулиар хамгаалагдана.

3. Ял шийтгэлийг биелүүлэх үйл явцад хууль бус зөрчил гарвал түүнийг шүүхээр шийдвэрлүүлэх эрх хоригдол ба төрд байх ёстой.

Германы Үндсэн Хуулийн Шүүх эдгээр саналуудыг

зарчмын хувьд зөвшөөрч 1972.03.14-ний шийдвэрээрээ баталсан.¹⁷ Хоригдлын эрхийг зөвхөн хуулиар хязгаарладаг ба түүнийг зөрчих тухай асуудал тухайн нийгмийн хувьд зайлшгүй тохиолдолд яригдах бөгөөд энэ нь Үндсэн Хуулийг зөрчих ёсгүй.

Хорьж эрх чөлөөг хязгаарлах ял нь дараахь онцлог шинжийг агуулах бөгөөд, дор дурьдсан үр дагаварыг агуулдаг. Үүнд:

1. Хоригдлыг үйлдсэн гэмт хэргийнх нь төлөө шийтгэхдээ түүнийг нийгэмшихэд нөлөөлөхийн тулд түүний хамаарах хүрээллээс нь тусгаарладаг.

2. Хорих ял нь гэмт хэрэгтнийг өөрийгөө үнэлэхэд хүчтэй нөлөөлдөг. Тэрээр суллагдаж, нийгмийн хэвийн амьдралд буцаж ороход маш хатуу бэрхшээл, доромжлол, хараал зүхэлтэй учирдаг.

3. Хууль зөрчигчид оноосон хорих ял нь гэмт явдлыг төрүүлж байдаг нийгэм бие хүний тулгамдсан байдлыг нийгмийн хувьд нууцладаг. Нийгэм гэмт явдлын асуудлуудыг шийдвэрлэх боломжоо алдаж, сөрөг үр дагавар бүхий нийгмийн үзэгдлүүд илрэн гарахгүйн зэрэгцээ тэдгээрийг арилгах асуудалд бэрхшээл учирдаг.

Эдгээртэй холбогдуулан Канад, Австралид эрх зүйн шинэчлэл хийх комисс хүний эрх чөлөөг хязгаарлахтай холбогдсон ялыг аль болох бага хэрэглэх, цаашид хязгаарлахыг зорьж байна.

Хорих ялын асуудал нэг улсаар зогсохгүй олон улсын байгууллагуудын анхаарлыг зүй ёсоор татаж байна. Жишээлбэл:

Европын Зөвлөл эрх чөлөөг хязгаарлахад шинэ альтернатив хандлагыг туршиж үзэх тухай санал дэвшүүлсэн. НҮБ 1980.08.25-1980.09.01 хооронд Каракаст болсон хууль зөрчигсөдтэй харилцах, гэмт явдлыг бууруулах талаар хийсэн IV Конгресс, ял шийтгэлийг биелүүлэх тухай зөвлөмжийг гаргажээ. Үүний зэрэгцээ АНУ-ын Үндэсний Зөвлөлийн Удирдлага 1975 онд хорих газруудад зөвхөн онц аюултай гэмт хэрэгтнүүдийг л хорьж байх санал дэвшүүлсэн байна. Зарим нэг криминологчдын үзлээр хууль зөрчигчийн нийгэмд аюултай түвшинг тодорхойлох нь онцгой бэрхшээлтэй гэдэг.

¹⁷Т.И.Шнайдер Криминология Мос., 1994. С.390

Хорих байгууллагад ялын биелэлтийг зөв зохион байгуулах 3 нөхцөл:

1. Хорих ангид нийгмийн стандартад нийцсэн амьдралын нөхцөлийг бий болгох.

2. Хүмүүжлийн арга хэмжээ нь хүмүүнлэг шинжтэй байх, өөрөөр хэлбэл шууд болон шууд бусаар хүмүүжүүлнэ хэмээн албадах ёсгүй.

3. Хорих ангиудад эрх зүйт төрийн зарчмуудыг биелүүлэхийн тулд ял эдлүүлэх ажиллагааг төрийн эрх бүхий дээд шатны байгууллагын хяналт шалгалтан дор байлгах ёстой.

Хорих ял нь хамгийн хүнд ялын төрөл мөн: Хорих ял нь хамгийн хүнд ялын төрөл төдийгүй эрүүгийн эрх зүйн судлагдахууны дотор ч судлаачдын гойд анхаарал татдаг. Ялын энэ төрөл нь гол төлөв онц хүнд, хүнд гэмт хэрэг үйлдэгсэд, онц аюултай гэмт хэрэгтэнд зориулагдсан бөгөөд Монгол Улсын эрүүгийн хуульд зааснаар үндсэн хугацаа нь 0,5-15 жил хүртэл байна.¹⁸

Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд 25 жил хүртэл хугацаатай хорих ял оногдуулдаг. Мөн түүнчлэн цаазаар авах ял шийтгүүлсэн гэмт хэрэгтний амийг Монгол Улсын Ерөнхийлөгч уучилсан тохиолдолд хугацаагүй хорино. Энэхүү заалтуудыг Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 1993.06.07-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулж, нэмсэн болно.

Хорих ялыг дараахь тохиолдолд зайлшгүй хэрэглэх болдог.

Учир нь 1) Онц аюултай гэмт хэрэгтэн (алан хядагч г.м) бол нийгмийг түүнээс хамгаалахын тулд

б) Хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдсэний улмаас нийгэмд учирсан хохирол нь их байдаг тул

в) Гэмт хэрэгтэн урьд нь хорихоос өөр төрлийн хөнгөн ял шийтгэл эдлэж байсан боловч үүнийг үл ойшоон дахин гэмт хэрэг үйлдсэн бол

Монгол Улсын эрүүгийн ялын төрөл дотроос хорих ял нь хамгийн хүнд нь учир голлон онц хүнд, хүнд гэмт хэрэг үйлдэж хорихоос өөр төрлийн ялаар нөлөөлөх боломжгүй гэж үзсэн этгээдэд энэ ялыг хэрэглэдэг.

¹⁸Монгол Улсын Эрүүгийн хууль, зүйл: 22

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 6 дугаар зүйлд гэмт хэргийн ангилалын тухай заасан бөгөөд гэмт хэргийн шинж чанар, хор аюулын хэр хэмжээг харгалзан хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэг хэмээн ангилана. Энэхүү заалтыг 1993 онд өөрчлөн найруулсан билээ.

Хүнд гэмт хэрэг гэдэг нь хуульд зааснаар эрүүгийн хуулийн тусгай ангид 15 жил хүртэл хугацаатай хорих ял оногдуулахаар заасан санаатай гэмт хэрэг билээ.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 36², 65, 67, 70, 71², 75, 77², 80, 90¹, 90², 102, 103¹, 105¹, 105², 112², 113, 123¹, 124¹, 124², 125¹, 126¹, 134¹, 137¹, 145¹⁻², 148¹, 171¹⁻², 175¹⁻², 179¹⁻¹, 185², 192², 193², 195¹, 196², 197², 201², 203², 205², 207², 211², 239¹, 240¹, 242², 243², 244², 245¹, 245², 246², 242², 253¹, 254¹, 260², 260³, 264, 265¹, 266, 267¹, 268¹, 268³, 270², 270³, 271¹, 272², 272³, 273¹, 274¹, 274², 276¹, 277¹, 278¹, 279¹, 279², 279³, 280, 281¹, 282², 283², 283³, 284², 284³, 285², 286¹, 287¹, 287⁴, 288¹, 289¹, 289⁴, 291¹, 292², 292⁴, 293¹, 294, 295, 296, 297², 297¹, 298, 299 заасан гэмт хэрэг нь хүнд гэмт хэрэг ба 60, 60¹, 61, 62¹, 63¹, 64, 73, 74¹, 74², 86¹, 86², 112¹, 125², 179¹⁻², 195², 222, 245³, 254², 268² дахь зүйлүүдэд хуульчилсан хууль бус үйлдэл нь онц хүнд гэмт хэрэгт тооцогдоно.

Хорих ялыг гэм буруутай нь нотлогдсон этгээдийг шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор олон нийтээс тусгаарлаж, харуул хамгаалалт, хяналт бүхий хорих тусгай байгууллагад гүйцэтгэнэ. Хорих ялыг ялын хүнд төрөлд тооцох болсон нэгэн үндэслэл нь ялтанг тусгай дэглэм бүхий ял эдлүүлэх ангид үйлдсэн гэмт хэргийн ба хувийн байдлыг харгалзан шүүх эсхүл эрх бүхий төрийн байгууллагаас хуваарилдагт оршино.

Анх "болдоггүйчүүд"-ийг хүний наад захын хэрэгцээ, шаардлагыг үл хангасан гэрэл гэгээ хомс, агааржуулалт муу цайзны хөнгөл, оромж, ил задгай хашаанд хорьж, амь зогоох төдий хүнсний зүйл өгөхийн хамт хоригдлуудыг ямар ч ангилалгүйгээр нийтээр нь хорьж байлаа. Энэ бол шорон юм. Хоригдлуудыг биечлэн ялаа эдлэхэд анхаарал тавьж, тэдний оргох боломжуудыг арилгахын тулд харуул хамгаалалтыг чангатгах, хэдэн давхар хэрмэн хашаа, цайзанд хорьсоор XVIII зууныг гаргажээ. Шоронд хоригдлуудыг гагцхүү цээрлүүлэх, бие махбодийг нь шаналган зовоох, өлсгөлөн болон хагас өлсгөлөн

байдалд байлгах нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх оновчтой зам мөн гэж байв.

Хорих ял үүссэн тэр үед шорон үүссэн гэсэн логик дүгнэлтийг хийж болох боловч анхны шоронг 1595 онд Голландын Амстердамд үүссэн гэдэг. Түүнийг *"Цухт Хауз"* хэмээнэ.¹⁹ Үүний дараа АНУ, Англи зэрэг улс орнуудад хорих ялыг эдлүүлэх талаар дэвшилтэт арга хэмжээнүүдийг авсан юм.

Одоогийн дагаж мөрдөн буй Эрүүгийн хуулийн дагуу шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор хорих ялыг жирийн чанга, онцгой дэглэмтэй хорих анги, гяндан, хугацаагүй хорих тусгай салбарт эдлүүлдэг.

Жирийн дэглэмтэй хорих ангид:

1. Хөнгөн буюу хүндэвтэр гэмт хэрэг санаатай үйлдэж анх удаа хорих ял шийтгүүлсэн

2. Хүнд буюу онц хүнд гэмт хэрэгт 3 жилээс дээшгүй хугацаагаар анх удаа хорих ял шийтгүүлсэн эрэгтэйчүүд

3. Төрийн эсрэг онц аюултай гэмт хэрэгт хорих ял шийтгүүлсэн буюу онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсоноос бусад эмэгтэйчүүдийн хорих ялыг жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлэхээр шүүх оногдуулна. (Эрүүгийн хуулийн 6 дугаар зүйл, 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэг)

Чанга дэглэмтэй хорих ангид:

1. Төрийн эсрэг онц аюултай гэмт хэрэгт хорих ял шийтгүүлсэн

2. Хүнд ба онц хүнд гэмт хэрэгт 3 жилээс дээш хугацаагаар анх удаа хорих ял шийтгүүлсэн

3. Урьд хорих ял эдэлж байсан эрэгтэйчүүд

4. Төрийн эсрэг онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эмэгтэйчүүдийн хорих ялыг чанга дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ.

Эрүүгийн хуулийн 22 дугаар зүйлийн 12 дахь хэсэгт заасны дагуу гянданд:

1. Онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эрэгтэй,

¹⁹Н.А.Стручков, Ю.М.Тючевский Советское исправительно-трудовое право Мос.,1983. С. 227

эмэгтэй хоригдлын ялыг

2. 18 насанд хүрсний дараа төрийн эсрэг онц аюултай гэмт хэрэг үйлдсэн этгээд

3. 18 насанд хүрсний дараа Эрүүгийн Хуулийн 6 дугаар зүйлд заасан бусад хүнд буюу онц хүнд гэмт хэрэг үйлдэж 5 жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлж байгаа этгээдийн хорих ялыг бүгдийг буюу заримыг эдлүүлнэ. Гяндан нь хорих байгууллагын тогтолцоонд зонхилох байр эзэлдэггүй ч бусад дэглэмийн хорих ангиудын нэгэн адил ялын зорилгыг хангах чиг үүрэг гүйцэтгэдэг.*

Гяндан нь дотроо жирийн болон чанга дэглэмтэй байна.

Онцгой дэглэмтэй хорих ангид онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эрэгтэйчүүдийн хорих ялыг эдлүүлнэ.

Цаазаар авах ялаас амь уучлагдсан этгээдийн ялыг хугацаагүй хорих ялаар солих бөгөөд тийм хоригдлуудын ялыг хугацаагүй хорих тусгай салбарт эдлүүлнэ.

Хорих ялын хугацааг хуульчлан тогтоодог: Хорих ялын үндсэн шинжийн нэг нь түүний хугацааны асуудал болно. Хорих ялыг хугацааны хувьд *хугацаа төвлөсөн* ба *хугацаагүй* гэж хуваадаг.

Гэм буруутай этгээдийг нийгмээс тусгаарлаж, ялын зорилгыг хангах магадлалтай гэж үзсэн *үндсэн* болон *онцгой* хугацааг хорих ялын хувьд эрүүгийн хуулиар тогтооно. Ийнхүү хорих хугацааг нь хуулиар тогтоосон хорих ялыг **хугацаа төвлөсөн хорих ял** гэнэ.

Хугацаа төвлөсөн хорих ялын хугацааг үндсэн ба онцгой, бүх насаар нь хэмээн хуваана.

Хорих ялын үндсэн хугацаа: гэдэг нь хуульд заасан онцгой тохиолдлоос бусад нөхцөлд гэм буруутай этгээдэд оногдуулах хорих ялын хугацаа юм. Монгол Улсын эрүүгийн хуульд зааснаар хорих ялын үндсэн хугацаа 0.5-15 жил. Хэрэв хуульд тухайн тодорхой гэмт хэрэгт оногдуулж болох хорих ялын зөвхөн доод хэмжээг тогтоож, дээд хэмжээг заагаагүй бол 15 жилээс дээш хугацаагаар хорьж болохгүй. Учир нь манай улсад дагаж мөрдөж байгаа хуулиар хорих ялын үндсэн хугацаа 0,5-15 жил. Хорих ялын үндсэн хугацаав улс орон бүрт харилцан адилгүй. Тухайлбал: Англид нэг өдрөөс 25 жил, Герман ба Японд нэг сараас 15 жил, Хятадад 0.5-15 жил, ОХУ-д 0.5-20 жил

Хугацаа товлосон хорих ялын онцгой хугацаа: Нийгмийн хор аюулын хувьд гойд их (манай улсын гэмт хэргийн ангиллаар онц хүнд гэмт хэрэгтэй дүйх) гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд оногдуулах **хугацаа товлосон хорих ялын онцгой хугацаа** нь хуульд заасан хорих ялын үндсэн хугацаанаас илүү байна. Эрүүгийн хуулийн 22 дугаар зүйлд зааснаар онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд 25 жил хүртэл хугацаатай хорих ял оногдуулна хэмээн заасан нь Монгол Улсад хугацаа товлосон хорих ялын онцгой хугацаа 25 жил хүртэл болохыг илтгэнэ.

Бүх насаар нь хорих ял: Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд бүх насаар нь хорих ялыг онооно. Энэ ялаар шийтгүүлсэн этгээд суллагдах боломжоор хомс боловч хуульд заасан онцгой нөхцөлд тийм магадлал үүснэ. Эрх зүйт төрийн үед ял биелүүлэх явдал нь эрх чөлөөг тодорхой хугацаанд хасах тухай асуудлыг хөнддөг. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн Хуулийн Шүүх 1977.№21-д эрх зүйт төрийн зарчмуудад тулгуурлан бүх насаар нь хорихоор гаргасан таслан шийдвэрлэх тогтоол эрх чөлөөтэй болох боломжийг өгдөг. Ялын зорилго нь дахин нийгэмшүүлэх учраас бүх насаар нь хорих ялын хэсгийг өөрчлөх шаардлагыг дэвшүүлэн гаргаж тавьж байжээ. Бүх насаар нь хорих ялыг АНУ, ХБНГУ, Франц, Япон, БНХАУ, ОХУ зэрэг улс орнуудад ялын нэгэн төрөл хэмээн хуульчилжээ.

Хугацаагүй хорих ял: Бүх насаар нь хорих ялтай харьцуулахад нийгэмд аюулгүй болсон онцгой тохиолдолд ялтан суллагдах магадлалтай. Хугацаагүй хорих ялаар шийтгүүлсэн этгээд хугацаа товлосон хорих ялын онцгой хугацаанаас дээш жилээр ял эдлэх, нийгэмд аюулгүй болсон гэх хангалттай үндэслэл байвал эрх чөлөөтэй болох болзолтой байдаг.

Хугацаагүй хорих ялыг Монгол улсад 1993 онд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар нэмсэн бөгөөд хуульд заасны дагуу 30-аас доошгүй жилийн хорих ял эдэлсний дараа нийгэмд аюулгүй болсон онцгой тохиолдолд түүнийг ялаас чөлөөлөх эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Хугацаагүй хорих ялаар шийтгэгдсэн этгээд хугацаагүй хорих тусгай салбарт ялаа эдлэнэ.

Өнөөдөр эрдэмтэн судлаачдын дунд хорих ялын хугацааны

асуудал нилээд маргаантай байна. Удаан хугацааны хорих ял төдийлөн үр ашиггүй гэж үздэг хэсэг байхад бага хугацааны хорих ял оногдуулахаас аль болох зайлсхийх, хорихоос бусад төрлийн ялаар шийтгэх нь үр дүнтэй гэх хүмүүс ч бий.

Хорих ял үе үеийн эрдэмтэн, судлаачдын анхаарлыг татсаар ирсэн судлагдахуун мөн.

Орчин үед ял эдлүүлэх асуудлыг *пенология* (ял судлал), *шорон судлал* буюу ял эдлүүлэх эрх зүйн шинжлэх ухаан судлаж байна. Эдгээр шинжлэх ухаан нь үүсэл хөгжил, ял шийтгэлд хандах асуудлаараа өөр боловч, судлах зүйлийн хувьд ялган салгахад нилээд бэрхшээлтэй.

Пенология нь эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны нэг хэсэг болон бүрэлдэн буй болсон бөгөөд

1. *Ял шийтгэл дэх торийн эрх*

2. *Ял шийтгэлийг хэрэглэх*

3. *Ял шийтгэлийн хэмжээ* гэсэн 3 асуудлыг онцлон авч үздэг болохыг И.Я.Фойницкий "Шорон судлал, ял шийтгэлийн сургаал" зохиолдоо 1889 онд дурьдсан.²⁰

Тэр үед ял шийтгэлийн ерөнхий онол боловсронгуй болж, шоронгийн практик үйл ажиллагаанд анхаарлаа хандуулж, Пенология шинжлэх ухаан болж төлөвшив.

Ял шийтгэлийн хүрээнд өөр нэг шинжлэх ухаан үүссэн нь ялын нэг төрөл хорих ялыг хэрэглэх тухай шорон судлалын шинжлэх ухаан. Түүний үүсэл нь Английн энэрэнгүй үзэлтэн Жон Говард, философ-утилитарист Иермия Бентам нартай салшгүй холбоотой.

Жон Говард (1726-1790) 1777 онд "Английн болон Уэльсийн шоронгийн байдал" зохиолоо гаргасан, Түүнийг шорон судлалын шинжлэх ухааны үндсийг тавьсанд тооцдог. Тэрээр Их Британы парламентын гишүүн байлаа. 1778 онд нэрт эрдэмтэн Вильям Блекстоуны дэмжлэгтэйгээр "Засан хүмүүжүүлэх байгууллагуудын тухай акт" гэж нэрлэгдсэн хуулийн төслийг боловсруулсан нь жилийн дараа парламентаар батлагджээ. Жон Говард хүний эрхийн төлөө тэмцэж, хоригдлуудын эрүүл мэнд, амьдрах нөхцлийг дээшлүүлэхийг эрмэлзсэн юм. Тухайн үед

²⁰Н.Ф.Кузнецова Современная буржуазная криминология МГУ., 1974. С.53

эрүүгийн гэмт хэрэгтэн, өрөнд орсон хүмүүс, эрх зүйн зөрчил гаргагч, ядуучууд, ажилгүйчүүд, тэнүүлчид, янхан, сэтгэл мэдрэлийн өвчтөн, цэргийн олзлогдсон хүмүүс шоронд хамтдаа хоригдож байсныг Говард нас хүйсээр нь тусад нь хорих тухай болон амьдрах шаардлага хангасан орчин, тэдний хөдөлмөрийн нөхцлийн талаар цэгцтэй авч үзсэн. Ж.Говардын бүтээл Англид дөрвөн удаа хэвлэгдэж, немц, франц хэлээр орчуулагджээ. Тэрээр өөрийн орны болон Европын хаант улсуудын шийтгэл хэрэглэх хуучирсан системийг шинэчлэхэд нөлөөлсөн гэдгийг цохон тэмдэглэе. Австрийн хорих ял эдлүүлэх нөхцлийг сайжруулахын тулд 1778 онд хатан хаан Мария Тереза, 1786 онд эзэн хаан II Иосифтой биечлэн ярьж байв. Ж.Говардын үзэл дэлхийн хорих байгууллагын практикт ихээхэн нөлөөлсөн гэж дүгнэх бүрэн боломжтой. Мөн түүнчлэн олон улсад хоригдогсодод хандах хүмүүнлэг, рационал хандлагыг дэлгэрүүлэхэд хувь нэмэр оруулсан. Хорих газар хоригдогсодын байдлыг сайжруулах ажилд хүчин зүтгэж яваад Ж.Говард Орост нас эцэслэсэн ажээ. Их эрдэмтний хөдөлмөр нь дэлхий даяар ялын системийг хүмүүнлэг болгоход чухал нөлөө үзүүлсэн. Насан өөд болсноос хойш хэдэн арван жилийн дараа квакеруудын нөлөөллөөр шоронг өвөрмөц албадлагын хийд мэтээр төсөөлж байв, Гэлэнгүүд лугаа гэмт хэрэгтнүүдийг амьдралын утга учрын тухай эргэцүүлэн бодоход тус болох юм гэж хоригдолуудыг нэг камерт хорих зохион байгуулалтыг бий болгосон.²¹

Пенология, шорон судлалын шинжлэх ухаануудад дэлхийн хоёрдугаар дайны дараа *ял шийтгэл, тухайлбал хорих ялын зорилгыг хангах боломж, гэмт явдалтай хийх тэмцлийг боловсронгуй болгох, төрийн засан хүмүүжүүлэх систем, хорих ял ба ял шийтгэлийн бусад илрэл, тэдгээрийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд нөлөөлөх тухай асуудлууд* шинээр тавигдсан билээ.

Улмаар пенология нь зөвхөн ял шийтгэлийн онолыг боловсронгуй болгох асуудалд анхаарлаа хандуулах болсон. Харин эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй нь пенологийн ба шорон судлалын судлагдахууныг хамарсан ял шийтгэлийн бүх төрөл, түүний

²¹С.М.Ишхакон Зарубежная криминология Мос., 1997. С.22

нийгмийн нөлөөлөл, ял эдлүүлэх нохиол, журмын тухай шинжлэх ухаан болон хөгжжээ.

Пенология ба шорон судлалын орчин үеийн тулгамдсан асуудал нь юуны өмнө ял шийтгэлийн торлууд, хорих ялын зорилго нь хорих байгууллагуудын үйл ажиллагаа ба чиг хандлагаас үл шалтгаалах тухай асуудал болно.

Стенли.Э бүх орчин үеийн ял шийтгэлийн зорилгын тухай онолуудыг хорих ялын жишгээр 4 хэсэгт хуваасан.

Үүнд: 1. *Хариу авах онол (retribution):* Шийтгэл нь гэмт хэрэгтний учруулсан зовлон зүдгүүрийн хариу. Энэ урсгалд хамаарах онолын нийгмийн зорилго, утга санаа нь гэмт хэргийн ертөнцийг жигших нэгдмэл мэдрэмжийг цэгцлэх асуудал. Гол төлөөлөгч нь И.Кант, Г.Гегель, Ф.Аквинский.

2. *Айлган сүрдүүлэх онол (deterrence):* Нийгмийн тусын тулд гэмт хэрэгтнийг заавал ял шийтгэлээр айлгах ёстой. Тэр нь айдас төрүүлэм, хэцүү бэрх байвал зохино гэж үздэг. Ерөнхийдөө хариу авах онолтой төстэй.

3. *Цагаатгах онол (rehabilitation):* Нийгмийн гишүүний хувьд гэмт хэрэгтнийг дахин хүмүүжүүлэх ёстой.

4. *Нэгдмэл онол:* Шийтгэл нь цээрлүүлэхийн хамт дахин хүмүүжүүлэх шинжийг агуулбал зохино.²²

Одоо ч ялын зорилгын асуудал маргаантай байна. 1978 онд Португалийн Лиссабонд хуралдсан Олон Улсын криминалогчдын нийгэмлэгийн олон улсын найм дахь удаагийн конгресс дээр ялын зорилгын асуудлыг авч хэлэлцээд, хариуцлага ба ял нь нийгмийн хамгаалал юм гэсэн үзэл баримтлал дээр суурилсан. Энэ санааг криминалогчдын Олон Улсын холбоог үндэслэгчдийн нэг А.Принс "Нийгмийн хамгаалал ба эрүүгийн эрх зүйн хувиралт" зохиолдоо анх дэвшүүлсэн болно.²³ Нийгмийн хамгааллын үзэл баримтлалыг эрүүгийн эрх зүйн социологийн сургуулиас тодруулан үзье.

Э.Дюркгейм залхаан цээрлүүлэх арга хэмжээгээр нилээд хялбар бус санаа дэвшүүлсэн хэдий ч хэлбэрийн хувьд ял шийтгэлийн тухай өөрийн онолыг бүтээхийг оролдсон социологч.

²²В.Фокс: *Введение в криминологию* Мос., 1980. С.163

²³С.М.Ишчаков *Зарубежная криминология* Мос., 1997. С.86

Түүний энэхүү шинэлэг санаа нь мөн чанартаа *бенгын пропорционал* байх үзэл санаанд хандсан байдаг. Иймээс Э.Дюркгейм ял шийтгэл гэмт хэргийн нийгмийн хор аюултай тэнцэж байгаагүй гээд Италийн эрдэмтдийн боловсруулсан нийгмийн хамгааллын онолыг шүүмжлээд ял шийтгэл нь гэмт хэргийн мөн чанарт нийцсэн байх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрдөггүй ямар ч шийгэм байхгүй гэдгийг онцлон тэмдэглэжээ. Нийгмийн гэмт явдлын байдал өөрчлөгдөхийн хэрээр ял шийтгэл ч тэрхүү хувьсалтай хол нийлэх ёстой гээд *хэрвээ гэмт хэргийг өвчин гэвэл ял шийтгэл нь түүнийг анагаах эм юм. Иймд эм нь өвчинг анагаах чадвартай байх ёстой. Өвчин хүндэрвэл эмийн тун нэмэгдэх ёстой. Илааршвал эмийн хэрэг мэдээж хэрэггүй. Огт өвчингүй гэмт хэргийн хувьд эм нь юуг анагаах билээ? Тэр цагт өвчингүй гэмт хэргийн асуудлыг ял шийтгэлээс өөр зүйлээс эрэх хэрэгтэй гээд* ял шийтгэлийн чиг үүргийг ийн тодорхойлсон. Үүнд:

1. Гэм буруутай этгээдийг засан хүмүүжүүлэх
2. Түүнийг даган дууриахыг хүсэгчийг айлган сүрдүүлэх

Ял нь шударга үнэн байх асуудал эргэлзээтэй байдаг хэдий ч түүний бодит функц нь нийгмийн ухамсарт түүний нөлөөлөх чадвар болно. Ял оногдуулахын ач холбогдол нь шударга хүмүүст ч нөлөөлж байдаг. Мөн ял оногдуулсны эцэст үүсэх аливаа үр дагваруудын хамт нийгмийн эмгэг болсон гэмт хэргийг анагаахад үйлчилдэг юм гэсэн үзэл дэвшүүлжээ.²⁴ Дюркгейм ял шийтгэлийн зорилгыг нэн тодорхой авч үзсэн байхад эрүүгийн эрх зүйн сонгодог чиглэлийн эх үндсийг тавигч Чезариа Беккариа (1738-1794) ял оногдуулах тэнцвэрт системийн тухай авч үзсэн. Тэрээр нэг адил гэмт хэрэг үйлдсэн хүмүүс нийгмийн гарал үүсэл, хөрөнгө чинээний байдлаасаа болон харилцан адилгүй ял шийтгүүлж байгаа шударга бус гээд "язгууртны оншгой эрх" гэдгийг томъёолоод тэд язгуур угсаа, эрх мэдэл, хөрөнгө чинээтэй болохоор ядуучуудыг бодвол ял шийтгэлээс мултрах нь элбэг, төдийгүй хүлээж буй ял нь хийсэн хэрэгтээ огт нийцээгүй хөнгөн байдаг бол нийгмийн энгийн

²⁴Раймон Арон Этаны социологик

хэсэг хатуу чанга ялаар шийтгүүлж байгаа нь "шударга ёс ба үүргийн тухай ойлголтыг эвдэж, түүний оронд хүчтэй түрэмгийлсэн эрхийг төрүүлдэг" гэж тухайн цаг үеийн ял оногдуулах асуудлыг шүүмжилсэн нь хууль шүүхийн өмнө эрх тэгш байх, хэнийг ч алив нэг үндэслэлээр ялгаварлан гадуурхаж, эрхийг хязгаарлахгүй байх зарчмын санааг ял шийтгэл оногдуулахад баримтлахыг санал болгожээ.*

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН ТОГТОЛЦОО, ТҮҮНИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

Цолмонгийн ЦЭЛМЭГ

Хууль зүйн магистр

Олон жилийн туршид манай оронд хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, баталгаажуулахад хэлбэрийн төдий хандаж иргэдэд Үндсэн хуулиар олгогдсон эрхээ бүрэн дүүрэн эдлэх бололцоог хэрэг дээрээ олгохгүй байсаар ирсэн нь өнөөдөр ч төдийлөн өөрчлөгдөөгүй байгаа билээ. Манай улс нийгэм эдийн засгийн нэг байгууллаас нөгөөд шилжиж бүхий л зүйл хувьсан өөрчлөгдөж байгаа өнөөгийн нөхцөлд энэхүү өөрчлөлт, шинэчлэлтийн гадна үлдсэн салбар нь хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаа, тэдгээрийн бүтэц зохион байгуулалтын асуудал юм.

Монгол Улсын хууль сахиулах байгууллагуудын тогтолцоо нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага, шүүх, прокурорын байгууллагаас бүрэлдэж байгаа бөгөөд эдгээр байгууллагуудын үйл ажиллагаанд оршиж байгаа дутагдал, олон шат дамжлага бүхий нүсэр зохион байгуулалт, тэдгээрт ажиллагсадын хүнд суртал, хээл хахуульд автагдсан байдал зэрэг нь төр, нийгэм, иргэдийн эрх ашгийг хамгаалахаасаа илүү тэднийг чирэгдүүлж, хохироож байгаа нь нууц биш.

Өнөөгийн Монгол Улсын хууль сахиулах байгууллагуудын энэхүү тогтолцоог жирийн иргэд битгий хэл мэргэжлийн хуульчид ч ойлгохгүйд хүрсэн нь энэ салбарт бүтцийн өөрчлөлт хийх цаг болсоныг харуулж байна. Ардчилсан нийгэмд хүний эрх, эрх чөлөө гагцхүү бусдын эрх, эрх чөлөөгөөр хязгаарлагддаг бөгөөд энэхүү халдашгүй дархан байдалд гагцхүү хуулийн байгууллагууд тодорхой үндэслэлтэй үед халддаг ба энэ нь байцаан шийтгэх хуулиар нарийн зохицуулагддаг онцлогтой.

Чухамхүү хүний эрх, эрх чөлөөнд халддаг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг эрхлэн явуулдаг хуулийн байгууллагуудын үйл ажиллагаа харьцангуй нээлттэй, чиг үүрэг нь тодорхой, үйл ажиллагаа нь давхардал багатай, цомхон чадварлаг, уян хатан бүтэц зохион байгуулалттай байх шаардлагатай. Манай улсын

хуулийн байгууллагууд дээрх шаардлагыг хангаж чадаж байна уу гэсэн асуултанд хариулт авахын тулд жирийн иргэд, оюутан, төрийн албан хаагчдаас бүрэлдсэн 101 хүнээс санал асуулга авсан юм.

Судалгаанд оролцсон хүн тус бүрд дараахь дөрвөн асуултыг тавилаа.

1. Та өнөөгийн Монгол Улсын хуулийн байгууллагууд үүргээ зохих ёсоор биелүүлж байна гэж үзэж байна уу гэсэн асуулт тавихад оролцогчдын 79 % нь хуулийн байгууллагууд үүргээ зохих ёсоор биелүүлж чадахгүй байна гэж, 16 % нь үүргээ зохих ёсоор биелүүлж чадаж байна гэсэн бол 5 % нь хэлж мэдэхгүй байна гэсэн хариулт өглөө.

2. Та шүүхийн үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай явдаг уу, та шүүхэд итгэдэг үү гэсэн асуултанд оролцогчдын 62 % нь шүүхэд итгэдэггүй, шүүгч нар хээл хахуульд автагдсан, мөнгөтэйд нь үйлчилдэг учир сэтгэл дундуур явдаг гэсэн байхад 26 % нь шүүхэд итгэдэг, шүүгчид үүргээ биелүүлж байгаа, 12 % нь сайн хэлж мэдэхгүй гэж хариуллаа.

3. Та прокурорын байгууллагын чиг үүргийг мэдэх үү, прокурор үүргээ биелүүлж байна гэж та үзэж байна уу гэсэн асуултанд оролцогчдын 71 % нь прокурорын байгууллагын чиг үүргийг сайн мэдэхгүй байна, шүүх хуралдаанд оролцдог, 9 % нь прокурор мөрдөн байцаалт явуулж, шүүхэд төрийг төлөөлдөг, 6 % нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавьж шүүх хуралдаанд улсын ялагчаар оролцдог, 14 % нь огт хэлж мэдэхгүй байна гэсэн хариултыг тус тус өглөө.

4. Та цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай байдаг уу гэсэн асуултанд оролцогчдын 51 % нь цагдаагийн байгууллага оногдсон үүргээ биелүүлж чадаж байгаа, 42 % үүргээ хангалтгүй биелүүлж байна, 7 % нь сайн мэдэхгүй гэж хариулахаас татгалзсан байна.

Энэхүү жижиг судалгаанаас харахад хуулийн байгууллагуудын нэр хүнд ард иргэдийн дунд ямар байгаа нь тодорхой байна. Харин цагдаагийн байгууллагын хувьд санал асуулгад оролцсон иргэдийн тал хувь нь ам сайтай байсан нь тэдний үйл ажиллагаа ард иргэдэд харьцангуй ойр байдагтай холбоотой санагдсан.

Ингээд судлаачын хувьд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага, шүүх, прокурорын байгууллагын бүтэц зохион байгуулалтын талаар өөрийнхөө санал бодлыг хуваалцаж гэж бодлоо.

1. Шүүхийн бүтэц зохион байгуулалтын талаар: Монгол Улсын шинэ Үндсэн хуулиар шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ гэж заасан. Шүүх эрх мэдэл гэдэг нь төр, нийгэм иргэд, байгууллагын хуулиар хамгаалсан эрх ашгийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээж, гэм хорыг арилгах талаар шүүхээс хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа юм. Шүүх нь шүүн таслах ажиллагааг хэнээс ч хамааралгүйгээр эрхлэн явуулж, мөрдөн байцаалтаар урьдчилан тогтоогдсон нотлох баримтыг эцэслэн хянаж шүүгдэгчийн гэм буруутай эсэхийг тогтоодог цорын ганц газар байх учиртай.

Энэ утгаараа шүүх эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд голлох байр суурийг эзэлдэг, эцсийн шийдвэрийг гаргадаг, харин яллах болон өмгөөлөх талууд шүүхэд туслах үүрэгтэй байвал зохистой. Өөрөөр хэлбэл эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны цөм нь шүүн таслах ажиллагаа байх ёстой гэсэн үг. Гэтэл манай улсын хувьд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд шүүх бус харин яллах чиг үүргийг хэрэгжүүлдэг прокурор гол үүргийг гүйцэтгэж байна гэхэд хилсдэхгүй. Манай улсын шүүх нь прокуророос шилжин ирсэн эрүүгийн хэргийг зөвхөн яллах дүгнэлтийн хүрээнд шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд хэрэв прокурор хэрэг шилжүүлэхгүй бол мөрдөн байцаалтаас хэргийг татаж хянах эрх хэмжээ байхгүй юм.

Нийт бүртгэгдсэн хэргийн 21 % нь шүүхийн өмнөх шатанд хэрэгсэхгүй болж байгаа нь олон этгээдэд ял завших нөхцлийг бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл тухайн этгээдийн гэм буруутай эсэхийг шүүх бус мөрдөн байцаагч, прокурор тогтоож байна гэсэн үг. Түүнчлэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь үзлэг нэгжлэг хийх, гүйцэтгэх ажиллагаа явуулах, таслан сэргийлэх арга хэмжээ авах зэрэг ажиллагаанд шүүх бус яллах чиг үүргийг хэрэгжүүлдэг прокурор зөвшөөрөл өгч гүйцэтгэлд нь хяналт тавьж байгаа одоогийн практик буруу гэдэг нь харагдаж байна. Ганцхан жишээ дурьдахад 1998-2000 онд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага 13,0 хүнийг сэжигтэнээр

цагдан хорих зөвшөөрлийг прокуророос хүсэхэд прокурор - 94 % -д нь зөвшөөрөл өгч тогтоолыг баталсан ба эдгээр цагдан хоригдсон сэжигтний 51 %-д нь ял төлөвлөж хэргийг шүүхэд шилжүүлсэн байх юм. Гэм буруугүй 11,0 хүнийг 14 - 60 хүртэл хоног үндэсгүйгээр цагдан хорьсон нь Монгол улсад хүний эрхийг ямар ноцтойгоор зөрчиж байгааг харуулж байна. Иймд дээрх ажиллагаанд зөвшөөрөл өгдөг, гүйцэтгэлд нь хяналт тавих эрхийг ялах үүрэгтэй прокурор бус харин хөндлөнгийн шүүх эдлэх ёстой бөгөөд холбогдох хууль тогтоомжыг энэ чиглэлд яаралтай өөрчлөхгүй бол энэ мэтээр хүний эрхийг ноцтой зөрчсөөр байх нь тодорхой. Түүнчлэн шүүхийн бие даасан байдлыг хангахад чухал үүрэгтэй шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга нь хууль зүйн сайд байхаар заасан нь үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой зөрчилдөж байгаа бөгөөд шүүхийн ерөнхий зөвлөл нь Ерөнхийлөгчийн дэргэд байвал илүү зохимжтой юм.

2. Прокурорын байгууллагын талаар: Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлд зааснаар прокурор нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийг төлөөлөх үүрэгтэй. Үндсэн хуулийн 4 дүгээр бүлэг буюу "Шүүх эрх мэдэл" гэсэн бүлэгт Прокурорын байгууллагын тухай заалтыг оруулсан нь Прокурор төрийн засаглалын аль хэлбэрт хамаарах тухай асуудлыг хөндөхөөс аргагүйд хүргэж байна.

Эндээс харахад Монгол Улсын Прокурорын байгууллага нь шүүх эрх мэдлийн байгууллага мэт харагдавч хэрэг дээрээ аль ч засаглалд хамаарахгүй биеэ даасан дөрөв дэх засаглалын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа билээ. Дэлхийн бусад орнуудын жишгийг харахад прокурорын байгууллага нь гүйцэтгэх засаглалын хүрээнд тэр дундаа хууль зүйн яамныхаа харьяанд байж мөрдөн байцаалтыг бие даан явуулан шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцдог байна. Бидний хуулбарлан дуурайх дуртай ОХУ-д прокурорын байгууллага нь мөрдөн байцаалт явуулж шүүхэд төрийг төлөөлдөгөөс гадна мөрдөн байцаах ажиллагаанд нь шүүх хяналт тавьдаг байх жишээтэй.

Манай улс энэхүү жишгийн дагуу Прокурорын байгууллагын чиг үүргээс мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих үүргийг нь хасаад оронд нь мөрдөн байцаах эрхийг өгөх

нь зүйтэй. Прокурорын байгууллага хэрэг бүртгэх байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, хэрэг бүртгэлээс шилжүүлсэн хэрэгт мөрдөн байцаалт явуулан, мөрдсөн хэргээ шийдвэрлэх шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцож байх боломжтой. Харин мөрдөн байцаах болон ял эдлүүлэх ажиллагаанд шүүх хяналт тавих нь илүү зохистой юм.

3. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагын талаар: Өнөөгийн Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар мөрдөн байцаах ажиллагааг харьцангуй бие даасан байхаар тусгасан боловч мөрдөн байцаах байгууллагыг цагдаагийн байгууллагын харьяанд өгсөнөөрөө бие даасан байдлыг нь алдагдуулж байгаа юм. Ганцхан жишээ дурьдахад - мөрдөн байцаагч нь мөрдөж байгаа хэргийнхээ талаар Цагдаагийн газар, хэлтсийн даргад даалгавар өгөх эрхтэй боловч нөгөө талаар цагдаагийн офицерийн хувьд даргадаа захирагдах үүрэгтэй. Цагдаагийн мөрдөн байцаагч цагдаагийн албан хаагчийн холбогдсон хэргийг мөрдөн шалгахад хүндрэлтэй байдаг нь нууц биш. Иймээс дээр дурьдсанаар мөрдөн байцаах байгууллагыг прокурортой нэгтгэн бие даасан үйл ажиллагаа явуулах бололцоо нөхцөлөөр хангах шаардлагатай. Харин энэхүү бие даасан байгууллага нь хууль зүйн яамны харьяанд үйл ажиллагаа явуулдаг бие даасан агентлагийн хэмжээнд зохион байгуулалтыг хийж болох талтай.

Зарим судлаачид хэрэг бүртгэх болон мөрдөн байцаах үе шатуудыг нэгтгэх нь зөв гэсэн саналтай байдаг. Гэтэл хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт нь харьцангуй биеэ даасан өөр үе шатууд бөгөөд нэгтгэх боломжгүй юм. Хэрэг бүртгэлтийг олон субъект / цагдаа, гааль, хил, татвар г.м / явуулдаг байхад мөрдөн байцаалтыг олон субъект явуулдаггүй онцлогтой. Практикаас харахад хэрэг бүртгэх байгууллагаас хэрэг бүртгэлт хийж ирүүлсэн эрүүгийн хэргүүд нь бүрдэл дутуу, шалгавал зохих үйл баримтыг дутуу шалгасан байх нь олон бөгөөд энэ бүхэнд мөрдөн байцаах байгууллага ямар нэг хэмжээгээр хяналт тавьж байгаа ч нэгэнт прокурор хэрэг бүртгэлтээс мөрдөн байцаалтад шилжүүлсэн тогтоол үйлдсэн бол уг хэргийг хүлээн авахаас өөр аргагүйд хүрдэг. Хэрэг бүртгэх байгууллагад мөрдөн байцаах байгууллага өөрөө бүрэн хэмжээгээр хяналт тавих нь үйл ажиллагааны давхардлыг арилгаж, мөрдөн байцаах байгууллагын ачааллыг

багасгаж чадах ач холбогдолтой.

Эцэст нь дүгнэхэд хууль сахиулах байгууллагуудын тогтолцоог дээрх байдлаар өөрчлөн зохион байгуулах нь Үндсэн хуулиас / 56, 57 -р зүйл / эхлээд Эрүүгийн байцаан шийтгэх хууль, шүүх, прокурор, цагдаагийн байгууллагын тухай хууль зэрэг олон хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулахаас эхлээд олон хүндрэлтэй асуудалтай тулгарах боловч хэзээ нэгэн цагт бүтцийн өөрчлөлт хийгдэж таарах нь мэдээж бөгөөд энэ чиглэлд тус нэмэр болгох зорилгоор өөрийн бодол саналаа нэмэрлэж байна.

БАРЬЦААНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТУХАЙД

Даш-Оволтын ДҮГЭРЖАВ

Санхүү Эдийн Засгийн Дээд Сургуулийн дэд профессор

Монгол Улсын Иргэний хуулийн төсөл боловсруулах ажил Хууль зүйн сайдын тушаалаар баталсан ажлын хэсгийнхний хувьд төгсгөлийнхөө шатанд ороод байгаа энэ үед уг төслийн агуулгын талаар бүх нийтээр нэгдсэн ойлголттой болох шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Шинэ төслийн нэг онцлог нь "Эдийн ба эдийн бус баялгийн тухай" шинэ дэд хэсэг оруулж, түүндээ эдийн болон эдийн бус баялгийн тухай, эзэмшлийн тухай, мөн өмчийн эрх зүйн үндсэн асуудлын иргэний эрх зүйн зохицуулалтыг тусгаснаас гадна энэ дэд хэсэгт барьцааны эрхийг нэг бүлэг болгон оруулсан юм. Одоогоор хуулийн төслийн энэ бүтэц олон хуульчдад зохих тайлбар шаардсан асуудлын нэг болох нь урьдчилсан хэлэлцүүлгийн явцад харагдаж байна. Зөвхөн энэ асуудлаар ажлын хэсгийн гишүүний хувьд санал солилцох зорилгоор энэхүү өгүүдлийг уншигч Танаа толилуулж байна.

Үүргийн гүйцэтгэлийг хангах аргуудын дотор барьцаа чухал байр суурь эзэлдэг. Энэ бол Ромын эрх зүйгээс эхэлсэн олон зуун жилийн түүхтэй иргэний эрх зүйн институт юм.

Ромын эрх зүйд барьцааны хөгжлийн эхний үе шатанд үүрэг гүйцэтгүүлэгчийн эрх ашиг давамгайлж байлаа. Барьцааны зүйл болох үүрэг хүлээгчийн эд хөрөнгө нь үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилждэг байв. Гэхдээ үүрэг хүлээгч өрөө хугацаанд нь барагдуулсан тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч барьцааны зүйлийг үүрэг хүлээгчид буцааж өгөх үүрэг хүлээхээр гэрээнд заана. Үүрэг хүлээгч өөрийн эд хөрөнгөө үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлснээрээ үүргээ зохих хэмжээнээс илүү өндөр түвшинд хангаж байлаа. Ийм харилцаа нь гагцхүү итгэл (fides) дээр үндэслэгдэнэ. Иймд барьцааны энэ хэлбэрийг фидуци гэнэ.

Барьцааны фидуцийн гэрээ нь одоо хир нь англи-америкийн эрх зүйд өөрийн ач холбогдлоо алдаагүй. Фидуцийн хэлбэрийн барьцаа нь Ромын эрх зүйн сонгодог үе шатанд ч оршоор байсан боловч пигнус /pignus/ ипотека /hypotheca / зэрэг барьцааны

өөр хэлбэрүүд давуутай хөгжсөн.²⁵

Пигнус хэлбэрээр барьцаалахад үүрэг хүлээгч үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор фидушийн нэгэн адил өөрийн эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгчид шилжүүлдэг боловч өмчлөлд нь биш харин эзэмшилд нь шилжүүлдэг. Үүрэг хүлээгч нь барьцааны үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрөлтэйгөөр уг эд хөрөнгөө, жишээ нь, түрээслэгчийн хувьд ашиглах эрхээ хадгалдаг.

Газрын барьцааны хөгжлийн цаашдын үе шатанд дорнын /Грек, Египет/ эрх зүйн нөлөөгөөр грекийн ипотека гэдэг нэрээр нэрлэгдэх болсон Ромын эрх зүйн шинэ институт үүссэн.

Пигнусээс ялгаатай нь ипотекийн үед барьцаалсан эд хөрөнгийн эзэмшил нь үүрэг гүйцэтгүүлэгчид шилжихгүй бөгөөд үүрэг хүлээгч барьцааны зүйлээ өөрийн эзэмшилд үлдээдэг.

Ромын барьцааны эрх зүйд ипотекийг төрийн байгууллагад бүртгүүлэх тухай заагаагүй бөгөөд нэг эд хөрөнгийг хэд хэдэн барьцаалагчид баруулахад барьцаа баригчдын дарааллыг ипотекийн тухай гэрээгээр тохиролцож шийдвэрлэдэг байв.

Үүрэг хүлээгч үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгчийн үндсэн эрх нь барьцааны зүйл болох эд хөрөнгийг худалдах явдал байв.

Барьцааны тухай гэрээнд барьцааны зүйл болох эд хөрөнгийг худалдахыг хориглож заасан байлаа ч үүрэг гүйцэтгүүлэгч гурван удаа үүрэг хүлээгчид мэдэгдсэний дараа борлуулах эрхтэй байв. Түүнчлэн талууд тохиролцсон зарим тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч барьцааны зүйл болох эд хөрөнгийг өөртөө үлдээх эрхтэй байв. Ийм тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжсэн эд хөрөнгөө үүрэг хүлээгч нэг жилийн дотор худалдаж авах боломжийг олгодог байв.

Ромын эрх зүйд шаардах эрхээ барьцаалах, барьцааны зүйлийг дахин барьцаалуулахаар хэд хэдэн гэрээ байгуулах, бараатай агуулах, дэлгүүрийг барьцаалах тухай ч заадаг байжээ.

Ромын эрх зүйг судлаач цивилистүүд Ромын эрх зүй дэх барьцааны харилцааны орчны тухай янз бүрийн дүгнэлт хийж,

²⁵ Римское частное право: Учебник, под ред. проф. И.Б. Новицкого и Проф. И.С.Перетерского. М.,1996. 340 дүгээр тал

үүний үр дагавар нь орчин үеийн иргэний эрх зүй дэх барьцааны эрх зүйн орчныг үнэлэх янз бүрийн хандлагыг санал болгодгийг тэмдэглэх нь зүйтэй. Энэ талаар хууль цаазны шинжлэх ухаанд 100 гаруй жил маргаан өрнүүлж байгаа боловч одоо хир шинжлэх ухаан үүнийг нэг мөр шийдвэрлээгүй л байна.

Мейерийн үзэж байгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангах аргуудын нэг болох барьцаа нь үүрэг хүлээгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ зөрчихөд барьцааны эрх авсан этгээд барьцааны зүйл болох эд хөрөнгийг худалдсан үнээс үүргээ хангуулах эрхтэй байдаг учраас барьцаа нь бусдын эд юмсын талаарх эрх юм.²⁶

Кавелин барьцаа (барьцаа баригчийн хадгалж байгаа болон барьцаалуулагчийн хадгалж байгаа) нь үүргийн гүйцэтгэлийг хангах арга бөгөөд түүний мөн чанар нь үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд гүйцэтгэлийг хангах зориулалт бүхий барьцааны зүйлээс гаргуулан авахад оршино гэж тодорхойлсон.

Гантовер үзэхдээ Оросын иргэний эрх зүйн хууль тогтоомжийн дагуу барьцаа бол үүрэг хүлээгчийн тодорхой эд хөрөнгөөр гэрээнд итгэгч нөгөө талын шаардлагыг ирээдүйд хангах хэрэгсэл юм. Энэ утгаараа барьцаа нь хувийн шинж чанар бүхий давуу эрх юм. Хуульд зааснаар өв залгамжлахаас бусад тохиолдолд үүрэг хүлээгч ба үүрэг гүйцэтгүүлэгч өөрчлөгдөж болдоггүй бөгөөд энд яг эд хөрөнгөтэй шууд холбогдсон эрх гэдэг утгаар нь хууль ач холбогдол өгдөггүй. Эд юмсын эрхээс барьцааны ялгагдах өөр нэг онцлог бол барьцаа нь бусад эд юмсын эрхтэй харьцуулбал бие даан оршдоггүй, үүргийн гүйцэтгэлийг хангах хэрэгслийн хувьд уг үүрэггүйгээр барьцаа дангаар оршихгүй, үндсэн үүргийн нэмэгдэл буюу аксессуар ач холбогдолтой байдаг гэж Гантовер үздэг.

Варадинов үүний эсрэгээр барьцаа бол бусдын эд хөрөнгөөр хангагдах эрх юм. Түүнд ипотека буюу эд юмсын эрхийн шинж чанар агуулагддаг, үүний нотолгоо бол нэгдүгээрт, хууль зээлийн гэрээ болон бусад гэрээг барьцаа /барьцаа баригчийн хадгалж байгаа болон барьцаалуулагчийн хадгалж байгаа/-гаар хангахыг зөвшөөрдөг, хоёрдугаарт, хууль хэд хэдэн гэрээг нэгэн зэрэг нэг

²⁶ Анненков, К. Система русского гражданского права. т. III: Права обязательственные. СПб., 1901. 343-345 дугаар тал

барьцаагаар хангахыг зөвшөөрдөг гэж үзжээ. Варадиновын нэгэн адил Шершеневич барьцааг эд юмсын эрхэд хамааруулжээ. Тэр бичихдээ "Барьцааны эрх гэдэг бол үүргийн дагуу шаардах эрхээ хангуулах итгэмжлэгчийн уг эд юмсын үнэ цэнээс хангагдах боломжоор илэрхийлэгдсэн бусдын юмсын хувьд эдлэх эрх юм" гэжээ.

Шершеневич барьцааны эрхийн шинж чанарыг гурван янзаар тодорхойлсон.

1. Барьцааны эрх бол бусдын эд юмсын эрхийн бүлэгт хамаарах эд юмсын эрх юм. Түүний объект нь эд юмс байх бөгөөд нэг этгээдээс нөгөөд шилжиж байдаг ч өмчлөх эрхээс үл шалтгаалдаг барьцааны эрхийн эд юмсын шинж чанар илрэн гарна.

2. Барьцааны эрх бол бусдын эд юмсын хувьд эдлэх эрх юм. Яагаад гэвэл бусдын эд юмсын үнэ цэн л шаардах эрхийг хангадаг. Барьцааны зүйл нь барьцаалагчийн өөрийнх нь эд юм байж болдоггүй. Барьцаалсан эд хөрөнгийг барьцаалагч өмчлөн авбал барьцааны эрх дуусгавар болно.

3. Барьцааны зорилго нь шаардах эрхийг хангахад оршдог тул барьцааны эрх нь өөр үүргийн харилцаа заавал байхыг шаарддаг нэмэлт харилцаа юм. Хууль тогтоомж нь барьцааг үүргийн гүйцэтгэлийг хангах хэрэгслийнх нь хувьд авч үзэж түүний аксессуар шинжийг нь хүлээн зөвшөөрдөг. Нэмэгдэл эд юмсын эрхийнх нь хувьд барьцааны эрх нь үүргийн эрхээс түрүүлж үүсэхгүй, үүргийн харилцаа дуусгавар болбол цаашид үргэлжлэхгүй. Иймд үүсээгүй байгаа үүргийн тодорхой эд юмсыг барьцаанд тавих тухай хоёр этгээдийн хооронд хэлэлцэн тохиролцсон тохиолдолд үүргийн харилцаа тогтоосноор л эд юмсын эрх үүснэ.²⁷

Барьцааны эрх зүйн орчны тухайд эсрэг байр суурьтай байгаа Гантовер, Шершеневич нар барьцааны эрхийн аксессуар шинжийг хэрхэн өөрийн үзэл баримтлалыг нотлох аргумент болгон тайлбарласныг бид эндээс харж болно. Шершеневич барьцааны эрх бол эд юмсын эрх гэдэг тал дээр хатуу зогсохын

²⁷Шершеневич Г.Ф. Учебник русского гражданского права (по изданию 1907г.). М., 1995. 240-241 дүгээр тал

сацуу барьцааны эрхийн бусад эд юмсын эрхээс ялгагдаж байгаа зарим онцлогт анхаарлаа хандуулж, бусад эд юмсын эрхээс эсрэгээр барьцааны эрх нь бие даасан ач холбогдолгүй бөгөөд үүргийн дагуу үүсэх эрхээс шууд хамааралтай гэдгийг юуны өмнө анзаарсан. Барьцааны эрх нь барьцаа баригчид барьцааны зүйлийг эзэмших, ашиглах эрх олгодоггүй. Гэтэл эд юмсын бусад эрхийн агуулга нь харин ч эд юмсыг ашиглахад оршино. Гэхдээ барьцааны эрх нь субъектдээ бусад эд юмсын эрхийг бодвол харьцангуй том эрх олгоно. Өөрөөр хэлбэл барьцааны эрх нь өмчлөгч өмчлөх эрхээ алдахад хүргэж ч болдог.

Барьцааны эрхийн эрх зүйн орчны талаар 19 дүгээр зууны сүүлчээр хууль цаазны бүтээлүүдэд өрнөсөн хэлэлцүүлгийн дүнг нэгтгэж Анненков тэмдэглэхдээ "Оросын цивилистүүдийн заримынх нь үзэж байгаагаар барьцаа нь хувийн эрх өөрөөр хэлбэл үүргийн эрх зүйд илүү ойролцоо, харин бусдынх нь үзэж байгаагаар барьцааны эрх нь яах ч аргагүй эд юмсын эрх гэж тооцоогдох ёстой, гуравдах хэсгийн үзэж байгаагаар барьцааны эрх нь эд юмсын эрх гэж тооцоогдох ёстой боловч энэ нь хуулиар баталгаажгаагүй юм" гэжээ. Анненков өөрөө барьцааны эрхийг эд юмсын эрхийн хэд хэдэн шинжийг агуулдаг боловч хувийн эрх /үүргийн/ гэдгийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзжээ.²⁸

Орос дахь барьцааны эрх зүйн түүхийг авч үзэх юм бол дээр дурдсанчлан барьцааны эд юмсын эрх зүйн концепцийг хатуу баримтлагч Шершеневичийн энэ асуудлаар хийсэн судалгааг авч үзэх нь зүйтэй. Шершеневич эртний Оросын барьцааны эрх нь барьцааны зүйл нь үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилждэг, хугацаандаа үүргээ биелүүлсэн үүрэг хүлээгч барьцааны зүйлийг худалдаж авах эрхийг хадгалдаг эртний Ромын fiducia-тай ижил байсан гэж Мейерийн үзэснийг маргаж, тэр үеийн барьцааны үнэмлэхүүдийг судалж үзвэл барьцааны зүйлийг өмчлөх эрх нь үүрэг гүйцэтгүүлэгчид барьцаа тогтоогдсон үеэс бус, хугацаа хожимдуулсан үеэс эхэлдэг байсан гэж тэмдэглэжээ. 16 дугаар зуунд хөдлөх эд юмсын тухайд барьцааны эрх нь үүрэг хүлээгч хугацаа хэтрүүлсэн үеэс итгэмжлэгчийн өмчлөлийн зүйл болдог үзэл баримтлалыг өөрчлөх оролдлого ажиглагдаж, барьцааны

²⁸ Анненков, К. Дурисан бүтээл. 342 дугаар тал

эрхийг бусдын эд юмсын тухайд эдлэх эрх гэдгийг хүлээн зөвшөөрч эхэлсэн.

1557 оны хуулиар хөдлөх эд юмс барьцаалсан үүрэг гүйцэтгүүлэгч нь хугацаа хожимдуулбал эд юмсаа алдана гэдгийг үүрэг хүлээгчид урьдчилан сануулах үүрэгтэй. Үүний дараа үүрэг хүлээгч өрөө төлөхгүй бол үүрэг гүйцэтгүүлэгч барьцааны зүйлийг гэрчүүдийг байлцуулан худалдаж, өөрийн шаардлагыг хангаж илүү гарсан мөнгийг эд юмсын өмчлөгчид өгөх үүрэгтэй. Худалдсан үнэ нь өр болон хүүг төлөхөд хүрэлцэхгүй бол үүрэг хүлээгч үлдсэн хэсгээ үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хариуцсан хэвээр байсан гэж Шершеневич тэмдэглэжээ. Үүний дараа Оросын барьцааны эрх зүйд үүрэг хүлээгч өөрийн үүргээ хугацаанд нь төлөөгүй тохиолдолд барьцааны зүйл болох хөдлөх болон үл хөдлөх эд юмс нь үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилждэг нэг хэсэг үе байсан. 1635 оны хуулиар үүрэг хүлээгч хугацаа хэтрүүлбэл үүрэг гүйцэтгүүлэгчийн хүсэлтээр үл хөдлөх юмс түүнийх болдог байв. Харин 17 дугаар зууны үед барьцаа нь Орост үүргийн эрх зүйн шинжийг агуулах болсон. 1737 оны хуулиар барьцааны зүйл нь үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчид шилжихээ больж, түүнийг нийтийн дуудлага худалдаагаар борлуулдаг болжээ. Худалдсан үнэ нь үүргийн хэмжээнээс их байвал үлдэгдлийг нь барьцааны зүйлийн өмчлөгчид нь буцааж олгодог.

1800 оны Дампуурлын дүрэм гарснаар үл хөдлөх эд юмсын хувьд заавал нийтийн дуудлага худалдаагаар борлуулах журам батлагдсан байна. Хөдлөх юмсын тухайд хууль тогтоогч хуучин журмаа хадгалж, үүрэг хүлээгч худалдахыг шаардаагүй бол барьцааны зүйл үүрэг гүйцэтгүүлэгчийн өмч болдог журамтай байв. Үүрэг хүлээгчийн шаардсаны дагуу худалдсан үнэ нь үүргийн хэмжээнээс бага бол үүрэг гүйцэтгүүлэгч үлдсэн мөнгөө үүрэг хүлээгчийн бусад өмчөөс гаргуулахаар шаардах эрхтэй байжээ.

Бусад орнуудад барьцааны эрх зүй мөн өөр өөр хөгжсөн. Ихэнх эрх зүйн системд барьцааг эд юмсын эрхийн төрөл гэж үздэг. Энэ нь тухайлбал, үүрэг хүлээгч дампуурсан тохиолдолд барьцаагаар хангагдсан барьцааны зүйл болох эд хөрөнгийг үүрэг хүлээгчийн өмч биш гэдэг утгаар дуудлага худалдаагаар оруулах эд хөрөнгөнд оруулдаггүй, үүрэг гүйцэтгүүлэгчийн хангагдах

шаардлагыг барьцааны зүйлийн үнээс ердийн журмаар хангуулдгаар илэрдэг.

Англи Америкийн системд хөдлөх эд юмсын барьцаа хоёр хэлбэртэй.

"Pledge" гэдэг нь барьцааны зүйлийг барьцаа баригчийн эзэмшилд шилжүүлэхийг хэлнэ.

"Mortgage" гэдэг нь үүрэг гүйцэтгүүлэгч нь барьцааны зүйлийн өмчлөгч болдог фидуцийн хэлцэл юм.

Гэхдээ үүрэг хүлээгч барьцаагаар хангагдсан үүргээ гүйцэтгэчихвэл барьцааны зүйлийн өмчлөл барьцаалуулагчид буцаж шилжинэ. Үүрэг хүлээгч үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч-барьцаа баригч нь мөн барьцааны зүйлийг үүрэг хүлээгчийн эзэмшилд шилжүүлж өөрийн шаардлагыг хангуулахын тулд нийтийн дуудлага худалдаагаар худалдахыг шаардах эрхтэй.

Үүргийн харилцаанд барьцаагаар хангагдсан үүрэг гүйцэтгүүлэгчийн үндсэн эрх нь эх газрын Европын орнуудад барьцааны зүйлийг албадан худалдаж, түүний үнээс өөрийн шаардлагыг тэргүүн ээлжинд хангуулах давуу эрх олгоход оршдог боловч жишээ нь, Францын эрх зүйгээр үүрэг гүйцэтгүүлэгч нь шүүхийн зөвшөөрөл, шинжээчийн дүгнэлтийг үндэслэн барьцааны зүйлийг үүргийн гүйцэтгэлд өөрийн өмчлөлд үлдээх эрхтэй байна. Германд барьцааны эрх зүйн харилцаанд Sicherungsübereignung -өөртөө авч хангагдах гэж нэрлэгдэх практик байдаг. Үүнд, үүрэг хүлээгчийн ашиглалтанд үлдсэн барьцааны зүйл болох үйлдвэр нь үүрэг гүйцэтгүүлэгчийн өмч болох бөгөөд үүрэг хүлээгч барьцаагаар хангагдсан үүргээ гүйцэтгэсэн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч үйлдвэрийг барьцаалуулагч -үүрэг хүлээгчийн өмчлөлд буцаан шилжүүлэх үүрэгтэй байдаг фидуцийн хэлцэлийн зохион байгуулалт хэрэглэгддэг.²⁹ Герман, Японы иргэний хуулийн бүтцийг авч үзвэл "Эд юмсын эрх" гэсэн хэсэгт барьцаа, үл хөдлөх хөрөнгийн барьцааны зохицуулалтыг байрлуулсан нь барьцаа нь эд юмсын

²⁹ Гражданское и торговое право капиталистических государств под ред. Е.А.Васильева. М., 1992. 233-234 дүгээр тал

эрх зүйн шинжийг тодорхойлж байна гэж дүгнэж болох юм.

Хүчин төгөлдөр мөрдөж байгаа Монгол Улсын Иргэний хуулийг хэлбэр талаас нь харвал барьцааны эрх зүй нь үүргийн эрх зүйн институт юм. Үүнийг барьцааны тухай хэм хэмжээний

Монгол Улсын Иргэний хуулийн бүтэц дэх байрлал нотолно.

Барьцааны тухай 181 дүгээр зүйл, ипотекийн тухай 181-1 дүгээр зүйл нь Монгол Улсын Иргэний хуулийн "Үүргийн тухай нийтлэг үндэслэл" нэртэй 3 дугаар хэсгийн "Үүргийн гүйцэтгэлийг хангах" гэсэн 15 дугаар бүлэгт байдаг. Иргэний хуулийн "Өмчийн эрх зүй" гэсэн 2 дугаар хэсэгт барьцааны харилцааг зохицуулсан ямар нэгэн хэм хэмжээ байдаггүй. Нөгөөтэйгүүр олон жилийн турш бид хойд хөршийнхөө эрх зүйн системийг хуулбарлаж ирсэнтэй ч холбоотой.

Барьцаа бол үүргийн эрх зүйн институт гэж үзэж байгаа сүүлийн үеийн төлөөлөгчийн нэг В.В.Витрянский барьцааны үүргийн эрх зүйн шинж чанарыг нотолсон, барьцааны харилцааг зохицуулсан хэд хэдэн тусгай журам Оросын Холбооны Улсын

Иргэний хуулиар тодорхойлогддог гэж үзэснийг бидний зүгээс тайлбарлах шаардлагатай хэмээн үзэж байна.

Нэгдүгээрт: ОХУ-ын Иргэний хуульд зааснаар барьцааны зүйл нь эд хөрөнгө төдийгүй эд хөрөнгийн эрх байж болно. Эд хөрөнгийн эрх бол жишээ нь шаардах эрх, дангаараа ямар ч нөхцөлд эд юмсын эрх зүйн объект болж чадахгүй хэмээн Витрянский үзжээ. Эд хөрөнгийн эрх нь векселээр илэрхийлэгдэх мөнгө төлөхийг шаардах эрх, хувьцаагаар илэрхийлэгдэх ногдол ашиг авах, санал өгөх, компани татан буугдахад үлдсэн эд хөрөнгөөс авах эрх, аливаа эд хөрөнгийг эзэмших эрх, ашиглах эрх гэх мэт янз бүрийн хэлбэрээр илрэх бөгөөд эдгээр нь мөн чанараараа эд хөрөнгө биш бөгөөд жинхэнэ эд юмсын эрх юм.

Вексель, хувьцаагаар илэрхийлэгдэх эрх, ашигт малтмалын орд ашиглах эрх, орон сууц хөлслөх эрх зэрэг нь барьцааны зүйл байж болно. Витрянскийн ойлгож байгаагаар барьцааны зүйл нь эд юмсын эрх болж байвал барьцаа нь эд юмсын эрх зүйн институт болох юм бол харин ч түүний иш татсан Иргэний хуулийн заалт нь барьцаа бол эд юмсын эрх гэдгийг нотолж байна.

Хоёрдугаарт: Иргэний хууль ирээдүйд барьцаалуулагчид бий

болох /жишээ нь ирэх жилд үйлдвэрлэх бүтээгдэхүүн/ эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх барьцааны зүйл байж болохыг хүлээн зөвшөөрсөн. /Монгол Улсын Иргэний хуулийн 181-1 дүгээр зүйлийн 9-д ч ийм заалт бий/. Өөрөөр хэлбэл барьцааны эрх нь ямар нэг субъектийн зүгээс, өмчийн эрх нь ч тогтоогдоогүй, эд хөрөнгийн эрх нь ч тогтоогдоогүй байгаа ирээдүйд бий болох эд юмсын тухайд үүсч болно. Өмчлөх эрх нь өмчлөлийн зүйлийг шилжүүлсэн үеэс үүснэ. Мөн цөөнгүй тохиолдолд хөрөнгө оруулалтыг барьцааны зүйл болгон ашигладаг. Барьж байгуулж байгаа үл хөдлөх эд хөрөнгийн тухайд өмчлөх эрх нь үл хөдлөх хөрөнгийг улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ. хэмээн Витрянский тэмдэглэжээ. Энд ч мөн ялгаагүй бодитой бий болоогүй байгаа эд хөрөнгө барьцааны зүйл болж байгаа нь ирээдүйд бий болох эд хөрөнгийн талаар барьцаа баригчийн эдлэх эд юмсын эрхийг тодорхойлж байгаа хэрэг билээ.

Гуравдугаарт: барьцаа баригч барьцааны тухай гэрээнд заасан эрхээ Иргэний хуульд зүйлд заасан шаардах эрхээ шилжүүлэх журмын дагуу өөр этгээдэд шилжүүлж болно. Шаардах эрхээ шилжүүлэх гэдэг бол гагцхүү үүргийн эрх зүйн институт билээ. Эд юмсын эрхийг цессийн журмаар өөр этгээдэд шилжүүлдэггүй хэмээн зохиогч үзсэн. Шаардах эрх шилжүүлэх явдал нь үүргийн эрх зүйн институт гэдэг нь маргаангүй. Харин эд юмсын эрхийг цессийн журмаар шилжүүлдэггүй гэснийг хүлээн зөвшөөрөх үндэсгүй юм. Жишээ нь, шилжүүлгийн вексель нь жинхэнэ цессийн журмаар мөнгө төлүүлэн авах эрхээ шилжүүлж байгаа хэрэг билээ.

Дөрөвдүгээрт: барьцааны харилцааны үүргийн эрх зүйн орчныг тодорхойлж байгаа нэг хүчин зүйл бол үүрэг хүлээгч хуулийн этгээд татан буугдах үед, тухайлбал дампуурсан тохиолдолд, барьцааны зүйл болох эд хөрөнгийг үүрэг хүлээгчийн хуваарилагдах эд хөрөнгөөс /дуудлагын худалдаанд оруулах эд хөрөнгөөс/ тусгаарлаж авдаггүй бөгөөд үүрэг гүйцэтгүүлэгч-барьцаа баригчийн шаардлагыг тэргүүн ээлжинд /бүр барьцаанд бариулаагүй эд хөрөнгийг худалдаалсан үнээс/ хангадгаар илэрнэ³⁰ гэжээ. Дампуурлын тухай Монгол Улсын хууль /

³⁰ Витрянский, В.В. Браинский, М.И. Договорное право. М., 1998. 403 дугаар тал

"Төрийн мэдээлэл" / 1998, №1/-ийн 35 дугаар зүйлд зааснаар дампуурлын үед хариуцагчийн мөнгөн хөрөнгөнөөс нэхэмжлэлийн шаардлагыг хангахдаа бусдын амь нас, эрүүл мэндэд учруулсан гэм хорыг арилгуулахаар гаргуулах төлбөр, хэрэг гүйцэтгэгчийн цалин хөлс, хэрэг гүйцэтгэгчийн эрх үүргийнхээ хүрээнд буюу шүүх, нэхэмжлэгчдийн хурлын зөвшөөрөлтэйгөөр явуулсан үйл ажиллагааны зардал, хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх явцад байгуулсан гэрээ, хэлцлийн дагуух нэхэмжлэлийн шаардлагыг хангасны дараа барьцаат нэхэмжлэлийн шаардлагыг хангахаар заасан байдаг тул барьцаат нэхэмжлэлийг тэргүүн ээлжинд хангахгүй байгаа нь харагдаж байна.

Тавдугаарт: барьцаа баригч-үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг барьцааны зүйлийг гагцхүү дуудлага худалдаагаар худалдах замаар хангана. Хуулийн энэхүү зохицуулалт нь барьцааны зүйлийг үүрэг гүйцэтгүүлэгч шууд өөрийн өмчлөлд шилжүүлдэг фидуцийг үгүйсгэж байгаа юм гэжээ. Манай Иргэний хуульд энэ заалт нэгэн адил байгаа. Зөвхөн фидуцийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд барьцаа нь эд юмсын эрх болдог мэтээр нотлох нь учир дутагдалтай юм. Ер нь иргэдийн хооронд фидуци маягаар барьцаа баригч барьцааны зүйлийг өмчлөн авч барьцааны гэрээг дуусгавар болгодгийг хэн ч үгүйсгэхгүй. Энэ байдал барьцаалан эзэлдүүлэх үйл ажиллагааны өнөөгийн практик, банкны хуулиар зөвшөөрөгдсөн байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Оросын холбооны улсын иргэний хуульд барьцааны эрх зүй нь үүргийн эрх зүйн институт болохыг нотолсон өөр 2 зохицуулалт байдгийг зохиогч авч үзсэн. Үүнд:

1. Оросын Холбооны Улсын Иргэний хуулийн 313 дугаар зүйлийн 2-г: "Үүрэг гүйцэтгүүлэгч барьцааны зүйлээс үүрэг гүйцэтгүүлэхээр шаардсаны улмаас уг эд хөрөнгийн талаарх эрхээ алдах аюул тулгараад байгаа гуравдагч этгээд /гүрээсийн болон барьцааны эрх гэх мэт/ үүрэг хүлээгчийн зөвшөөрөлгүйгээр үүрэг хүлээгчийн шаардлагыг өөрийн хөрөнгөөр хангах эрхтэй" гэж заасан нь барьцааны харилцааны үүргийн эрх зүйн шинж чанарыг илүү тодотгож байна.

2. Мөн Оросын Холбооны Улсын Иргэний хуулийн 345 дугаар

зүйлийн 2-т: "Барьцааны зүйл уствал барьцаалуулагч түүнийг өөр ижил үнэ цэн бүхий эд хөрөнгөөр солих эрхтэй". Ийм журам аливаа эд юмсын эрхэд хамаарах эд хөрөнгийн хувьд тогтоодоггүй хэмээн Витрянский бичжээ.

Энэ хоёр үндэслэлийн хувьд ямар нэг тайлбар хийх зүйлгүй байна. Угаас 100 жилийн турш маргаан үргэлжилсэн нь уг асуудал хичнээн ярвигтай болохыг илэрхийлж байгааг хүлээн зөвшөөрсөн хэрэг гэж хэн нэг нь дүгнэх боломжийг үлдээсэн хэрэг юм.

1994 оны 12 дугаар сарын 27-нд батлагдсан Казакстаны Иргэний хуулийн ерөнхий ангид анализ хийсэн Н.К. Сулейманов, Е.Б. Осипов нар "барьцааны эд юмсын эрх зүйн буюу үүргийн эрх зүйн шинж чанарын тухай маргааныг барьцааны эрх зүйн хоёрдмол орчныг хүлээн зөвшөөрснөөр шийдвэрлэж болно. Барьцаа нь хоёр төрлийн харилцааг үүсгэдэг. Барьцаалуулагч ба барьцаа баригчийн хооронд үүсэх харилцаа, барьцаа баригч ба эд юме хоорондын харилцаа. Өөрөөр хэлбэл, нэг талаас, барьцаа нь барьцаалуулагчийн үүргийг барьцаа баригчтай харьцангуй эрх зүйн холбоо тогтоох замаар гүйцэтгэлийг нь хангах арга, нөгөө талаас, барьцаа баригч ба эд юме хоорондын шууд эрх зүйн холбоо. Иймд барьцаа бол үүргийн гүйцэтгэлийг хангах эд юмсын арга юм" гэжээ.³¹

Зохногчид барьцааны эрх зүйн үүргийн шинж чанарыг илэрхийлсэн хуулийн олон хэм хэмжээний талаар тайлбарлаад эцэст нь барьцааны зүйлийн талаарх барьцаа баригчийн эрхийг хамгаалахтай холбогдсон асуудлыг авч үзэхдээ барьцааны эрх зүйн харилцааны эд юмсын эрх зүйн шинж чанар луу эргэж орсон байна. Тэд тэмдэглэхдээ:

"Барьцааны эрхийн эд юмсын эрхийн шинж чанар нь үүрэг гүйцэтгүүлэгчийн өөрийнхөө болон барьцаалуулагч/үүрэг хүлээгч/-ийн эзэмшлээс гарсан барьцааны зүйлийг шаардан нэхэмжлэх эрхээр илүү тодорхой илэрдэг "барьцааны харилцааны нөгөө тал болох барьцаалуулагчтай харьцуулбал юуны өмнө барьцаа баригчийн эрх гэдэг утгаар илэрч, барьцааны эрх нь гуравдагч этгээдийн үйлдсэн зөрчлөөс хамгаалагдаж байгаагаараа

³¹ Сулейманов, Н.К. Осипов, Е.Б. Экономическое право. Алматы: Экспресс, 1997.5 дугаар тал

өмчлөх эрхтэй төстэй байна" гэжээ.¹²

Зохиогчид энэ дүгнэлтийг хийхдээ Казакстаны Иргэний хуулийн 316 дугаар зүйлийн "Үүрэг гүйцэтгүүлэгч өөрийн болон барьцаалуулагч /үүрэг хүлээгч/-ийн эзэмшлээс гарсан барьцааны зүйлийг хууль бус эзэмшигчийн эзэмшлээс шаардан нэхэмжлэх эрхтэй" гэсэн заалтыг үндэслэжээ.

/Монгол улсын 181 дүгээр зүйлийн 11-д "барьцаалагчаас буюу хадгалж байсан үүрэг хүлээгчийн хадгалалтаас гарсан барьцаалагдсан эд хөрөнгийг барьцаалагч нэхэмжлэх эрхтэй" гэж заасан/

В.В.Витрянский бичихдээ Иргэний хуульд барьцааны зүйлийн талаарх өөрийн эрхийг хамгаалах барьцаа баригчийн эрхийн тухай хэм хэмжээний зэрэгцээ өмчлөх эрх болон бусад эд юмсын эрхийн /Оросын Холбооны Улсын Иргэний хуулийн 20-р бүлэг / тухай хэм хэмжээнүүдийг оруулсан нь харин ч хууль тогтоогч барьцаа бол эд юмсын эрхэд хамаарахгүй гэдэг зарчмын үүднээс хандсан гэдгийг илэрхийлж байгаа юм. Тиймгүйсэн бол барьцааны эрх зүйн харилцаанд өмчлөгчийн эрх, бусад эд юмсын эрхийг хамгаалах тухай заалтууд нь шууд хэрэглэгдэх билээ¹³ хэмээн Сулейманов, Осипов нартай санал нэгдэхгүй байгаагаа илэрхийлжээ. Тэрээр цааш өгүүлэхдээ: хууль бус эзэмшлээс барьцааны зүйлийг шаардах хамгаалалтын аргыг хэрэглэх эрхийг барьцаа баригчид олгосон нь түүний эрхийг /эрх зүйн орчны хувьд үүргийн эрх / барьцаалуулагч төдийгүй гуравлагч этгээдийн хууль бус үйлдлээс хамгаалах зайлшгүй шаардлагаас урган гарсан юм. Үүнээс үндэслэн барьцааны харилцааны эд юмсын эрх зүйн орчны тухай биш эд юмсын эрх зүйн хамгаалалтын зарим аргын тухай хэм хэмжээ нь барьцааны харилцаанд хамаардаг тухай ярьж болох юм хэмээн Витрянский өөрийн дүгнэлтийг хийжээ.

Барьцааны эрхийг эд юмсын эрх гэж үздэг эрдэмтдийн аргумент дотроос Шершеневичийн бусдын эд юмсын хувьд эдлэх эрх болох барьцааны эрхийн 3 шинж чанараас эхний хоёрыг нь үгүйсгэх үндэслэл тун бага байна. Энэ нь барьцааны зүйлийн өмчлөл шинжсэн ч барьцааны эрх хадгалагдсаар байдаг, өөрөөр

¹² Сулейманов М.К, Осипов Е.Б дурдсан бүтээл 52-53 дугаар тал

¹³ Витрянский В.В, Брагинский М.И. Доказательство право. М., 1998. 404 дүгээр тал

хэлбэл барьцааны эрх нь эд юмсаасаа салшгүй байгааг тодорхойлдог шинж, нөгөөтэйгүүр барьцааны зүйл нь барьцаалагчийн өөрийнх нь өмч байж болдоггүй, барьцаалсан эд хөрөнгийг барьцаалагч өмчлөн авбал барьцааны эрх дуусгавар болдог, барьцаа нь бусдын эд юмсын хувьд эдлэх эрх гэж Шершеневич үзсэн явдал юм.

Барьцааны эрх зүй нь эд юмсын эрх гэдгийг нотлох өөр нэг үндэслэл байна гэж бид үзэж байна. Барьцаа нь зөвхөн үүрэг гүйцэтгүүлэгч ба үүрэг хүлээгч хоёрын хоорондын гэрээ, үүргийн эрх зүйн асуудал төдийгүй бусад нэхэмжлэгч, оролцогчдын хувьд хамааралтай байдаг эд юмсын эрх мөн. Учир нь үүрэг хүлээгчийн нэхэмжлэгч нарын хувьд барьцаалагчийн тэргүүн ээлжинд нэхэмжлэлийнхээ шаардлагыг хангуулах давуу эрхийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй. Энэ нь ялангуяа үл хөдлөх эд хөрөнгийн тухайд илүү тод илэрч, үл хөдлөх эд хөрөнгө барьцаанд байгаа гэдгийг иргэний эрх зүйн харилцаанд оролцогчид бүгд хүлээн зөвшөөрч, барьцаалагчийн эрхийг хүндэтгэхээс өөр гарцгүй байдалд хүргэдэг.

Тэгээд ч эцэс төгсгөлгүй үргэлжилж байгаа энэ маргааны эцсийн шийд нь үүрэг хүлээгчийн эрхийг барьцаагаар хангах эрх зүйн хамгаалалтын чанарт нөлөөлөхгүй. Энэ талаар иргэний эрх зүйн хууль тогтоомж зохих шаардлагад нийцэхүйц түвшинд хүрч хөгжсөн, хөгжсөөр ч байна. Харин барьцааны эрх нь үүргийн эрх үү эд юмсын эрх үү гэдэг асуултын хариулт нь гагцхүү Иргэний хуулийн бүтэц, энэ асуудлыг аль хэсэг бүлэгт байрлуулах вэ гэдэгт л нөлөөлөх ач холбогдолтой гэж үзэж байна.

Монгол Улсын Иргэний хуулийн шинэ төслийг боловсруулж байгаа ажлын хэсэг барьцааны эрх нь үүргийн гүйцэтгэлийг хангахад чиглэсэн эд юмсын эрхийн хэлбэр хэмээн үзсэн юм. Иймд барьцааны талаархи зохицуулалтыг үүргийн гүйцэтгэлийг хангах аргын талаар заасан хэсэгт бус, эдийн болон эдийн бус баялгийн хэсэгт оруулсан нь төсөл дээр ажиллаж байгаа хэдэн хүний санаанаасаа зохиосон зүйл бус, үе үеийн цивилистүүдийн маргасаар байгаа асуудлын нэг бөгөөд бид түүнээс "Барьцаа бол эд юмсын эрх" гэж үзэж байгаагаа болон шинээр Монгол Улсын Иргэний хуульд тусгагдаж байгаа эдийн болон эдийн бус баялгийн эрх зүйн зохицуулалтыг эхнээс нь аль болох цогц

байдлаар тодорхойлохыг хичээсэнтэй холбоотой гэдгийг дурьдах юун.

СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭГЧДИЙН УЛС ТӨР, ЭРХ ЗҮЙН ФИЛОСОФИ СЭТГЭЛГЭЭНИЙ ХӨГЖЛӨӨС

/цуврал лекц/

Дагдангийн ОТГОНТУЯА

Хууль зүйн магистр

XII-XVIII зуун бол нийт Европ дахины соён гэгээрлийн үе байлаа. Учир нь энэ үед нийгэм соёлын шинжлэх ухаан шинэ голдролоор улам боловсронгуй болон хөгжиж, хүн төрөлхтний оюуны сод оргил болсон бүтээлүүд туурвигдажээ. Мөн өгүүлэн буй үед улс төр, эрх зүйн талаарх янз бүрийн үзэл онол боловсрогдон гарч, их сэтгэгчид өөрсдийн үзэл бодлоо дэвшүүлэн тавьж байв.

Тухайн үеийн соён гэгээрүүлэгчид нь нийгэм-улс төрийн дэвшилтэт хөдөлгөөний төлөөлөгчид байсан ба тухайн нийгэмд ноёрхон байсан бурангуй байдлын эсрэг шударга ёс, тэгш байдлыг илэрхийлсэн үзэл санаа, шинжлэх ухааны мэдлэгийг дэлгэрүүлэх замаар тэмцэж байжээ.

Нийгмийн бүдүүлэг харанхуй байдлыг гэтлэн үнэн зөв мэдлэгийг тараах, хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүндийг хүндэтгэх үзэл дээр үндэслэсэн нийгмийн үнэт зүйлсийг амьдралд нэвтрүүлэх нь тэдний гол зорилго байв.

Соён гэгээрүүлэгчдийн гол төлөөлөгчид нь Францын сэтгэгч ВОЛЬТЕР, Ж.Ж.РУССО, Ш.Л.МОНТЕСКЬЕ, Якобинчуудын удирдагч Ж.П.МАРАТ, М.РОБЕСПЬЕР, социалист МОРЕЛЛИ, Г.МАБЛИ, Г.БАБЕФ, Германы Х.ТОМАЗИЙ, С.ПУФЕНДОРФ, Х.ВОЛЬФ, Г.Э.ЛЕССИНГ, Италийн Ж.ВИКО, Ч.БЕККАРИА зэрэг сэтгэгчид байсан бөгөөд тэдний гэгээрүүлэгч үзэл санаа нь тухайн үед гарч байсан хөрөнгөтний хувьсгалуудын үзэл суртлын зэвсэг нь болж байсан юм.

ЖАН ПОЛЬ МАРAT /1743-1793/ нь Якобинчуудын удирдагчдын нэг байсан ба 1793 оны 6 дугаар сард болсон Жирондистуудаас засгийн эрхийг булаан авсан бослогыг М.Робеспьертой хамтран толгойлжээ.

Түүний гол бүтээл нь "Боолчлолын гинж" /1774/, "Эрүүгийн хууль тогтоомжийн төлөвлөгөө" /1780/ зэрэг зохиолууд бөгөөд

эдгээр бүтээлдээ дарангуйлал, түүний эх үндэс, эзэрхэг засаглалыг тогтоогч арга хэрэгсэл, үр дагавар, түүнтэй тэмцэх хэлбэр, арга зам зэрэг асуудлыг хөндсөн байна.

Маратын үзсэнээр эзэрхэг ёс нь хүнд заяагдсан засаглах хүсэл зоригоос үүдэлтэй, хувь хүний тэргүүлэгч байх гэсэн эрмэлзлэлээс болж улам бүр осөн нэмэгддэг. Засаглах хүсэл нь хүний зүрхэнд хэзээнээс байдаг ба энэ нь засаглагчдын эрх мэдлээ буруугаар ашиглахын үндэс, мөн хүмүүсийн хоорондох боолчлолын эх үндэс нь ажээ.

Тэрээр төрийн үүслийг "төр нь үүслийнхээ хувьд ихэвчлэн хүчирхийллээс төрдөг ба түүнийг үндэслэгч нь ихэнх тохиолдолд ямар нэг "азтай дээрэмчин" байдаг" гэж үзэж байсан ба түүний энэхүү үзэл нь тэр үеийн гэгээрүүлэгчдийн төрийн үүслийн талаарх гэрээний онолтой зөрчилдөж байсан ч тэрээр дараагийн бүтээлдээ дээрх онолыг хүлээн зөвшөөрсөн байдаг. Энэ талаар "гишүүд хоорондоо гэрээ байгуулах нь зайлшгүй. Энэ гэрээний үндэс нь тэгш эрх, хоёр талын ашиг сонирхол, харилцан туслалцаа байх ёстой" гэж бичиж байв.

Сайн зохион байгуулагдсан төрийг байгуулахын тулд түүний эрх мэдлийг олон тооны албан тушаалтны дунд хуваарилах ёстой. Ард олноо төлөөлөн ажиллаж байгаа эдгээр эрх мэдэлтнүүд бие биеэс үл хамааран оршивч нэг нэгийгээ тогтоон тэнцвэржүүлдэг байх учиртай. Энэ төрд дээд эрх мэдэл бүх ард түмэнд оногдоно. Ард түмэн хаана бие даан оршиж байна, тэнд аз жаргал байдаг хэмээн үзжээ.

Марат хүний төрөлхийн ба иргэний эрхийг ялган үзсэн. Хүний төрөлх эрх нь анхдагч бөгөөд түүнээс иргэний эрх нь урган гардаг гэжээ. Тэрээр Үндсэн хууль болон "Хүний болон иргэний эрхийн тунхаглал"-ын төсөл бэлтгэх ажилд оролцохдоо "хүмүүсийн харилцаан зөвшөөрсөн эрх нь төрөлх эрхээс үүсэлтэй. Түүнийг нийгмээс тогтоох ба нийгмийн гэрээний агаар үл зөрчилдөх ариун дархан шинжийг олдог" гэж зөвлөж байжээ.

Маратын бичсэнээр деспот дэглэмийг халах эцсийн найдвар нь нийтийн хөдөлгөөн, ард олны бослого, тэмцэл, эх оронд дайсагнагчид, төрийн эрх мэдлийг хэтрүүлэгчдийг нухчин дарах явдал хэдий ч сайн зохион байгуулагдаагүй эсэргүүцлийн хөдөлгөөн нь үймээн, самууныг л төрүүлэх ба энэ нь ямар ч үр

дүнгүй, хялбар дарагддаг. Ийм үр дүнд хүргэхүйн тулд ард олныг тэдний дарлагчид руу хандуулах зоригтон нь цэцэн, шалгарсан ухаантай, олон түмнийг удирдаж, чиглүүлж чаддаг байх ёстой гэжээ.

Маратын үзлийн гол ач холбогдол нь ард түмний тусгаар тогтнол, төрийн эрх мэдлийг хуваарилах зарчим, төрийн удирдлагын механизм дахь дэмжлэгийн болон хяналтын тогтолцоог байгуулах тухай, хүний эрхийн тухай, хувьсгалыг удирдагч хувь хүнийг аюулгүй байдал, эрхийн баталгаа зэрэг асуудлуудыг бүхэлд нь авч үзсэнд оршино.

МАКСИМИЛИАН РОБЕСПЬЕР /1758-1794/ нь Францын соён гэгээрүүлэгч, улс төрийн зүтгэлтэн бөгөөд тэрээр төрийн онол, эрх зүйн философийн хөгжилд үнэтэй хувь нэмрийг оруулсан юм. Тэрээр бусад сэтгэгчдийн адил бие даасан тодорхой зохиол бүтээл туурьваагүй ч "Үндсэн хуулийн тухайд"/1793.05.10/, "Хувьсгалт удирдлагын зарчмын тухай"/1793.12.25/, "Улс төр, зан суртахууны зарчмын тухай" /1794.02.05/ гэх мэт ард нийтэд хандан хэлсэн үгнүүдэд нь түүний үзэл бодол илэрхийлэгдсэн байдаг. Тэрээр зөвхөн 1789-1794 оны хооронд нийтэд хандан 600 гаруй удаа үг хэлсэн байна.

Робеспьерийн үзлийн гол цөм нь үлгэр жишээ жижиг хөрөнгөтний байгуулал, өөрөөр хэлбэл жижиг үйлдвэрлэгчдийн нийгэм ажээ. Энэ нийгмийн үед ард олон, хүн бүхэн газар, зохих хэмжээний урлантай, өрх гэрээ өөрөө тэжээн тэтгэх чадвартай, хийж бүтээсэн илүүдэл нөөцөө бусадтай чөлөөтэй солилцох чадвартай байна.

Түүний улс төр, хууль зүйн нэгдмэл үзлийн гол асуудал нь төрийн засаглалын тухай, төрийн байгуулал, түүний үйл ажиллагааны зарчмын тухай асуудал байв. Түүнийхээр улс төрийн нэгдлийн үндэс нь:

1. Иргэдийн жам ёсны эрхийн хангалт ба хамгаалалт;
2. Хүмүүсийн төрөлхийн тэгш байдал, эрх чөлөөн дээр тулгуурласан төрийн удирдлагад иргэн болгон оролцох эрх;
3. Төрд ард түмний засаглал тэргүүлэгч байх гэсэн 3 нөхцөлд тулгуурлана.

Ард түмэн ямар ч үед өөрсдийн хувь заяаг шийдэх эрхтэй байх ёстой. Хэрэв нийгмийн нэг гишүүний дарлал мөлжлөгөн дор

байвал нийгэм бүхэлдээ дарлагдаж байгаа гэсэн үг. Дарлал хүчирхийллийн эсрэг тэмцэх хүний эрх нь жам ёсны эрх бөгөөд энэ нь хэзээ ч зөрчигдөх ёсгүй хэмээн тууштай үзэж байснаараа ард олны дунд түүний нэр хүнд үлэмж өсжээ. Ийнхүү Робеспьерийн дэвшүүлсэн дарлал мөлжлөгөөс ангижирснаар нийгэмд эрх чөлөө ноёрхдог гэсэн ард түмний тусгаар байдлын тухай сэдэв нь тухайн үеийн улс төрийн үзэл санаанд дэвшилтэт алхам болсон юм.

Робеспьер нийтийн засаглалыг хэрэгжүүлэх ганцаар дарангуйлал захирах арга хэрэгслийн эсрэг үзэл баримталж байв. Тэрээр "Үндсэн хуулийн тухай" хэмээх хэлсэн үгэндээ хууль тогтоох байгууллагуудыг засаг захиргааны аппаратаас бүрэн салгаж, эрх мэдэлтнүүдийн бүрэн эрхийн хугацааг богиносгох талаар авч үзэх, тэднийг ард олны дундаас сонгож байх зэргээр засаглалын хуваарилалт гүйцэтгэлийг конвентод уриалж байжээ.

"Хувьсгалт засгийн газрын зарчмууд"-ын талаар хэлсэн үгэндээ тэрээр 2 төрлийн Засгийн газрын ялгааг гаргаж тавьсан. Үндсэн хуулийн Засгийн газрын зорилго нь нэгэнт байгуулагдсан төр улсыг тогтоон барих, хувь хүмүүсийг нийтийн засаглалаас тогтоогдсон эрх хэмжээгээ хэтрүүлэхээс сэргийлэх зэрэг үндсэндээ иргэний эрхийн асуудлаар хөөцөлддөг бол хувьсгалт Засгийн газар нь ширүүн тэмцлийн нөхцөлд ажиллахаар зориулагдсан бөгөөд хувьсгал хийх гол зэвсэг, түүний шууд үр дүн гэжээ. Түүнийхээр хувьсгал гэдэг нь дайсны эсрэг хийсэн эрх чөлөөний дайн ажээ.

Хүмүүс хэдийгээр байгалиас заяагдсан зан төрхөөрөө Үндсэн хууль болон төрд захирагддаг ч ухамсарт үйл ажиллагаатай, сэтгэхүйт амьтан болохын хувьд төртэй тэрсэлдэж, түүний хуулийг зөрчих явдал олонтаа. Түүнийг тэр болгон эв зүйгээр зохицуулах боломжгүй. Иймд зарим тохиолдолд хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх аргыг төрийн үйл ажиллагаанд хэрэгжүүлж болно гэж үзэж байв.

Робьестрийн энэ мэт үзэл нь улс үндэстнийг хүчирхийллийн замаар шударга нийгэмд шилжүүлж, дээрх аргыг ирээдүйд Үндсэн хуульт төр улсад хэрэглэх боломжийг үгүйсгээгүй юм.

АФОРИЗМ

* Шударга хүнийг хойшид ч шударга байх хүсэлтэй байлгахын тулд түүнд ихийг төлөх хэрэгтэй.

С.ЛЕЦ

* Өөрийгөө бүхнээс илүү зальтайд тооцох нь хууртагдах найдвартай шинж.

ЛАРОШФУКО

* Спартчууд нарийн аргаар хийсэн хулгайг үнэлдэг байсан бол одоо цагт загалмайтнууд ихээр хийсэн хулгайг хүндэлдэг болжээ.

Г.СПЕНСЕР

* Хайр дурлалыг гурвантаа хулгайч гэж хэлж болно. Яагаад гэвэл тэрээр унтахыг мэддэггүй, үлэмж зоригтойн зэрэгцээ бид бүгдийг цурви нүцгэн үлдээдэг.

ДИОФАН

* Бүх хүнийг шударгад тооц, гэхдээ тэдэнтэй зальтан шиг харьц

Ж. МАЗАРИН

* Буянгүй бузар гэж үгүй, бузаргүй буян гэж үгүй /Баян хүний үрэлгэн байдал нь ядуу хүний хийххулгай /

П.БАУСТ

* Зальт этгээдийг төгс шударга хүн мэт санагдуулах найдвартай боловч чамгүй үнэтэй нэг арга бий. Энэ нь түүнд зуун мянгыг жилийн орлого болгон өгөх явдал юм.

П.ЛЕВИС

* Зуун мянгыг зүгээр аваад зальтай гэж хэлүүлэх боломж тохихоод түүний талыг аваад шударга хэвээр үлдэх нэгээхэн ч хүн энэ хорвоод олдохгүй болов уу.

Г.ЛИХТЕНБЕРГ

* Баяжаад байгаа хүний хүү нь шударга хүн болж болох юм. Харин хүргэн нь хэзээ ч үгүй гэдэг.

Ж.НАРРЕЙ

* *Бусдын санаа бодлыг хулгайлах нь мөнгийг нь цалмсноос ч илүү гэмт хэрэгт ямагт тооцогдоно .*

ВОЛЬТЕР

* *Хамгийн булхай зүйл бол хуурамч чекээр, хуурамч мөнгө авах явдал юм. /Мэхт мэхэндээ/*

Р.ГОМЕС

* *Хулгайч хулгайчийгаа, чоно чоныгоо мэддэг. Харин загасчин загасчнаа холоос хардаг.*

ЭРАЗМ РОТТЕРДАМСКИЙ

* *Ялаа барьсан аалзхан үүгээрээ бахархана. Өөр нэг нь бүжин барьснаараа, нөгөө нь жаргахай шүүрдснээрээ, эсхүл бодон, том баавгай барьснаараа сэтгэл нь тэнийнэ. Тэдний хийсэн үйлдлийг төлөвлөсөн бодол санааг нь ойлгож чадвал тэд дээрэмчид били гэж үү.*

МАРК АВРЕЛИЙ

* *Хулгай хийх боломж хулгайчийг бий болгодог.*

Ф.БЭЖОН

* *Дээрэмчин хэтэвчийг эсхүл амийг нэхдэг. Харин эмч хэтэвчийг амьтай хамт авдаг.*

В.ШЕКСПИР

* *Би соёлт эртэй хоёр дахин илүү соёлтой харьцаж, залилан мэхлэгч эрийг хоёр дахин илүү залилахыг эрмэлздэг.*

БИСМАРК

* *Бусдыг хуурах нь эцсийн бүлэгт өөрийгөө хуурч эхлэдгээрээ аюултай.*

Э.ДУЗЕ

* *Чи өөрийгөө хуурсан шиг хэн чамайг байнга ийн хуурах вэ?*

Б.ФРАНКЛИН

- * *Нэгэн цагт Демосфенд баригдсэн хулгайч эр "Үүнийг би таных гэдгийг мэдээгүй шүү дээ" гэхэд тэрээр "Гэхдээ өөрийнх тань биш гэдгийг та мэдэж байсан шүү дээ" хэмээн харуулжээ.*

ДЕМОСФЕН

- * *Хэрэв зээ залилан мэхлэгч нар шударгуу байхын давуу талыг мэддэгсэн бол ашиг хонжооны хойноос бусдыг мэхлэхээ болихсон.*

Б.ФРАНКЛИН

- * *Хаягдал бус эд зүйлийг авахыг хулгай гэнэ.*

В.КРОТОВ

- * *Хаанаас ч хамаагүй өөрийнхөө юмыг олоод авчихдаг хэргээ өөрийн нь халаасанд өөрийнх нь юм байдаггүй хүн бол хулгайч юм.*

П.ДЕКУРСЕЛЬ

- * *Долдой хүн бол баг өмссөн хулгайч болой.*

У.ПЕНИ

- * *Эх орноо хамгаалах зоригийг гавъяад, дээрэм хийх зоригийг нүгэлд тооцох.*

А.А.БЕСТУЖЕВ-МАРЛИНСКИЙ

- * *Шийтгэлгүй өнгөрөхөөс илүү хүнд шийтгэл үгүй.*

РАКУТАГАВА

- * *Өөрийн биеийг засаж үл чадагч хүмүүн бусдыг засах нь үгүй.*

СЕНЕКА

- * *Буруугаа хүлээх нь засрахын эхлэл.*

СЕНЕКА

- * *Гэмт хэрэгтэн ял шийтгэлээс мултарч болох ч шийтгэлээс айх*

айдсаас хэзээ ч мултарч чадахгүй.

СЕНЕКА

* *Гэмт хэрэгтнийг өршөөх нь шударга нэгэнд гэм учруулахтай утга дүйнэ.*

СЕНЕКА

* *Гэмт хэрэг үйлдэх тэрхэн агишинд шийтгэл зүрхэнд нь шигддэг юм.*

ГЕСИОД

* *Санаа муутыг шийтгэл тойрон өнгөрөх нь үгүй, харин шийтгэхээс түр азнасхийж болох юм. Бурхан тэнгэр шалмаг биш ч мэргэн шүү дээ.*

П.СИР

* *Зөвхөн хийсэн хэргийн нь төлөө төдийгүй завдсаны нь төлөө шийтгэх хэрэгтэй.*

П.КОРИНФСКИЙ

* *Тохиолдлын зүйл гэж үгүй. Хөрвөөгийн юмс үзэгдэл нь сорилт, эсхүл шийтгэл, нөгөө бол шагнал байдаг.*

ВОЛЬТЕР

* *Алуурчинг тарчлаан зовоох нь бага хүүхэд тээглэн унасан сандлаа хий л нүдэхтэй адил мэт.*

ЛИХТЕНБЕРГ

* *Шийтгэл бус харин гэмт хэрэг ичгүүртэй.*

И.ГЕРДЕР

* *Гэм буруутны эхний шийтгэл бол хүн чанарын өмнө буруугаа хүлээх.*

ЮВЕНАЛ

* *Гэмт хэрэгтэй тэмцэх арга нь шийтгэл, ёс жаягыг өөрчлөх арга нүүлгэрлэл.*

Ш.МОНТЕСКЬЕ

- * *Сайныг дагаад саар болсон мунхаг үгүй.*

В.Г.БЕЛИНСКИЙ

- * *Би ташуурын ганихан үйлдлийг ажиглав. Тэр зүрх сэтгэлийг нэг бол хөргөж, нэг бол догшруулдаг ажээ.*

М.МОНТЕНЬ

- * *Зөвхөн нэг удаа ташуурдуулах ялтай этгээдийг хоёр удаа бүү цахь.*

- * *Хүнийг амьдралд барьц алдснаар нь бус цаашид хөлөө олсноор нь хэмждэг.*

Д.КРАЗЕ

- * *Төр буй цагт шийтгэл буй*

Чжуан-цзы

- * *Цаазыг баячууд бичиж, шийтгэлийг үгээгүйчүүд эдлэдэг.*

Армены зүйр үг

- * *Биеийг минь эрүүдэн шүүвч, сэтгэлд минь хүрч эс чадна.*

АПОКРИФЫ МАККАВЕЕВ.

- * *Чамайг үзэн ядсандаа бус хайрласандаа шийтгэж байна.*

Латины зүйр үг

ШИХИХУТУГ
ЭРХ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ОНОЛ,
АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ

Гурав дахь жилдээ
1/2001

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН АСУУДАЛД

АГУУЛГА

- | | |
|--|----|
| 1. Д.Лүндээжанцан
“Төрийн эрх мэдэл хуваарилах үндсэн хуулийн үзэл
баримтлал” | 4 |
| 2. Ж.Бямбаа
“Төслийг улам төгөлдөр болгоё” | 21 |
| 3. С.Жанцан
“Гэмт хэрэгт хамтран оролцохын онол, практикийн зарим
асуудал” | 27 |
| 4. Ч.Баяртуул
“Хорих ял” | 46 |
| 5. Ц.Цэлмэг
“Монгол Улсын хууль сахиулах байгууллагуудын тогтолцоо,
түүнийг боловсронгуй болгох зарим асуудал” | |
| 6. Д.Дүгэржав
“Барьцааны эрх зүйн орчны тухайд” . . . | |
| 7. Д.Отгонтуяа
“Соён гэгээрүүдэгчдийн улс төр, эрх зүйн философи
сэтгэлгээний хөгжлөөс” . . . | |
| 8. Афоризм . . . | |
-

Эрхлэн гаргасан
“ШИХИХУТУГ”
ХУУЛЬ ЗҮЙН ДЭЭД СУРГУУЛЬ

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИ

Ерөнхий редактор

Данзангийн ЛҮНДЭЭЖАНЦАН

Редакцийн гишүүд

Галдангийн СОВД
Жигжидийн БОЛДБААТАР
Чимидийн ЭНХБААТАР
Жамсрангийн БЯМБАДОРЖ
Жаргалантын ЭЛБЭГСАЙХАН
Бирваагийн МАНДАХБИЛЭГ
Түдэврэнчингийн БАЯРМАА

Нарийн бичгийн дарга

Чимэд-Очирын БАЯРТУУЛ

Хаяг:

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, Сөүлийн гудамж,
“Шихихутуг” ХЗДС-ийн байр,
Утас: 323392, 320176
Факс: 976-11-323392

Жилд 4 дугаар хэвлэгдэн гарна.
Улсын бүртгэлийн дугаар 173

“Мөнхийн үсэг”
хэвлэх үйлдвэрт хэвлэв.